



2019 ОНЫ МОНГОЛ-ЯПОНЫ ТӨВИЙН ЯПОН ДАХЬ ДАДЛАГА СУРГАЛТЫН ТАЙЛАН

2019.09.01-2019.09.14

Улаанбаатар хот
2019 он

ГАРЧИГ

1. Сургалтын талаарх товч танилцуулга
2. Бизнесийн үндсэн сургалтын төгсөгч
 - 1) М.Баярмагнай
 - 2) Д.Бундхорол
 - 3) Д.Тодрол
 - 4) Ц.Саранцэцэг
 - 5) Б.Чинзориг
 - 6) Д.Ганбат
 - 7) Д.Ганхуяг
 - 8) Т.Солонго
 - 9) Г.Ганбаяр
 - 10) Л.Гэрэлмаа
 - 11) Ч.Халтмаа
 - 12) А.Уянга
 - 13) Д.Уянга
 - 14) Д.Бат-Эрдэнэ
 - 15) О.Сэндэгмаа
3. Загвар аж ахуйн нэгж компани
 - 16) Б.Хулан
 - 17) Ц.Дагийсүрэн
4. Хамтын ажиллагаатай байгууллагын төлөөлөл
 - 18) Н.Дамдиндорж
5. Монгол-Японы төвийн мэргэжилтэн
 - 19) О.Баярмаа
 - 20) С.Амарбаясгалан

Япон дахь дадлага сургалтын талаарх товч танилцуулга

Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд 2002 оноос эхлэн Бизнесийн үндсэн сургалтыг 18 дахь жилдээ зохион байгуулж байна. Тус сургалтад 2018 оныг хүртэл давхардсан тоогоор нийт 900 гаруй жижиг дунд аж ахуй нэгжийн удирдлага болон менежерүүд суралцаж төгссөн.

Бизнес сургалтын төгсөгчдийн туршлагаас харахад сургалтаар сурсан зүйлээ бодитоор хэрэгжүүлэхээр хичээл зүтгэл гарган ажиллаж байгаа боловч төдийлөн үр дүнд хүрч чадахгүй байх нь олонтой учир Япон маягийн менежментийн хэрэгжүүлэлтийг Японы компаниудын бодит байдлыг харж, сонсож суралцах нь илүү үр дүнтэй хэмээн энэхүү дадлага сургалтыг санаачлан зохион байгуулж эхэлсэн билээ. Бизнес эрхлэгчдэд Япон компаниудын бодит байдалтай биечлэн танилцаж, бид ямар түвшинг зорих ёстой вэ гэдэг загвар жишгийг нүдээр харж мэдрэн, туршлагаас нь суралцсанаар компаниудын үр ашигтай зохион байгуулалт шийдвэр гаргалтад нөлөөлж, улмаар энэ нь бизнес сургалтын үр дүн жинхэнэ утгаар хэрэгжиж, Монголын жижиг дунд бизнес цэцэглэн хөгжихөд дорвитой хувь нэмэр болно гэж үзэж байгаа юм.

Энэхүү сургалтаар дамжуулан олж авсан мэдлэг туршлагаа үр дүнтэй ашиглах талаар ажлын төлөвлөгөөг заавал боловсруулах бөгөөд сургалтын дараа ажлын төлөвлөгөөгөө бусадтай хуваалцах зорилгоор энэхүү тайланг бэлтгэн дараа дараагийн суралцагчиддаа танилцуулж байна.

Энэ удаагийн сургалт дараах агуулгаар явагдаж дууслаа.

1) Сургалтын талаарх товч танилцуулга

Сургалтын нэр: Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх дадлага сургалт

Сургалтын хугацаа: 2019.09.01 (Ням) - 09.14 (Бямба) 2 долоо хоног

Сургалтын зорилго, агуулга:

1. Япон байгууллагуудтай танилцаж, тэдгээрийн удирдлага, боловсон хүчнүүдтэй уулзаж ярилцсанаар Монгол-Японы төвийн сургалтаар суралцсан Япон маягийн менежментийн талаарх ойлголтоо гүнзгийрүүлж, өөрийн байгууллага дээр удирдлагын сайжруулалт хийхэд тус болохуйц мэдлэг, мэдээллийг олж авах.
2. Үйлдвэрийн удирдлага болон оффис ажлын менежментийн талаарх мэдлэгээ гүнзгийрүүлэх.
3. Маркетинг болон брендинг менежментийн аргын талаар мэдлэгээ гүнзгийрүүлж, өөрийн байгууллагын үйл ажиллагаанд үр дүнтэйгээр ашиглах.
4. Үйлчлүүлэгчдийг сэтгэл ханамжтай байлгахын тулд үйлчилгээгээ сайжруулах, үйлчилгээний ажилтнуудаа хөгжүүлэх зэрэг менежментэд шаардлагатай мэдлэгийг олж авах.
5. Бизнесийн хамтын ажиллагааны уулзалт, семинарт оролцож, Японы бизнес эрхлэгчидтэй санал бодлоо солилцон, өөрийн компанийг сурталчлах боломжийг эрэлхийлэх.
6. Тус сургалтаар олж авсан мэдлэгээ өөрийн байгууллага дээр амжилттай хэрэгжүүлэхийн тулд Action plan боловсруулах.

2019 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

Нэр: М.Баярмагнай

Албан тушаал: Ахлах инженер

Үндсэн сургалт төгссөн он: 2019



| | |
|-------------------------|---|
| Компанийн нэр: | МЯК ХХК |
| Байгуулагдсан он: | 2004 |
| Үйл ажиллагааны чиглэл: | <ul style="list-style-type: none"> • Бизнесийн зөвлөгөө өгөх • Аялал жуулчлал • Гадаад худалдаа • Мод, модон эдлэлийн үйлдвэрлэл худалдаа • Барилгын засвар хийх • Барилгын материалын худалдаа • Худалдааны зуучлал |
| Ажилчдын тоо: | 12 |

Компанийн товч танилцуулга

Монгол Японы хамтарсан “МЯК” ХХК нь 2004 онд байгуулагдсан бөгөөд Япон архитекторын удирдлага дор мэргэшсэн дизайнер, туршлагатай инженер техникийн ажилчдаар баг бүрдүүлж ажиллаж байна. Бид үйлчлүүлэгчийн нэр хүнд бизнесийн онцлогийг илэрхийлэх, тав тухыг хангах дизайны дахин давтагдашгүй орон зай, шийдлийг цаг хугацаа, хэрэглээний явцад чанараа үл алдах бат бөх, гоёмсог материалаар ур ухаан шингээж гүйцэтгэдэг.

Бидний зорилго бол захиалагчийн хүсэлтийг **100%** биелүүлэхэд оршино.

ХУГАЦАА, ЧАНАР, БАТАЛГАА, ҮЙЛЧИЛГЭЭ**Компанийн дүрмээс**

1. Та ажлыг хэн нэгнээр шаардуулах бус, **өөрөө санаачилж хий.**
2. **Бусдаас түрүүлж хөдөл.** Ажил бол бусдын эрхэнд хийдэг зүйл биш.
3. **Том ажил руу ханцуй шамлан ор.** Жижиг ажил таныг өчүүхэн болгоно.
4. **Ажлын хүнд хэцүүг сонго,** түүнийг даван туулах үед нэг алхамаар урагшилна.
5. Төлөвлөж ажилла. **Урт хугацааны төлөвлөгөө танд амжилт авчирна.**

1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

1. Компанийн үйл ажиллагааг сайжруулах
2. Ажилчдыг удирдан зохион байгуулах арга барилаас сурах
3. Шинэ мэдээ мэдээлэл авах
4. Мэдлэгийн цар хүрээгээ өргөжүүлэх

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

Менежментийн хувьд

- Хүний нөөцийн бодлогоор ажилчдаа хөгжүүлж, жил бүр сургалтад тогтмол хамруулдаг.
- Үргүй зардлыг бууруулах тал дээр байнга анхаардаг
- Компанийн одоогийн түвшинг тодорхойлж, цаашдын үйл ажиллагаанд хэрхэн өөрчлөлт хийх тал дээр ажиллаж байна.
- Талбайн 7 хоног тутмын ажлын шуурхайг тогтмол хийж хэвшиж байна.

3S нэвтрүүлэх энэ ондоо хийж эхлэхээр бэлтгэл ажлууд хийгдэж байна.

- Багт хуваагдаж төлөвлөгөө гаргах
- Гүйцэтгэлээ хянах самбар байршуулах
- Туслан гүйцэтгэгч компаниудад сургалт зохион байгуулах

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

Компанийхаа эрхэм зорилго, алсын харааг тодорхойлж түүнийгээ ажилчдадаа сайн ойлгуулах нь маш чухал гэдгийг орсон компани болгон дээр харагдаж байлаа.

- Хүнийг чухалчлах, сургалтын орчинг бий болгох
- Компанийн жилийн төлөвлөгөөг хамтран гаргах
- Ажилчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх
- Ажлын байрны эмх цэгц
- Магтаалын хуудас
- Борлуулалтын хувь хэмжээнээс хамаарсан урамшуулал
- Үйлдвэргүй үйлдвэрлэгч тогтолцоо, менежмент
- 5S кайзэн, хөтөлбөр хэрэгжүүлэхийн ач холбогдол
- Музейгээр дамжуулан компанийхаа философийг олон нийтэд таниулах, суралцах талбар болгосон байдал.

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Сургалтанд хамрагдаж явсандаа баяртай байна. Бизнесийн үндсэн сургалтад хамрагдан бизнесийн удирдлагын онолын талаарх ерөнхий мэдлэгээ бататган, сургалтаар олж авсан мэдлэг бодит байдалд хэрхэн буудаг талаар нүдээр үзсэн нь хэрхэн хийх аргачлал боломж бололцоо байдаг талаар зааж өгсөн үр дүнтэй сургалт боллоо.

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

Ажилчдын сургалт мэдлэг мэдээлэлийн тал дээр анхаарч ажиллах. Ажиллах урам зориг итгэл үнэмшлийг байнга мэдрүүлж байх.

Компаний дотоод журам буюу соёл

Ажлын байрны сайжруулалт

6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)

1. Шинэ ажилтны дасан зохицох хөтөлбөр
2. Сайжруулалт Кайзэн, 3S нэвтрүүлэх бэлтгэх хангах, нэвтрүүлж эхлэх
3. Ажилтан бүр нэг талбай дээрээс нэг шинэ санаа

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Цаг барилт, бусдад хүндэтгэлтэй хандах
- Хичээлдээ анхааралдаа хандаж бусдад саад болохгүй байх
- Японы соёл, уламжлал, япон хүний тэвчээртэй тууштай, үнэнч байдал, компанийн менежментийг олж харах
- Сурсан зүйлээ мартахгүйн тулд тэмдэглэл хөтлөх, зураг авч явах нь цаашид хэрэглэхэд хялбар байх болно.

2019 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

Нэр: Д.Бундхорол
Албан тушаал: Захирал
Үндсэн сургалт төгссөн он: 2019



| | |
|--------------------------------|-----------------|
| Компанийн нэр: | Вортекс ХХК |
| Байгуулагдсан он: | 2012 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Барилга угсралт |
| Ажилчдын тоо: | 30 |

Компанийн товч танилцуулга



“Вортекс” ХХК нь Монгол Улсын барилгын салбарт дэвшилтэт технологи, өндөр чанартай ажлын гүйцэтгэх арга хэлбэрийг нэвтрүүлэх, Үндэсний хэмжээний бүтээн байгуулалтанд оролцох замаар залуу боловсон хүчнийг чадавхижуулах зорилготой үйл ажиллагаа явуулахаар 2012 онд үүсгэн байгуулагдсан үндэсний компани юм.

1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

1. Япон маягийн менежментээс суралцах
2. Бизнесийн үйл ажиллагааны хүрээгээ тэлэх

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

- Ажлын байрны сургалт зохион байгуулж эхэлсэн,
- Ажлын байранд эмх цэгц сахиулах журам хэрэгжүүлж байгаа,
- Ажил эхлэхийн өмнө өглөөний тайсо дасгал хийж заншсан.



3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

Эрхэм зорилгын зорилтоор удирдлага зохион байгуулах.

- Эрхэм зорилгын талаар нэгдсэн ойлголттой болгох чиглүүлэх сургалтыг зохион байгуулав,
- Ажил горилогчийн анкетийн асуулгыг эрхэм зорилгын зорилтод нийцүүлэн дахин боловсруулна. Ингэснээр зөв хүн зөв ажлын байрандаа тогтвор суурьшилтай ажиллаж, ажил гүйцэтгэх чадвар нь сайжирдаг байна.

Өглөөний шуурхай хурлын үр дүнг боловсронгуй болгох арга

- Ажилтнуудын илтгэх, өөрийгөө илэрхийлэх чадварыг дээшлүүлэх зорилгоор ХАБ-ын Share Case тогтмолжуулсан,
- Инженерүүдийг 1 минут 30 сек-н хугацаанд өнгөрсөн, өнөөдөр, ойрын ирээдүйд хийх ажлуудаа илтгэж сургах,
- “Бидний дууриал” магтаалын хуудсыг 7 хоног тутам ажиллуулах

3S, Кайзен үйл ажиллагааг хэрэгжүүлэх

- 3S-г байгууллагынхаа өдөр тутмын үйл ажиллагаанд шат дараатайгаар хэвшүүлэх,
- Кайзен саналын системийг нэвтрүүлэх арга ажиллагаанд суралцах,
- Ажилтнуудын үнэлгээний системийг боловсронгуй болгох, Тухайлсан ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх *Lead time* системийг сурч, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх.

Үйл ажиллагааны тоон мэдээллүүдийг тогтмол цуглуулж, шийдвэр гаргалтыг оновчтой хурдан болгох

- PDCA өдөр тутмын ажил гүйцэтгэлийн хүснэгтийг хэн ч харсан ойлгохоор энгийн хялбаршуулсан динамик хэлбэрт шилжүүлэх,
- Хүснэгтийг бүх хүнд ил харагдах газарт байрлуулан удирдлага төдийгүй ажилтнууд өөрсдийн ажилдаа дүн шинжилгээ хийх боломжоор хангах. Энэ талаар мэдээлэл хийж, сургалт зохион байгуулна.

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Япон дахь дадлага сургалтаар зочилж очсон байгууллага, хамт олон төдийгүй ажилч хичээнгүй, нягт нямбай жирийн ард түмний амьдрал ахуй, түүх соёл, уламжлалаас бүх зүйл улбаатай болохыг ойлгож тэднээс чадлын хэрээр суралцахыг хичээж явлаа.

Монголд ирсэн хойноо ажлын хамт олонтойгоо сурч мэдсэн зүйлийнхээ талаар хуваалцаж ярилцаад, бид 3S хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байна.

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

Японд дадлага сургалтанд хамрагдсаны дараа компани дээрээ танилцуулга хийхэд манай ажилтнууд **Амьдралын төлөвлөгөөний хуудас**-ыг ихэд сонирхон нааштай хүлээж авсан.

- Амьдралын төлөвлөгөөний хуудасны загварыг гаргаж батласан байгаа.
- Сар тутам ажилтнуудад үлгэр дууриал авах алдар хүндтэй хүмүүс, харилцагч банкны эдийн засагч, сургагч багш нарыг урьж лекц унших, зөвлөгөө өгөх, сургалт авах ажлыг төлөвлөгөөний дагуу эхлүүлээд байна.
- Ажиллагсдын дунд “Амьдралын төлөвлөгөөний хуудас”-ын өдөрлөг ойрын өдрүүдэд зохион байгуулагдана.

6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)

Оршин байхын боловсрол

Энэ нь миний хувьд шинэ нэр томъёолол байсан. Ойлголтын хувьд аваад үзэхэд, бидний өдөр тутмын амьдрал үйл ажиллагаанд тохиолддог ёс зүй, хандлага, суурь хүмүүжилтэй холбоотой дадлыг хүний анхан шатны суурь боловсрол юм байна. Энэ хүрээнд дараахь ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөөд байна.

- Хийж байгаа ажлаа хэрэглэгчийн өнцгөөс харж сурах сургалт зохион байгуулах
- Байгууллагад хэвтээ удирдлагын тогтолцооны шинэ хэлбэрийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байгаа. Цалинд сонгуульт ажлын урамшууллын системийг нэвтрүүлж эхэлсэн.
- Чанарын дугуйлан ажиллуулах

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Сургалтанд явахаас өмнө Японы бизнесийн орчин, ёс зүйн талаар өөрийн хэмжээнд уншиж судалж мэдээлэлтэй явмаар санагдсан.
- Компани, байгууллагадаа тулгамдаж байгаа жинхэнэ “гацаа” болдог асуудлууддаа лекц семинар дээр хичээл орсон багш, бизнесменүүдээс хариулт авах боломжтой.

2019 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

Нэр: П.Тодрол
 Албан тушаал: Үйл ажиллагаа хариуцсан захирал
 Үндсэн сургалт төгссөн он: 2019



| | |
|------------------------|---|
| Компанийн нэр | Монос Хүнс ХК |
| Байгуулагдсан он | 2012 |
| Үйл ажиллагааны чиглэл | Эрүүл мэндийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа |
| Ажилчдын тоо | 131 |

Компанийн товч танилцуулга

Монос Хүнс ХК нь 2012 оноос эхлэн бие даасан аж ахуй нэгж болон үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Монгол улсын эмийн зах зээлийн тэргүүлэгч компани болох



Монос Группийн үйлдвэрлэлийн чиглэлийн компаниудын нэг бөгөөд эрүүл мэндийн хүнсний үйлдвэрлэл, худалдааны чиглэлд үйл ажиллагаагаа явуулж байна. Компани үндсэн 6 Брэндийн 80 орчим нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд гаргаж байгаа бөгөөд Монгол улс даяар нийт 2500 орчим цэгт хүрэн ажиллаж байна. 2017 оны 11 дүгээр сараас эхлэн Олон Улсын Чанарын Удирдлагын тогтолцоо ISO 9001:2015, Хүнсний Аюулгүй байдлын HACCP стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэлсэн бөгөөд 2019

оны 10 дугаар сард Швейцарь улсад төвтэй SGS байгууллагын аудиторуудын хяналтан доор олон улсын баталгаажуулалт хийж чадсан. Мөн 2019 оны 5 дугаар сараас эхлэн компанийн

эзэмшлийн 30 олон нийтэд арилжиж зах зээл дээрээс төгрөгийг бөгөөд олон нээлттэй компани чадсан. Олон



хувийг нээлттэй хөрөнгийн 8,5 тэрбум босгосон нийтэд болж нийтээс

босгосон хөрөнө оруулалтаар эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэр барьж байгаа бөгөөд 2019 онд багтан ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

НЭГ. Бизнесийн үндсэн сургалтад суух болсон шалтгаан

1. Монгол-Япон төвийн бизнесийн үндсэн сургалтаар сурсан онолын мэдлэгийг Япон улсад хэрэгжүүлсэн байдлаар үзэж бататгах
2. Япон маягийн менежментийг ойлгох, Япон орны талаар мэдлэг мэдээлэлтэй болох

ХОЁР. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлсээ компанидаа яаж хэрэгжүүлсэн бэ? Компанид гарсан өөрчлөлт

Бизнес стратегийг төлөвлөлтийг илүү бодитой гаргах, SWOT анализийг илүү зөв, орчин үеийн



байдлаар гаргаж ашиглаж сурсан. Ингэснээр манай жил болгон уламжлал болсон Retreat арга хэмжээ маань илүү сайжирч байна.

Мөн Хүний нөөцийн хичээл дээр сурсан ярилцлагын арга техникүүдийг удирдлагуудын түвшинд тогтмол явуулж эхэлсэн. Энэ нь зөвхөн ажилд авах ярилцлага биш, ажлаас гарах үеийн, мөн ажлын явцын ярилцлагуудыг хийж хэвшээд байна. Ингэснээр хамт олны уур амьсгалыг сайжруулах, ажлаас гарч байгаа ажилтнуудын жинхэнэ шалтгааныг олж

илрүүлэх гэх мэт сайн талууд ажиглагдаж байна.

ГУРАВ. Дадлага сургалтын зорилго буюу Японоос суралцах зүйлс**Компанийн хувьд:**

- ✓ Шинэ үйлдвэр ашиглалтад оруулан үйл ажиллагаа томорч байгаа тул үйлдвэрлэлийн менежментэд нарийвчлан суралцах шаардлагатай.
- ✓ Хүний нөөц өсч байгаагаас шалтгаалж үр дүнтэй, бүтээмж өндөртэй хүний нөөцийг бүрдүүлэх шаардлагатай.
- ✓ Ажилтнуудыг хандлагыг өөрчилж өндөр бүтээмжтэй ажиллах шаардлагатай.

Хувь хүнийхээ хувьд:


- ✓ Тушаал дэвшээд удаагүй тул хүний нөөцийн удирдлагын талаар мэдлэгээ дээшлүүлэх шаардлагатай.
- ✓ Удирдагч хүн болж төлөвших шаардлагатай.
- ✓ Үйлдвэрлэлийн менежментийн практик мэдлэг, туршлага шаардлагатай.

Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйлс

1. Япон маягийн менежмент гэж юу вэ гэдэг талаар нилээд өргөн мэдлэгтэй болсон.
2. Амьдралын хэв маяг, орчин нөхцөл, хүүхдийн хүмүүжлээс нь эхлээд Япон маягийн

Япон маягийн менежмент = Япон соёл

менежментийн ойлголтуудыг суулгаж өгдөг юм байна. Цаг баримтлах, зарчимч байдал нь Япон хүний давтагдашгүй онцлог юм.



3. Бизнесийн онолд win-win зарчмыг нилээд ярьдаг боловч сүүлийн үед Японы бизнесийн ертөнцөд All-win зарчмыг ярих болжээ. Энэ нь үйлдвэрлэлийн процесстoo бэлтгэн нийлүүлэгчдээ болон хэрэглэгчдээ бүгдийг нь хамруулж ойлгох талаар онол юм. Ингэснээр хэрэглэгчид

Хэрэглэгчийн сэтгэл ханамж




Ажилтны сэтгэл ханамж

болоод бэлтгэн нийлүүлэгчид, мөн ажилтнууд,

хувьцаа эзэмшигчид ч гэсэн ашигтай байж бүгд хожих зарчим үйлчилнэ гэсэн үг юм.

4. Дэлхийд үйлдвэрлэлийн менежментээр гайхагдсан Тоёота-ийн үйлдвэртэй танилцаж энэхүү амжилтад хүрсэн шалтгаан, үндсэн 2 тулгуур хэрхэн хэрэгжиж байгаатай танилцсан.



Мэдээж Total Product Systems-ийн бүрдэл болох Just In Time, Jidoka зарчмууд байсан юм. Монголчуудын дунд зайлшгүй хэрэгжүүлж эхлэх зарчим бол процесс хооронд алдаатай бүтээгдэхүүн дамжих учиргүй гэсэн зарчим юм.

5. Япон менежментийн тулгуур ойлголтуудыг хэрхэн амьдрал дээр хэрэгжүүлсэн байгааг очиж үзэж танилцсан. 5S хэвшүүлэхийн тулд 3S дээр хэрхэн төвлөрөх, нөхцөл байдлыг байнгын давтамжтайгаар хэрхэн сайжруулж байх хэрэгтэйг, бүтээмж өндөртэй ажлын байр бий болгохын тулд Муда-г хэрхэн тодорхойлж, арилгах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хэрхэн нэгдүгээрт тавьдаг болох вэ зэрэг асуудлуудыг үзэж танилцсан.

ДӨРӨВ. Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга. /Компани эсвэл хувь хүн/

1. Байнга давтаж сургалтууд орсоноор ажилтнуудын хандлага өөрчлөгдөнө гэж үзэж байгаа тул давтамжтайгаар сургалтууд орно. Мөн өглөөний шуурхай буюу Чойрэй-г илүү үр бүтээлтэйгээр хийж сурах нь тухайн өдрийн бүтээмж, зорилгыг ажилтнууд ойлгох сайн талтай гэж харж байгаа.
2. Япон маягийн менежментийн онцлогийг илүү ойлгож эхэлсэн тул хэрхэн монголчилж өөрсдийн хөрсөн дээр буулгах ёстой вэ гэдэг талаас нь ажлуудыг харж байна.
3. Ажилтнуудын зорилгыг компанийн зорилготой хэрхэн уялдуулах, хэрхэн сэтгэл ханамжтай ажилтнуудыг бий болгох улмаар хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх вэ гэдгийг удирдах шатандаа ярилцаж эхэлсэн.
4. Загвар аж ахуй нэгжээр сонгогдсон байгаа тул хүний нөөцийн менежментийн талаар албаны дарга дунд шатны удирдлагуудад сургалт оруулах нь зөв гэж үзсэн.

ТАВ. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

- ✓ Сургалтын хугацаа 14 хоног байсан нь бага санагдсан. Илүү хүртээмжтэй болгохын тулд 21-28 хоног болгож хамрагдах хүмүүсийн тоог цөөхөн болгох шаардлагатай гэж дүгнэсэн. Учир нь хүний тоо хэтэрхий олон болохоор цаг барих, цуглах тал дээр нилээд бэрхшээлтэй болж байсан.
- ✓ Мөн компаниудыг чиглэл чиглэлийнх нь дагуу үзэх хүсэлтэй компаниуд руу баг болгон явуулбал үр дүнтэй санагдсан. Жишээ нь: хүнсний үйлдвэрлэлийн компанийн төлөөллүүдийг нэг орчуулагчтай нь цуг sake-ний үйлдвэр, чихрийн үйлдвэр гэх мэт газрууд руу, худалдааны компанийн төлөөлөгчдийг бөөнд нь нэг орчуулагчтай нь Такашимаая, бусад их дэлгүүрүүдтэй танилцуулахаар явуулах гэх мэтээр зохион байгуулалт хийвэл илүү өгөөжтэй байх болов уу гэж бодож байна.
- ✓ Монголчуудын хувьд Жайка-ийн байранд хатуу хяналтан дор байрлах нь нилээд асуудалтай /архи уудаг, тамхи татдаг/ байхаар байсан тул манай ээлж шиг гадуур буудлуудад байрлах нь илүү үр дүнтэй байхаар санагдсан.

ЗУРГАА. Дараа жил сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйлс

“Усыг нь уувал ёсыг нь дага” гэдгийг л хамгийн сайн санах хэрэгтэй. Япон улсад мөрдөгддөг нийтлэг ёс зүй, зарчмын талаар мэдээллийг сайтар авах хэрэгтэй. Үндсэн сургалтын үеэр үзүүлдэг баримтат кинонуудыг заавал үзэх хэрэгтэй санагдсан. Япон маягийн менежментийн үндсэн ойлголтыг аваад хэрхэн Монголчилж хөрсөн дээр буулгах вэ гэдгийг илүү бодох нь зүгээр байх.

2019 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

“ЭМ ЭС ГАРМЕНТ” ХХК

Нэр: Ц.Саранцэцэг
 Албан тушаал: Захирал
 Үндсэн сургалт төгссөн он: 2019



| | |
|-------------------------|------------------------------------|
| Компанийн нэр: | “Эм Эс гармент” ХХК |
| Байгуулагдсан он: | 2017 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Савхин хувцас үйлдвэрлэл, худалдаа |
| Ажилчдын тоо: | 12 |

Компанийн товч танилцуулга

Байгалийн эрс тэрс уур амьсгалд зохицсон эдэлгээ сайтай монгол малын арьсыг дэлхийн брэнд болгохыг зорьж тус компаниа 2017 байгуулан ажиллаж байна.

Бид Дэлхийн жишигт хүрсэн боловруулалт сайтай арьсаар хэрэглэгчдийнхээ хүсэл сонирхолд нийцүүлэн үргэлж шинэлэг, үргэлж загварлаг, сэтгэлээ шингээн бүтээгдэхүүнээ урладаг бөгөөд хувь хүний захиалгаар хийхээс гадна төрийн худалдан авах ажиллагаанд оролцон хүчний байгууллагын савхин дүрэмт хувцасыг үйлдвэрлэн нийлүүлдэг.



2017 онд
 “АРЬС ШИР НООС НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН 2017”
 үзэсгэлэнгийн
 Гран-при – “Шилдэг савхин хувцас үйлдвэрлэгч”

2018 онд “Шилдэг бүтээгдэхүүн”
 (Технологи завгарын өвөрмөц шийдэл бүхий
 савхин хувцас).



Made in Mongolia



“MS garment” LLC



The Leather garments

 @msleathermongolia
 #msleathermongolia
 976-99855435

1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан


1. Аж ахуйн нэгжийг эрхлэн явуулах онолын цогц мэдлэгтэй болох.
2. Японы үйлдвэрүүдтэй танилцах,
3. ЖДҮ-ийн менежментийн арга барилтай танилцах
4. Хэрхэн яаж өсөж хөгжиж урт хугацаанд тогтвортой ажилладгийг судлах.
5. 5S-г хэрхэн хэрэгжүүлж үйлдвэрлэлийн өртгийг бууруулах

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

- 2017 оны намар “Үйлдвэрийн удирдлага” сургалтанд сууснаар 5S өөрийн үйлдвэртээ нэвтрүүлж эхэлсэн / цаашид үйлдвэрлэлийн процессыг сайжруулах/
- 2018 оны үндсэн сургалтад сууснаар хамгийн түрүүнд өндөр зардал болох ажлын байрны түрээс төлдөг байснаа өөрийн ажлын байртай болж ажилчдынхаа тохь тухыг бүрэн хангасан.
- Ажлаа төлөвлөж үр дүнг харьцуулдаг болсон.
- Санхүүгээ төлөвлөж цаашид зохистой удирдах.
- Ажилчдын цалинг салбартаа хамгийн өндрөөр өгөхөөс гадна 2019/01/01- ээс 6 төрлийн урамшуулал нэмж олгодог болсон нь ажилчдын ажлаас гарах асуудал багассан.
- Компаний хүний нөөцийн тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх /ажилд авах, сургах, чадваржуулах, мэргэшил дээшлүүлэх, хөгжүүлэх, ажлын байр дэвших/

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

Японд дадлагажих хугацаандаа удирдлага, хүний нөөц, үйлдвэрлэл гэсэн 3 өнцгөөс харж өөрийн компанид нэн тэргүүнд тусгаж авах зүйлээ онцолсон.



Удирдлагын зүгээс харахад
Осакагийн ТИС-н Минагава багшийн хэлсэнчлэн, хүн 18-60 насны ид үеэ ажлын байрандаа өнгөрөөдөг тул тэдний хийсэн бүтээгдэхүүнийг үнэ цэнэтэй зүйл болгох нь биднээс шалтгаалдаг юм байна.



Бизнест тохиолдох ямар ч бэрхшээлийг Удирдагч хүн давах сэтгэлийн хаттай байх ёстойг Ишикава Тоорү Сан-гийн: 1995 оны газар хөдлөлтөнд өртөж тэгээс биш хасахаасаа үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн амжилттай өндийж босож ирсэн туршлага.



Үйлдвэргүй үйлдвэр Гогёфүкү ХК-ийн борлуулалт менежментийн арга барилаас өөрт тохирохыг авч хэрэглэнэ гэж бодож байна

Ажилтнаа загнасан ч магтах зүйлийг олж харах нь менежментийн чухал арга барил юм байна

Бүх зүйлийг хүн хийдэг, тиймээс хүний зөв давуу талыг олж харж хөгжүүлж ажиллах нь удирдах чухал арга барил юм байна гэдгийг олж харлаа.

Өөрчлөгдөхийг би өөрөөсөө эхлэх ёстой юм байна.

Хүний нөөцийн зүгээс харахад



- “Aircon service” компанийн үүсгэн байгуулагч Иноүэ Орлого хэт хөөхөөс илүүтэйгээр ажилчдынхаа сургалт хөгжлийг чухалчлах, тэдний ур чадварыг байнга дээшлүүлж бүтээмж болон чанараа өсгөхийн чухал
- Өөртөө он удаан жил үнэнчээр ажиллаж байгаа ажилтнуудаа юуны төлөө ажиллаж буйг нь тодорхой болгох
- 10 жил ажиллаад хувьдаа гарахыг нь зөвшөөрч, менежментийн зөвлөгөө өгч хамтран ажилладаг нь зөв юм байна. Үүнийг хэрэгжүүлж ажиллана гэж бодлоо. сан –гийн

Үйлдвэрлэгчийн зүгээс харахад

- Ажлын талбар болон ажиллах хүчээр манай компанитай ойролцоо “Ямада” компаний захирал нь ажилтнуудынхаа дунд орж 3S болон ISO -г төгс болтол нь хэрэгжүүлээд бага талбайд, цөөн хүнээр, өндөр бүтээмжтэй, чанартай бүтээгдэхүүн гаргаж болдог нь дуурайн хэрэгжүүлэхэд их ойрхон санагдлаа
- Мөн КТС, Тоёота Мотомачи зэрэг үйлдвэрүүдийн 5S –ийн төгс хэрэгжилт, “Just in time”, AP компаний “ALL WIN” бизнес загвар зэрэг нь гойд анхаарал татсан.



4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

- Алсын хараа, эрхэм зорилгоо байнга сануулж үүнд багаараа хүрнэ, та бүхний оролцоо чухал үүрэгтэй
- Сурсан зүйлээ хуваалцаж бүгд нэг зүгт харах
- Ажилтан ажил олгогч бус хамтран ажиллагсад соёлыг бий болгох
- Хүнээ байнга тасралтгүй сургаж хөгжүүлэх
- Өдрийн, долоо хоногийн 5 дахь өдөр, сарын сүүлийн 5 дахь өдөр их цэвэрлэгээ
- Өөрсдийн ажлын байран дахь мудаг илрүүлэн арилгах
- Төгсгөлгүй кайзен санаа цуглуулан түүнийг урамшуулах зэргийн чухлыг ярилцаж эхнээс нь хийж эхлээд байна

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

МЯТ-д сонссон онолын мэдлэгээ Японд очиж хөрсөн дээр нь 5 мэдрэхүйгээрээ мэдэрснээр богино хугацаанд давтагдашгүй үр өгөөжтэй сургалт болсон.

- Тоёота компани - “just in time”
- “Aircon service” - хүний нөөц болон сургалт хөгжүүлэлтийн бодлого
- AP компаний - хэрэглэгчийн сэтгэл ханамж = хүлээлт – бодит байдал
- Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж = ажилчдын сэтгэл ханамж
- Ямада компаний - 3S хэрэгжилт, дамжлагын удирдлага
- КТС компаний - тогтсон байршил, тогтсон чигт, тогтсон хэмжээгээр,
- Минагава багшийн - муда болон кайзен
- Тарүмаса –н - уламжлалт органик, бүтээгдэхүүний ялгарал чухал
- Гогёфүкү - том хэмжээний харилцагчаас хараат бус, 200 гаран харилцагч хамтрагчтай байх ухаан

зэрэг нь үйлдвэрлэгчийн хувьд хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай тул эхнээс нь төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлж байна.

6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)

- Өөрчлөлтийг өөрөөсөө эхлэн байнга тасралтгүй сурч хөгжих шаардлагатай
- Хувь хүний болон ажилтнуудын зорилго зорилтыг тодорхойлуулан хяналтын хуудас хөтлүүлэх
- Хүний нөөцийг голлон анхаарч шинээр төгсөгчдийг сургаж хөгжүүлэх
- Үйлдвэрлэлийн өртгийг бууруулах
- Мэргэжилтнүүдийг урьж ажиллуулах үйлдвэрлэлийн технологи, процессыг сайжруулах
- “All win” тогтолцоог хэрэгжүүлэх арга зам судлах
- МЯТ- ийн загвар аж ахуйн нэгж болох хөтөлбөрт хамрагдах

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Цагийг баримтлан бусдыг хүндлэх
- Слайд дээрээ тэмдэглэл хөтлөж хадгалах
- Үзсэн харсан зүйлээ зурагжуулах
- Сонссон хичээлээ ажил амьдралдаа шантралгүй, тасралтгүй хэрэгжүүлж мэдлэг болгох

2019 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

Нэр: **Б. Чинзориг**
 Албан тушаал: **Ерөнхий менежер**
 Үндсэн сургалт төгссөн он: **2019**



| | |
|---|---------------------------------|
| Компанийн нэр: | “Шугам” ХХК |
| Байгуулагдсан он: | 2008 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Эрчим хүчний зураг төсөл |
| Ажилчдын тоо: | 15 |
| Компанийн товч танилцуулга | |
| <p>Шугам ХХК нь 1994 онд байгуулагдсан бөгөөд одоогоор техник эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төсөл, инженерчлэл, судалгаа шинжилгээний чиглэлээр ажиллаж байна. Уг компани нь нийтдээ 15 инженертэй бөгөөд зураг төсөл, барилга угсралтын ажил, 0.4-220 кВ дамжуулах шугамыг сэргээн засварлах, 0.1-100 МВт-ын дэд станц болон сэргээгдэх эрчим хүчний систем (нарны цахилгаан станц, усан цахилгаан станц гэх мэт), байрзүйн судалгаа, гурван хэмжээст төлөвлөлт болон инженерийн хяналт шалгалт зэргийг гүйцэтгэдэг.</p> <p>Үйл ажиллагааны үндсэн чиглэл</p> <ul style="list-style-type: none"> • Эрчим хүчний зураг төсөл <ul style="list-style-type: none"> ○ Дэд станц болон ЦДАШ-ын зураг төсөл ○ Сэргээгдэх эрчим хүчний системийн зураг төсөл ○ Реле хамгаалалт, автомажуулалт, СКАДА ○ Гэрийн автомажуулалт болон халаалтын шийдэл • Эрчим хүчний зөвлөх үйлчилгээ <ul style="list-style-type: none"> ○ Техник эдийн засгийн үндэслэл болон тооцоолол ○ Тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлт ○ Цахилгаан халаалтын шийдэл ○ Эрчим хүчний хэмнэлтийн зөвлөх үйлчилгээ • Геодези, зураг зүй <ul style="list-style-type: none"> ○ Байрзүйн дэвсгэр зураг ○ 4D Зураглал ○ 3D рендер | |

| |
|---|
| 1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан |
| <ol style="list-style-type: none"> 1. Бизнесийн удирдлагын талаар мэдлэгтэй болох 2. Санхүүгийн менежментийн онолын мэдлэгтэй болох |
| 2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт |
| <p>Компанийнхаа SWOT шинжилгээ хийсэн Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлийг дахин тодорхойлсон Компанийн дотоод орчины хүрээнд цаашид хэрэгжүүлэх ажлуудыг тодорхойлж шат дараатай хэрэгжүүлж байна.</p> |
| 3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл |
| <p>Ямада Сэйсакушо <i>Мөрдөх зүйлээ шийдэж, шийдсэн зүйлээ мөрдөх</i> 3S бол үйл ажиллагаа тиймээс ангилж ялгах, эмхэлж цэгцлэх, цэвэрлэх үйл ажиллагааг ягштал биелүүлбэл үлдсэн 2S нь аяндаа бий болно. 3S нь Байршлын 3S, Эд зүйлсийн 3S, Мэдээллийн 3S, Сэтгэлгээний 3S гэсэн 4 төрөл байна. Эдгээр 4 төрлийн аль нэгийг дутуу хийвэл хэрэгжихгүй байх магадлалтай учир сайтар төлөвлөж, багаар ажиллах шаардлагатай гэж үзэж байна.</p> <p>Aircon service Компанийнхаа дотоод дүрмийг товчхон, энгийн хялбар боловсруулж, түүнийгээ мөрдөж хэвшүүлэх.</p> <p>Оосака Их сургууль /Минагава Кэнтаро багш/ <i>“Манай компанид ажилладаг хүмүүс амьдарлынхаа хамгийн чухал мөчийг ажлынхаа байранд өнгөрүүлдэг. Тиймээс тэрхүү чухал үнэ цэнэтэй цагийг гологдол бүтээгдэхүүн үйлдвэрлүүлж засуулах ажил хийлгэвэл тэр хүмүүсийн амьдралыг үл хүндэтгэсэн зүйл болно”</i> Тиймээс ХҮН ажиллахад аюулгүй тохилог орчинг бүрдүүлж, үр ашигтай, үнэ цэнэтэй оюуны бүтээл бүтээдэг нийгэмдээ хэрэгтэй ХҮН-г бэлтгэж төлөвшүүлэх.</p> |
| 4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл |
| <p>Өөрийн ажил мэргэжилдээ эзэн болж компанийнхаа үйл ажиллагааг удирдан зохион байгуулах хамгийн гол хүч нь Менежер юм байна. Манай компанийн захирал зардал гаргаж ийм сургалтанд явуулсан нь хий дэмий зүйл болоогүй юм байна гэдгийг ажлын гүйцэтгэлээрээ харуулах. Мөн Жайкагийн хамт олонд талархаж байна, энэ сургалтыг зохион явуулсан хүмүүст талархаж байна.</p> |
| 5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ |
| <p>Байгууллагынхаа үндсэн үйл ажиллагааг сайжруулж чанартай бүтээгдэхүүн гаргах. Бүтээгдэхүүн үйлчилгээгээ чанаржуулсанаар энэ бүтээгдэхүүн нь өөрөө манай компанийн маркетинг болж өгнө. Хэрэглэгчийн сэтгэл ханамж = Ажилчдын сэтгэл ханамж байх боломжийг бүрдүүлнэ.</p> |

6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга(Компани эсвэл өөрийн бие дээр)

Зураг төсөл боловсруулах болон зохиогчийн хяналт тавих үйл ажиллагаанд Кайзэн хийх:
Үүнд:

- Зураг төслийн ажлын МҮДА-г багасгах
- Зургийн төслийн чанарыг сайжруулах
- Зохиогчийн хяналт хийх ажлын чанарыг сайжруулах

Менежерийнхээ үүргийг сайтар биелүүлэх хэрэгтэй байна. Өөрчлөгдөх ёстой нь ажлын талбар бус “Менежмент” юм гэж /Табита Коожиро/ хэлсэн байна. Өөрчлөгдөх ёстой хүн менежер Би өөрөө юм байна. Өөрчлөлтийг өөрөөсөө эхлэх ёстой юм байна.

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Цаг барих, хувийн бэлтгэлээ сайн хангах.

2019 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

Нэр: Д.Ганбат
 Албан тушаал: Технологи хариуцсан захирал
 Үндсэн сургалт төгссөн он: 2019



| | |
|------------------------|--|
| Компанийн нэр | Метропласт ХХК |
| Байгуулагдсан он | 2011 |
| Үйл ажиллагааны чиглэл | Барилгын хуванцар хийц эд анги үйлдвэрлэл худалдаа |
| Ажилчдын тоо | 30 |

Компанийн товч танилцуулга



“Метропласт”ХХК 2011 онд дотоодын 100% - ийн хөрөнгө оруулалттайгаар хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар байгуулагдсан. 2012 оноос үйлдвэрлэлийн үйл ажиллагаа өнөөдрийг хүртэл тасралтгүй явж байна.

Өнөөгийн байдлаар манай үйлдвэр нь

- Хуванцар цонхны бэлдэц болон дагалдах материалын худалдаа (MNS5874:2008)
- Өндөр даралтын халуун, хүйтэн цэвэр усны хуванцар хоолой болон холбох хэрэгсэл (MNS4427:2007)
- Дулааны болон ус дамжуулах хоолойн дулаалгын хөөсөнцөр

зэрэг стандарт техникийн шаардлагыг хангасан иж бүрэн үйлдвэрийн тоног төхөөрөмжөөр өндөр чанартай бүтээгдэхүүн Монголын зах зээлд амжилттай үйлдвэрлэн нийлүүлэн ажиллаж байна.

Хуванцар цонхны бэлдэц

- 60x60 мм 3 камертай тагтны хаалт, тасалгаа, дотор цонхны бэлдэц
 - 60x70 мм 4 камертай цонхны бэлдэц
 - 70x63 мм 5 камертай цонхны бэлдэц
 - 70x79 мм 5 камертай цонхны бэлдэц
 - 7мм, 11мм, 16мм, 19мм, 22мм, 36мм -ын цонхны шил дарагч
 - 60мм, 70мм хаалганы хуванцар бэлдэц
- нийт 24 төрлийн хэвээр дан болон 2 3 давхар шил хийх зориулалтаар Монгол орны эрс тэс уур

амьсгалд тохируулан үйлдвэрлэж байна.

Өндөр даралтын халуун хүйтэн цэвэр усны хуванцар хоолой

Өндөр чанартай анхдагч цэвэр түүхий эдээр 20мм - ээс 450 мм хүртэл диаметртэй хоолойг 25 төрлийн хэвээр, хоолойн уртыг хүссэн хэмжээгээр Монгол улсын чанар стандартын дагуу бүх төрлийн даралтаар үйлдвэрлэж байна.

Уг хоолой нь угсарч суурилуулахад хялбар, зэвэрдэггүй, ус урсах шугамын эсэргүүцэл бага, үйлдвэрлэгдэж буй хоолой бүрийг чанар стандартын лабораториор баталгаажуулан бичиг баримтыг дагалдуулаж өгдөг.

Дулаалгын хөөс

Монгол улсын стандартын дагуу 40 – 80 кг/м³ нягтралтайгаар захиалагчийн дагуу үйлдвэрлэж байна. /100 айл дээрх хөөсний нягт 18 кг/м³ тай байдаг. Нягт их байх тусам хоолой доторх ус хөлдөхгүй/

Цонхны бэлдэц

Давуу тал:


Эрс тэс уур амьсгалд тохиромжтой
Усны тусгаарлах чадвар өндөр
Дулаан алдагдал бага
Дуу, чимээ тусгаарлах чадвар өндөр
Герман стандарт
Хүссэн уртаараа захиалах боломжтой



Хоолой

Өндөр даралтын хүйтэн усны хүчитгэсэн хоолой

20мм- 450 мм



| | | | | | |
|-------------------------|-------------------------------|---------------------------------|----------------------|------------------------------|--------------------------|
| Гадны нөлөөнд тэсвэртэй | Уян хатан | Температурын өөрчлөлд тэсвэртэй | Дотоод эсрүүцэл бага | Элэгдэл бага | Хөлийн өндөр эсрүүцэлтэй |
| Дотоод дамжуулалт бага | Дотоод хийгээрүүрэн байдалтай | Тусгаарлагч | Угсралд хялбар | Хамбалт ажилд нэг биет болно | Хайбаржуулалтад хялбар |
| | | | | | ШИНЖ ЧАНАР |
| | | | | | |
| | | | | | Хөнгөн |

Дулаалгын хөөс



1.Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

1. Компани болон үйлдвэрийнхээ үйл ажиллагааг сайжруулах
2. Япон менежментийг судлах
3. Өөрийгөө хөгжүүлэх

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

1. Компанийн алсын хараа, эрхэм зорилгыг шинэчлэн тодорхойлов.
Old: Шинэ технологи, Чанартай бүтээгдэхүүн, Хэрэглэгчийн найдвартай түнш байх
New: Мэдлэг шингэсэн баялаг бүтээнэ.
2. Үйлдвэрийн ажилчдад өглөөний дасгал хөдөлгөөнийг тогтмол хийлгэдэг болсон.
3. Үйлдвэрийн үйл ажиллагаанд 3S хэрэгжүүлэх ажлын байрны эмх цэгц цэвэрлэгээг хэвшүүлэхээр ажиллаж бна.

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

1. Үйлдвэрийн болон оффисын эмх цэгц Кайзен 3S талаар маш гүн гүнзгий ойлголт олж авлаа.Хамгийн энгийн жишээ гэхэд хичээл орж буй анги бүрт самбарын хажууд маркерыг 4 өнгөөр нь хайрцагт хийж өнгө бүрийг бичсэн байсан.
2. Осака хотын Технологийн Их сургуульд очин сургалтад сууж Лего машин угсарсан. Үүгээрээ технологийн урсгалыг зөв болгож илүү хөдөлгөөн буюу Мудаг багасгаснаар богино хугацаанд алдаагүйгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж байгааг олж харлаа.
3. Киото хотын КТС компани автомашин болон эмнэлгийн багаж хэрэгсэлийн үйлдвэрээс хэрэглээгээр нь ангилах гэдэг нь манай үйлдвэрт их ойр санагдлаа.



Түүхий эд болон багаж хэрэгсэлийг хэрэглээгээр нь

- Амьд зүйл /8 цагийн дотор хэрэглэх/ **ойр**
- Амарч буй /3 – 6 сар хэрэглэх/ **дунд байрлал**
- Үхмэл байрлал /6 – аас дээш сар/ **хол** гэж ангилах ингэснээрээ илүү хөдөлгөөн Мудаг багасгах.

Хүний нөөцийн хөгжил тогтвортой байдал.

1. Токио хотын AP company менежменттэй танилцлаа.Уг компани нь хоолны үйлчилгээ болон хүнсний бүтээгдэхүүний худалдаа эрхэлдэг компани. Ажилчидаа тогтвор сууршилтай ажиллуулахын тулд нилээд хэдэн ажил явуулдагаас заримыг нь дурьдвал
 - Шинэ ажилтан авахдаа компанийн эрхэм зорилго үнэт зүйлст таарах эсэхийг өөр асуултаар асууж таньж мэддэг.

- Компанийн эрхэм зорилго үнэт зүйлсийг ажилчдад ухуулан ойлгуулах хуваалцах өдөрлөг зохион байгуулах ажилтан бүрийг зорилготой болгох
 - Ажилтан бүрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр эцсийн бүтээгдэхүүн хийж буйг ажилтанд нь танилцуулж байх
 - Ажилтан бүрт байнга сургалт явуулж байх санал бодлыг сонсох байх
 - Ажилчдийн сэтгэл ханамжийг тодруулах хагас жил тутам дэлгэрэнгүй асуулттай судалгаа авч байх
2. Токио хотын АйрКон Сервис Компани агааржуулалт болон сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл эрхэлдэг компани.
- Компанийн ажилтан бүр менежментийн төлөвлөгөөнд оролцдог
 - Төлөвлөгөөний дагуу зорилгодоо хяналт тавьдаг
 - Сар болон улирал бүр хийсэн ажлаа тайлагнадаг
 - Магтаалын картыг ажилтандаа сар бүр өгч урам өгдөг
3. Хүний нөөцийг тогтвортой ажилуулахад үйлдвэрүүдийн эрүүл орчин бүрдүүлсэн тохижилт бас байлаа.

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

1. Өөрчлөгдөх ёстой нь ажлын талбар бус “менежмент” юм. Менежмент өөрчлөгдвөл ажлын талбар ч өөрчлөгдөнө.
2. Сайн ажлын байр нь хамгийн сайн борлуулагч дээрхи зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгохыг зорьж байна. Энэ нь маш өргөн агуулгыг багтаасан ойлголтууд юм.
 - Стратегийн төлөвлөлт, маркетинг, хүний нөөц, санхүүгийн менежмент

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компанид хэрэгжүүлж болохуйц жишээ

Япон дахь сургалт маш сайн зохион байгуулалттай үр өгөөжтэй болж өнгөрлөө . Японы компаниуд цагийн менежмент болон ажилчдын ажиллах орчны анхааруулгууд маш тодорхой байсан.

Сургалтууд бүгдээрээ шууд компани болон үйлдвэрүүд дээр болж байсан нь авч хэрэгжүүлж болохоор маш үр дүнтэй ойрхон байлаа.

Ялангуяа Киото хотын Төмөр хийцийн үйлдвэр болох Ямада Сэйсакушо ХКомпани дээрх сургалт үйлдвэр дээрх ажлын байрны зохион байгуулалт ажлын байрны цэвэрлэгээ зэрэг нь ямар байвал зохих талаарх бодит мэдлэгийг өгч, өөрчлөлтийг хийж болох итгэлийг маш ихээр төрүүллээ. Үйлдвэрийн тохитой цэвэр орчин бүрдүүлэхийн тулд энэ компани өглөө бүр тогтмол 10 минутын цэвэрлэгээ хийдэг

- Өглөө бүр Эрхэм зорилго уриа үгээ хэлж байх
 1 ажилтан дурын сэдвээр 3 минутын яриа хийж байх
 3 багаар нь дүгнэх урамшуулах
 Зорилт сорилтын хуудас багаар нь бөглөх





6.Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)

Үйлдвэр дээр 3S хэрэгжүүлэх эхний бэлтгэл

- Шинээр орж ирж буй ажилтанд зориулсан үйлдвэрийн процессийг ойлгомжтой тодорхой байх гарын авлагатай болно.
- Үйлдвэрлэлийн процессын зураглалыг бүтээгдэхүүн бүр дээр хийж,илүү хөдөлгөөн болон мудаг арилгах арга замыг хамтдаа тодорхойлж хэрэгжүүлнэ.
- Ажиллагсдынхаа тав тухтай ажиллах амрах нөхцлийг сайжруулна.

Үйлдвэрийн дуут сэрүүлэгтэй цагийг захиалгаар хийлгүүлнэ.

Энэ цагийн тохиргоо нь:

- Ажил цуглах
- Өглөөний цэвэрлэгээ
- Өглөөний шуурхай эхлэх
- Ажил эхлэх
- Өдрийн цайны цаг
- Орой ажил тарах
- Өдрийн цахилгааны хэрэглээний ачаалалыг гэрлээр харуулна.



/ Зарцуулалт ихсэхэд цагийг тойрсон гэрэл бүгд асна.Үүгээр цахилгааны хэрэглээг хянах боломжтой/

- Багаж тус бүрийг ангилан 1 жигд өрөх , ажилчдын нэрсийг соронзон наалт дээр нааж багаж авсан хүн нь багажны зайнд нэрээ наах. Ингэснээрээ багаж хэнд байгаа нь харагдах орой ажил тарахад хэн гэдэг ажилтан багажаа хураагаагүй нь харагдана.



- Тоног төхөөрөмж бүрийн хажууд хэрэглэгдэх багажийг байрлуулах
 - Ажилчдын хувцас солих шкафанд нэр, зураг наах
- Тоног төхөөрөмж бүрийг ажилуулах дараалал процессын зургийг төхөөрөмж бүр дээр хэвлэж наах



7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Японд цаг маш сайн баримтлах хэрэгтэй.
- Сургалтын явцад хэрэгтэй гэсэн зүйлээ тэр даруйд нь байнга зургаар баталгаажуулж авах.

2019 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

Нэр: Д.Ганхуяг
 Албан тушаал: Гүйцэтгэх захирал
 Үндсэн сургалт төгссөн он: 2019



| | |
|-------------------------|------------------------------|
| Компанийн нэр: | Женерал Эталон ХХК |
| Байгуулагдсан он: | 2011 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Барилгын материал үйлдвэрлэл |
| Ажилчдын тоо: | 30 |

Компанийн товч танилцуулга

“Женерал Эталон” ХХК нь хөнгөн бетон блок, бетон эдлэхүүний үйлдвэр, барилгын материалын тоног төхөөрөмж, үйлдвэрийн сэлбэг хэрэгслэлийн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулдаг.

Хөнгөн бетон гулдмай /блок/

Төмөр замын дэр бетон

Арматуран бэхэлгээтэй бетон шон

Арматуран бэхэлгээтэй бетон ус зайлуулах хоолой

Замын хашлага, өнгөт хавтан гэх мэт...



Бидний нэрийн хуудас бол туршилт судалгааны аргаар гарган авсан стандартад нийцсэн, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ болон гадаад хамтын ажиллагаа юм.

“Женерал Эталон” ХХК нь барилгын материалын үйлдвэрлэлийг жилийн дөрвөн улиралд явуулан, MNS 831-2011 стандартын шаардлага хангасан, орчин үеийн иж бүрэн автомат тоног төхөөрөмжтэй. Мөн нийгмийн хамтын ажиллагаанд үр бүтээлтэй идэвхтэй оролцдог. Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны гишүүн байгууллага юм.

Манай зөвлөх инженер,технологич инженер, мэргэжилтэнгүүд шохой, цемент, элс, нэмэлт бодисуудад лабораторын шинжилгээг тогмтол хийдэг. Энэ нь танд очих хөнгөн бетон, гулдмай нь Монгол Улсын MNS 831-2001 стандартыг хангасан байх баталгаа болдог юм.

1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

1. 5S тогтолцоог хэрхэн үр дүнтэй нэвтрүүлэх үү
2. Кайзан санал авах ажиллагааг хэрхэн нийт компанийн ажилтнуудын дунд зохион байгуулах уу?
3. Тогтвортой ажиллахад нөлөөлөх Япон маягийн менежмент
4. Өөрчлөлтийн менежмент
5. Чанарын удирдлагын тогтолцоог хэрхэн бий болгох вэ?

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

1. Өглөөний хурал



Дадлага сургалтад хамрагдаж байх хугацаанд Ямада Сэйсакушо ХК-ийн Өглөөний Чоорейтэй танилцсан. Энэхүү хурал нь богино хугацаанд мэдээллийг үр дүнтэй дамжуулах ач холбогдолтой санагдсан. Иймд өөрийн үйлдвэр дээр ирээд ажилтнуудтайгаа ярилцаж байгаад өглөөний хурлыг хэвшүүлэхээр Долоо хоногт 1 удаа хийж эхэлсэн болно. Ингэхдээ аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, тухайн 7 хоногийн төлөвлөгөө болон өнгөрсөн долоо хоногийн гүйцэтгэлийг хэлэлцэж, байгууллагын алсын хараа болон эрхэм зорилгоо хамтдаа хэлээд хурлаа өндөрлөж байгаа болно. Цаашдаа 7 хоногт удаа хийгээд хэвшээд ирэхээр нь өдөр бүр хийх төлөвлөгөөтэй байна.

2. 3S, Кайзен санал

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулдаг учраас зайлшгүй 3с хэрэгжүүлэх шаардлагатай гэдгийг сургалтад оролцож байхдаа ойлгосон. Энэ нь Аюулгүй байдал, тав тух болон бүтээмж үр ашигтай байдал чухал нөлөө үзүүлнэ. Иймд эхний ээлжид нийт ажилтнууддаа 3S-ийн мэдлэг мэдээлэл өгөх шаардлагатай бөгөөд энэ талаар анхан шатны сургалтыг зохион байгуулсан. Мөн үйлдвэрийн хашаа болон барилгын эмхэлж цэгцлэх ажиллагааг хийж гүйцэтгэсэн. Үүний дараа ажилтнуудаасаа Кайзен санал авах ажиллагааг хийж эхлэхээр ажиллаж байна.

Хэрэглэгчийн сэтгэл ханамж = Ажилтны сэтгэл ханамж гэдэг ойлголтыг AP company-д зочлон сургалтад хамрагдаж байхдаа сурсан. Иймд ажилтнаа халамжлах нь компанийн хөгжилд өндөр үр дүнтэй зүйл гэдгийг ойлгосон. Гэхдээ ажилтанд мөнгөөр бус түүний компанид оруулж буй хувь нэмрийг шаардлагатай цаг хугацаанд нь хэлж байх нь мөнгөн урамшууллаас илүү ажилтныг идэвхижүүлдгийг ойлгосон.

Ингээд ажилтнуудынхаа дунд талархлын аяныг зарлаж зөвхөн удирдлага талархал илэрхийлэх бус ажилтнууд мөн хоорондоо талархлаа илэрхийлдэг халуун дулаан хамт олон болохоор зорьж байна.

3. Талархлын хуудас



3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

1. Миний хувьд барилгын материал үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг. Энэ дадлага сургалтад хамрагдаж байхад МҮДА /үргүй зардал/-г арилгах – ажлын 10-20 хувь нь л нэмүү өртгийг бий болгох жинхэнэ үр дүнтэй ажлууд байдаг тул МҮДА-г арилгах нь нэмүү өртгийн хувь хэмжээг нэмэгдүүлнэ. Тоёота компани 7 МҮДА-г хэрэгжүүлдэг талаар сурсан. Энэ талаар урьд өмнө нь сонсож байгаагүй тул маш үр дүнтэй санагдсан. Мөн гологдолгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилт зорилт тавьж байна.
2. 3S болон кайзан амжилттай нэвтрүүлсэн компаниудаар зочилсон нь өөрийн үйлдвэртээ хэрэгжүүлж болох маш олон санаа, мэдлэгийг олж мэдсэн. Иймд газар дээр нь зочилж мэдсэн зүйлээ цаашид өөрийн үйлдвэртээ хэрэгжүүлэхээр зорьж ажиллаж байна.
3. Өглөөний чоорей богино хугацаанд үр дүнтэй мэдээлэл дамжуулах арга барилыг сурсан бөгөөд энэхүү хурлаар дамжуулан мөн ажилтнуудаа урамшуулах, идэвхижүүлэх боломжтой гэж харж байна.
4. Алсын хараа, эрхэм зорилго болон менежментийн зорилго зорилтоо хуваалцах нь ажилтан болон удирдлага нэгдсэн нэг зорилго зорилттой байх, нэг зүг рүү хамтдаа харж алхах боломжийг нээдэг юм байна. Зөвхөн энэ нь удирдлагын хийдэг зүйл биш юм аа ажилтнуудын хамтын оролцоотойгоор хүрдэг юм гэдгийг дадлага сургалтад хамрагдаж байхдаа сурсан.

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

1. Бизнес уулзалтад маш үр дүнтэй оролцсон бөгөөд хэд хэнд компаниуд манай үйлдвэрийн үйл ажиллагааг сонирхож уулзаж байсан. Үүний үр дүнд сургалтад хамрагдаж ирснээс хойш нэг сарын дараа SGCHEM компаниас төлөөлөгчид ирж манай үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж хамтын ажиллагааны талаарх уулзалт хэлэлцээ хийгээд буцсан. Эндээс дүгнэхэд энэхүү дадлага сургалт нь монголын компаниудад бизнес боломж гаргаж өгөх үр дүнтэй сургалт болдгийг мэдсэн. Иймд сургалтад хамрагдаж буй удирдлага менежерүүд маань маш хариуцлагатайгаар өөрийн бизнесийн хэрэгцээ шаардлагаа тодорхойлох, сургалтаас хүлээх хүлээлтээ тодорхой болгон түүндээ өөрийн компанийн танилцуулга, болон материалуудаа бэлтгэх шаардлагатай юм байна гэж дүгнэлээ.
2. Монголд сурсан үндсэн сургалтын хичээлүүдээ газар дээр нь дадлага сургалтаар илүү бататгах боломжийг сургалт нь олгосон. Мөн япон менежмент гэдэг зүйлийг япон соёлтой танилцаж байж илүү ойлгох илүү амьдралтай хэрэгжүүлэх боломжтой юм гэдгийг ойлгож сурсан болно.

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

1. Барилгын материалын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулдаг учраас 3S, Кайзен болон МҮДА-г хамгийн түрүүнд үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх шаардлагатай юм байна гэж дүгнэсэн.
2. Чоорей буюу өглөөний хурал
3. Талархлын хуудас
4. Алсын хараа, эрхэм зорилго болон менежментийн зорилго зорилтоо хуваалцах нь ажилтан болон удирдлага нэгдсэн нэг зорилго зорилттой байх буюу хүрэх зорилгоо тодорхой болгох шаардлагатай бөгөөд компанийн ажилтан гишүүн бүр мэддэг байх шаардлагатай болон

үүнийг хэрэгжүүлэх нь компанийн үйл ажиллагаанд өндөр үр дүн авчирна.

6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)

PDCA буюу тасралтгүй сайжруулалт хийж байх нь өөрөө Япон менежментийн онцлог гэж бодож байна. Зөв төлөвлөж сурах, түүнийгээ 100 хувь гүйцэтгэх, болон гүйцэтгэлээ дүгнэж байх түүнийгээ үндэслээд тасралтгүй сайжруулалтыг үйл ажиллагаандаа хийж байхыг сурлаа.

Мөн аливаа компанийн бүрийн нийгмийн хариуцлагаа ухамсарласан байдал болон жижиг гэлтгүй бодитой үр дүнд чиглэсэн арга хэмжээ авч ажилладаг нь харагдсан. Иймд цаашид нийгмийн хариуцлагаа ухамсарлаж байгаль орчинд ээлтэй бодлого төлөвлөгөө хэрэгжүүлж ажиллах болно.

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Япон дахь сургалтын хэрэгцээ шаардлагаа зөв тодорхойлох хэрэгтэй. Тэгээд сургалтад хамрагдахаас өмнө сургалтын төлөвлөгөө болон хөтөлбөрт багтсан компаниудын талаар урьдчилан судалж аль болох өөрийн сургалтын хэрэгцээ шаардлага, төлөвлөгөөний дагуу сурч мэдэх зүйлсийн талаарх асуултуудаа урьдчилан бэлтгэж бэлдээд түүндээ хариулт аваад тэмдэглээд явбал илүү үр дүнтэй сургалт болно.

Мөн хэрэгжүүлэх зүйлсээ маш тодорхой бэлтгээд түүндээ хүрэх цаг хугацааг тодорхой төлөвлөх юм бол энэхүү япон дахь дадлага сургалтын үр дүн гарна. Мэдээж богино хугацаанд энэхүү сургалтын үр дүн бол гарахгүй боловч тасралтгүй тууштай хэрэгжүүлэх юм бол урт хугацаандаа танай байгууллагын үйл ажиллагаанд эерэг үр дүнг авчрах болно. Иймд та бүхэн маш сониучаар болон идэвхитэй сургалтадаа хамрагдахыг захья.



2019 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

Нэр: Т.Солонго
 Албан тушаал: Хуулийн зөвлөх
 Үндсэн сургалт төгссөн он: 2019



| | |
|-------------------------|-----------------------|
| Компанийн нэр: | Таван Богд Трейд ХХК |
| Байгуулагдсан он: | 1995 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Менежментийн зөвлөгөө |
| Ажилчдын тоо: | 186 |

Компанийн товч танилцуулга

1995 онд Японы Fujifilm компанийг албан ёсоор төлөөлөн борлуулагч болсноор Таван Богд Группийн эхлэл тавигдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Таван Богд Групп нь өнөөдрийн байдлаар Уул уурхай, ханган нийлүүлэлтийн үйлчилгээ, ноолуур үйлдвэрлэл, олон улсын худалдаа болон үйлчилгээ, хүнс үйлдвэрлэл болон үйлчилгээ болон аялал жуулчлал, рестораны чиглэлээр нийт 18 охин болон 5 хараат компани нийт 12,000 гаруй ажилтантай Монгол улсын манлайлагч компаниудын нэг болсон.

Бид өөрсдийн ажиллаж буй салбар бүртээ манлайлан Монгол Улсын хөгжил дэвшилд өндөр хувь нэмэр оруулахын төлөө өдөр бүр хичээн зүтгэж ажиллаж байна. Таван Богд группийн компаниуд нь Монгол улсын Засгийн газар, МҮХАҮТ-тэй хамтран зохион байгуулдаг Монгол улсын нийгэм, эдийн засагт үнэтэй хувь нэмэр оруулдаг 'ТОП-100' аж ахуйн нэгжийн шалгаруулалтад байнга шалгардаг.

Манай группийн Ерөнхийлөгч Ц.Баатарсайхан нь Японд боловсрол эзэмшсэн хүн байдаг бөгөөд Таван Богд Группийн япон менежменттэй компани гэж олон нийтэд түгсэн байдаг. Таван Богд Группийн охин компаниудын гүйцэтгэх захирал, ажилчид дунд японд боловсрол эзэмшсэн хүмүүс мөн олон байдаг.


Мөн Таван Богд Группийн охин компаниуд нь Японы Тоёото Моторс, Тото, Fujitec, Tein гэх зэрэг брэндүүдийн албан ёсны төлөөлөгчөөр ажилладаг бөгөөд Вашёокү, Сакура зэрэг япон хоолны рестораны үйл ажиллагааг мөн явуулах зэргээр Японы компаниудтай хамтран ажиллаж үйл ажиллагаагаа явуулдаг.



1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

6. Групп компанийн удирдлага зохион байгуулалтын бүтэц
7. Дотоод аудитын тогтолцоо
8. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо
9. Тогтвортой ажиллахад нөлөөлөх Япон менежмент
10. Өөрчлөлтийн менежмент

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт



1. Япон соёлын онцлог, япон маягийн менежмент гэж юу вэ талаар компанидаа сургалт зохион байгуулсан. Учир нь манай компани япон менежменттэй компани гэдэг боловч япон соёлын онцлогийг мэдэхгүйгээс бүрэн хэрэгжихгүй байх дутагдалтай гэж дүгнэсэн. Иймд өөрийн япон дахь дадлага сургалт болон япон орны соёлтой танилцсан туршлагаасаа үүдэн энэ талаарх сургалт зохион байгуулсан

2. Хүний нөөцийн тогтворжуулах функц хариуцсан менежерт дараах саналыг гаргасан болно. Үүнд:

- a. Ажилтны сэтгэл ханамж = Хэрэглэгчийн сэтгэл ханамж – Иймд ажилтнуудын сэтгэл ханамж ямар түвшинд байгааг судлах, ажлаас гарсан ажилтнуудтай хийх ярилцлагаас дүн шинжилгээ хийн сэтгэл ханамжийн түвшинг сайжруулах арга хэмжээ зохион байгуулах
- b. Байгууллагын соёлын судалгааг хийхдээ аль болох үр дүнтэй, компанийн соёлд эерэг үр дүнд хүрэхүйц, ажилтнуудын сэтгэл ханамжийг судлах, байгууллагын зорилго, алсын харааг хэрхэн ойлгодог болон цаашид тогтвортой ажиллах эсэхийг судлах талаар санал өгсөн.



3. Таван Богд Группийн хэмжээнд бүтээлч Таван Богдчууд арга хэмжээг зохион байгуулахад хамт олонтойгоо баг болж ажиллаж дадлага сургалтаас олж авсан мэдлэг мэдээллийг хуваалцаж нийт группийн хэмжээнд зохион байгуулагдах арга хэмжээнд санал оруулна.

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

- Нийгмийн хариуцлага- бодитой үр дүнтэй ирээдүйд чиглэсэн

Очсон компани бүр нийгмийн хариуцлагын хүрээнд ирээдүйд чиглэсэн, бодитой үр дүнтэй ажил зохион байгуулдаг нь хичээлийн явцад харагдаж байсан. Гэтэл монгол компаниудын хувьд бид маркетингийн үйл ажиллагаатай холбож ойлгодог дутагдалтай талтай бөгөөд нэг удаагийн арга хэмжээгээр бид нийгмийн хариуцлагатай гэх ойлголтууд байгаад байдаг. Гэхдээ нийгмийн хариуцлагатай байх нь маш энгийн жижиг зүйлээс эхлэх юм байна гэдгийг дадлага сургалтаас олж харсан. Жишээ нь *байгууллагын хог хаягдлыг ангилж хаядаг байх хувь хүн өөрөө ч гэсэн.*

- All win

Харилцан ашигтай урт хугацаанд тогтвортой хамтран ажиллахыг хүсвэл тухайн бизнесийн харилцаанд оролцож байгаа талууд бүгд сэтгэл ханамжтай эрх тэгш байх ёстой юм байна гэдгийг сургалтын хугацаанд олж харсан. Хэн нэгэнд нь давуу байдлыг бий болгоод хэн нэгэн нь бизнесийн харилцаанд алдаад байх нь цаашдын хамтын ажиллагаанд үр дүнгээ өгөхгүй. Иймд талууд **All win** зарчим япон компаниудын дунд хэрэгждэг байна.

- Ажилтан болон удирдлагын оролцоотой буюу бүх нийтийн оролцоотой менежмент

Компанийн зорилго зорилт нь зөвхөн удирдлагын хүрэх гээд байгаа үр дүн биш бөгөөд зөвхөн түүний хичээл зүтгэлийн үр дүнд хүрэхгүй юм. Харин хүрэх гээд байгаа зорилго зорилтын төлөө ажилтан удирдлага хамтдаа арга замаа тодорхойлоод, бүх нийтийн оролцоог хангаж чадсанаар амжилттай зорилгодоо хүрэх юм. Дадлага сургалтад хамрагдаж байхад ихэнх компаниуд бүх нийтийн оролцоог чухалчилж байсан бөгөөд Aircon service ХК нь нийт ажилтнуудаараа менежментийн зорилго зорилтуудаа тодорхойлуулан түүнийг эмхтгэн ном болгож нийт ажилтнууддаа тараадаг нь таалагдсан.

- Хүнийг хүндлэх

Дадлага сургалтаар компаниудаар явж сургалтад хамрагдаж байхад ихэнх компанийн удирдлагын үзэл санаанд хүнийг хүндлэх, хүнийг чухалчлах үзэл баримтлал байсан. Аливаа бизнес, компани хүн буюу ажилтангүйгээр оршин байх боломжгүй юм. Мөн аливаа үйл ажиллагааны сайжруулалт, шинэлэг бүхий л санааг удирдлага ганцаараа мэдээд байх боломжгүй бөгөөд үүнийг хэн сайн мэдэх вэ гэхээр тухайн ажлыг гүйцэтгэж байгаа ажилтан л мэдэх боломжтой юм. Иймд ажилтнаа сонсох, түүнээс үйл ажиллагааны сайжруулалт хийх боломжтой орчныг бий болгох нь компанийн удирдлагын үүрэг гэдгийг сурсан. Мөн ажилтнаа хөгжүүлэх нь эргээд компанийн хөгжилд хувь нэмэр оруулдаг юм байна гэдгийг олж харсан.

- Хүлээлтээс давуулан биелүүлэх

Сургалтад хамрагдаж байхад олж харсан бас нэг чухал зүйл нь аливаа ажил үүрэг, үйлчилгээг байх хэмжээнд нь гүйцэтгэх нь хангалтгүй юм байна. Байх ёстой хэм хэмжээнээс нь давуулан биелүүлэх хүсэл эрмэлзэлтэй байх, түүнийгээ давуулан биелүүлж болдог юм байна гэдгийг олж харсан. Энэ нь эргээд давтан үйлчилгээг бий болгох, давтан хэрэглээг үүсгэдэг эерэг үр дүнтэй юм байна. Иймд жирийн нэг үйлчилгээг бус гайхамшигтай дээд зэргийн үйлчилгээг үзүүлэх хүсэл эрмэлзэлтэй ажиллах хэрэгтэй юм.

- Уламжлалыг орчин үед ашиглах арга барил

Бүхнийг шинээр хийх сэдэх бус байгаа зүйлийг орчин үед хэрхэн сайжруулж шинэчилж болох вэ гэдгийг япон компани бүр хэрэгжүүлдэг санагдсан. Байгаа сайн туршлага уламжлалаасаа санаа авч түүнийгээ улам сайжруулах, түүнийгээ өөрийн бизнесийн онцлог болгон ашиглаж байгаа нь маш их таалагдсан. Тухайлбал Тарүмаса ХК-ийн “философи нь уламжлалыг орчинд үед ашиглах”. Монголд маань ч гэсэн сайн туршлага, уламжлагдаж ирсэн уламжлал маань байгаа бид үүнийгээ өөрсдийн бизнесийн үйл ажиллагаанд ашиглах шаардлагатай байна.

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

1. Дадлага сургалт нь бизнесийн үндсэн сургалтаас олж авсан мэдлэгийг газар дээр очиж танилцах боломжийг олгосон. Мөн тухайн орны соёл, уламжлалыг газар дээр нь очиж танилцсанаар Япон маягийн менежментийг илүү ойлгох боломжийг олгосон үр дүнтэй сургалт болсон.
2. Сургалтын зохион байгуулалтын хувьд маш өндөр хэмжээнд зохион байгуулсан буюу хүлээлтээс хэрхэн давуулан биелүүлж гүйцэтгэж болохыг харсан. Тухайлбал сургалтын хөтөлбөр, хуваарь маш нарийн зохион байгуулалттай, сургалтад оролцогчдын сурахыг хүссэн сэдвийг бүрэн хамарсан болон өмнөх жилийн сургалтаас авсан судалгааны дагуу сайжруулалт хийсэн сургалт болсон. Мөн хэрхэн 25 хүнд хэрэг болохуйц сургалтыг зохион байгуулах вэ гэдэг дээр тал бүрээс нь бодолцсон сургалт байсан.
3. Эмх цэгцтэй, цаг нарийн баримтлах талаар бодитой харуулсан сургалт байсан. Сургалтын хөтөлбөрийг маш нарын зохион байгуулсан байсан бөгөөд тухайн сургалтад шаардагдах анги танхим, тээврийн хэрэгсэл түүнд зарцуулагдах хугацааг нарийн тооцсон байсан. Мөн тасралтгүй сайжруулалт хэрхэн үр дүнтэй хийх вэ гэдгийг тухайн сургалтын эцэст үр дүнгийн хурал дээр хийсэн ярилцлага харуулж байсан. Юу вэ гэхээр 2 хоногийн өмнө бидэнд сургалтын талаарх санал асуулгыг тарааж өгсөн байсан бөгөөд хэзээ гэхэд бөглөж өгөх ёстой вэ гэдгийг мэдээлсэн. Энэ дагуу үр дүнгийн тайлан өгөхийн өмнөх өдөр бид бүгд санал асуулгаа бөглөж өгсөн. Үүний маргааш үр дүнгийн тайлангаа тавьж дууссаны дараа өмнөх өдөр бидний бөглөж өгсөн саналыг сургалт зохион байгуулагчид маань нэгтгэн дүгнэсэн байсан бөгөөд эндээс бид нараас тодруулах, саналыг маань сонсох шаардлагатай асуултуудыг нэг цагийн хугацаанд асууж тодруулсан. Маш энгийн бөгөөд эмх цэгцтэй, нарийн заасан хугацаандаа энэхүү сургалтын дүгнэлт болон сайжруулалтын саналаа авч байгаа нь аргагүй л япон маягийн менежмент санагдсан.
4. Сургалтаас компанийн хөгжил, үйл ажиллагаанд хэрэгтэй олон зүйлийг сурахаас гадна хувь хүний хөгжлийн хувьд суралцах зүйлс мөн маш их байсан. Цагийн менежмент, чин сэтгэл, аливаа ажлыг хүлээлтээс давуулан биелүүлэх, хичээл зүтгэл, шаргуу хөдөлмөрч зан гээд маш олон зүйлийг суралцах боломжтой.

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

1. ALL win бизнесийн загвар – бизнесийн үйл ажиллагаанд бүгд харилцан ашигтай ажиллах зарчим
2. Алсын хараа, эрхэм зорилго болон менежментийн зорилго зорилтоо хуваалцах сургалт болон ажилтнуудаараа энэхүү зорилго зорилтод хүрэх арга замуудыг тодорхойлуулах. Энэ нь ажилтан өөрийн хувь нэмэрээ оруулах боломжтой байна гэдэг нь эргээд идэвхижих, үр дүн гаргах боломжийг нэмэгдүүлнэ.
3. Хэрэглэгчийн сэтгэл ханамж = ажилтны сэтгэл ханамж – ажилтан бол байгууллагын үнэт зүйл бөгөөд ажилтан сэтгэл ханамжтай байснаар хэрэглэгчид бид сэтгэл ханамжтай үйлчилгээг үзүүлнэ.
4. Талархлын хуудас – мөнгөн бус урамшууллын арга хэмжээг хэрэгжүүлэх
5. Өглөөний хурал буюу Чоорей – мэдлэг мэдээллийг богино хугацаанд үр дүнтэй түгээх
6. Кайзен хөтөлбөр хэрэгжүүлэх – кайзан амжилттай нэвтрүүлбэл хүний нөөц аяндаа бий

болдог байна.

7. МҮДА /үргүй зардал/-г арилгах – ажлын 10-20 хувь нь л нэмүү өртгийг бий болгох жинхэнэ үр дүнтэй ажлууд байдаг тул МҮДА-г арилгах нь нэмүү өртгийн хувь хэмжээг нэмэгдүүлнэ. Тоёота компани 7 МҮДА-г хэрэгжүүлдэг байна.
8. Ажлын байр бүрт тохирсон оновчтой сургалт хөгжлийн бодлого – ажилтны хөгжил бол байгууллагын хөгжлийг бий болгоно.

Хэрэгжүүлж болох олон шинэлэг, санааг дадлага сургалтын хүрээнд олж харж, сурч мэдсэн бөгөөд үүнийг шууд хэрэгжүүлэх боломжгүй байна. Байнгын тасралтгүй мэдлэг мэдээллийг компанийн ажилтнуудад өгөх шаардлагатай байгаа бөгөөд урт хугацаанд нарийн төлөвлөгөөтэйгөөр тасралтгүй хэрэгжүүлж, хэвшүүлэх шаардлагатай юм байна.

6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)

Хувь хүнийхээ хувьд ур чадвар мэдлэг нь зөвхөн амжилтад хүрэх зэвсэг биш юмаа харин хичээнгүй, шаргуу зан, тууштай байдал хичээл зүтгэл нь хүнийг амжилтад хүргэдэг юм байна энэ нь Япон улсын соёлоос харагдсан бөгөөд ийм зан чанартай иргэд байгаа учраас улс нь өндөр хөгжилтэй орнуудын нэг болж хөгжиж чадсан байна гэдгийг олж харсан. Иймд аливаа зүйлийг чин сэтгэлээсээ, хичээгүйлэн хийж тасралтгүй сайжруулалт хийж байх шаардлагатай юм байна гэдгийг олж харсан.

Компанийн хувьд шинэ санааны уралдаан зохион байгуулах, кайзен, талархлын хуудас болон ажилтны сургалт хөгжлийн үр дүнтэй бодлого арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Мөн Компанийн нийгмийн хариуцлагыг бодитой үр дүнтэй ирээдүйд чиглэсэн байдлаар хэрэгжүүлэх шаардлагатай байна гэдгийг олж харсан. Мөн одоо байгаа сайн зүйлээ цаашид хөгжүүлэх, тасралтгүй сайжруулалт буюу PDCA циклийн хүрээнд хийх шаардлагатай байна.

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Сургалтад хамрагдаад үр дүнгийн тайлангаа багаараа бэлтгээд ярилцаж байхад бүгд маш их зүйлийг сурсан байсан бөгөөд бүгд л ам уралдаан энэ компани дээр ийм зүйл онцлог байсан дараагийн компани дээр ийм зүйл нь таалагдсан гээд бүгд чин сэтгэлээсээ бусадтайгаа хуваалцаж байсан. Тэгэхээр 14 хоногт бид маш их зүйлийг сурч мэдсэн бидний багийн ажлаас харагдаж байсан.



Иймд сурсан мэдсэн зүйлийг Монголдоо ирээд бусадтайгаа аль болох түргэн хугацаанд зөвхөн өөрийн компаниар хязгаарлалгүй хуваалцах хэрэгтэй санагдсан. Мөн өөрийн Япон дахь дадлага сургалтаас сурч мэдэхийг хүсч байгаа зорилгоо зөв бөгөөд тодорхой тодорхойлж чадвал сургалтын үр дүн өндөр гарах болно

2019 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

Нэр: Г.Ганбаяр

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Үндсэн сургалт төгссөн он: 2018-2019 он



| | |
|--|---|
| Компанийн нэр: | Монмасло ХХК |
| Байгуулагдсан он: | 2003 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Гадаад худалдаа болон Хүнсний үйлдвэрлэл |
| Ажилчдын тоо: | 80-90 |
| Компанийн товч танилцуулга | |
| <p>2003 онд Монгол улсын 100% хөрөнгө оруулалттайгаар Гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаагаа эхэлсэн.</p> <p>Гадаад худалдааны чиглэлээр ОХУ, Франц, Турк, БНСУ, Малайз, Сингапур улсуудаас ISO болон НАССР чанарын стандартын шаардлага хангасан Хүнсний бүтээгдэхүүнийг Монголын зах зээлд доорх хүчин чадалтайгаар нийлүүлэн ажиллаж байна. Монголын томоохон болон жижиглэнгийн хүнсний бүхий л дэлгүүрүүд болон худалдааны төвүүдэд бүтээгдэхүүнээ нийлүүлж байна. Жишээлбэл: Номин, Сансар, Оргил, Э-март, Шангри-ла ресторан, Рамада ресторан гэх мэт.</p> <p>Ажилчдын тоо: 80 гаруй</p> <ul style="list-style-type: none"> • Түгээлтийн хүнсний бүтээгдэхүүний шаардлага хангасан: 30 автомашин • Хүнсний агуулах Улаанбаатар хотод: 9,500 м.кв • Дархан хотод хүнсний агуулах: 1000 м.кв • Үйлдвэрийн талбай: 1,000 м.кв • Харилцагчдын тоо: 3,600 • Ажлын туршлага: 16 жил <p>2018 онд Үйл ажиллагаагаа өргөжүүлэн Хүнсний үйлдвэрлэл болох Вафлины үйлдвэрлэлийн чиглэл рүү орсон. 2019 оны 12-р сард Монголын зах зээлд Вафлины үйлдвэрийнхээ бүтээгдэхүүнийг нийлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p> | |

Тоног төхөөрөмжийн хувьд Турк улсад үйлдвэрлэсэн Олон улсын шаардлага хангасан автомат болон бүрэн тоноглогдсон.



Үйлдвэрлэгч: Gocmen (БНТУ)

1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

11. Менежментийн талаар онолын цогц мэдлэгтэй болох
12. Компанидаа япон маягийн менежментийг хэрэгжүүлэх

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

Стратегийн менежмент:


Үндсэн сургалтаас өмнө стратегийн төлөвлөгөөгөө нэг жилээр төлөвлөдөг байснаа 3-5 жилийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байгаа.

3-5 жилийн төлөвлөгөө боловсруулахаар ажилчдын тогтвортой байдал болон ажлын үр дүн эрс нэмэгдсэн.

Дотоод бүтцийн зураглалаа дахин боловсруулж үйл ажиллагааны процессыг хялбаржилсан.

Хувь хүний хөгжлийн төлөвлөгөө

Ажилчдыг өөрсдөөр нь ажлын төлөвлөгөөгийн гаргуулж хяналт тавьж байгаа.



3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

Хүний нөөцийг хөгжүүлэх

Японы байгууллагуудтай танилцахад жижиг болон дунд зэргийн байгууллагуудын хувьд бол хүний нөөцөөр дээрээ маш сайн анхаарч ажилтны ур чадвараас ажил нь хамааралтай. Харин Тоёота буюу том байгууллагуудын хувьд бол ажилтаны ур чадвараас үл хамаарахаар байдлаар үйл ажиллагааны процессоо зөв явуулдаг нь зөв санагдсан. Яагаад гэвэл манай улс шиг хүний

нөөцийн оролд гаралт ихтэй газар Тоёотагийн арга барил зөв санагдсан.

Ажилчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх

Ажилтны сэтгэл ханамжийг дан ганц цалингаар биш ажлын байрны орчин болон дотоод үйл ажиллагааны ойлгомжтой бүтэцтэй холбоотой юм байна. Мөн ажилтан бүрийн оновчтой саналыг удирдлагын түвшинд авч хэрэгжүүлэх тусам компани улам хөгжин, өсөн дэвжинэ. Харин хийх нөхцлийг нь бүрдүүлж өгөх хэрэгтэй.

5S хэрэгжүүлэх

Байгууллагын урт хугацаанд тогтвортой оршин тогтоход нэн чухал арга барил бол 5S. 5S япон явахаас өмнө маш том ажил гэж бодож байсан боловч Японы байгууллагуудын хэрэгжүүлж байгаагийн хараад шууд маргаашаа хэрэгжүүлж эхлэх боломжтой ойлгосон. Заавал 5S-г бүтэн хэрэгжүүлэх гэж яарах хэрэггүй эхлээд 3S хэрэгжүүлсэн тохиолдолд үлдсэн 2S нь хэрэгжүүлэхэд дөхөм санагдсан. 5S хэрэгжүүлэх нь ажилчдын хувьд дарамт биш байдлаар өдөр тутмын ажилд нь хэвшүүлэх хэрэгтэй.

Мүда-г арилгах

Нэг мүда нь өөр нэг мүдаг бий болгож байдаг. Тоёота үйлдвэрийн үүсгэсэн Total Product System-г практикт хэрэгжүүлж “Хэрэгцээтэй түүхий эд, хэрэгцээтэй тоо ширхэгээр, хэрэгцээтэй үйлдвэрлэлийг явуулах” гэж арга барлыг хэрэгжүүлэх шаардлагатай санагдсан. Мөн Нэг дамжлагаас нөгөө дамжлага хүртэл алдаагүй бүтээгдэхүүн гарах гэсэн бодлогыг үйлдвэртээ хэрэгжүүлэх шаардлагатай.

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулан, сургалтууд зохион байгуулж эхэлсэн.

Хүнээ байнга, тасралтгүй сургах хэрэгтэй ба үүний тулд компанийхаа сургалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан гаргаж, хэрэгжүүлж эхлээд байна. Сургалтын төлөвлөгөөндөө, зөвхөн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхээс гадна 5S, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, багаар ажиллах, хувь хүний соёлын талаар сургалт хийхээр оруулсан.

3S-г хэрэгжүүлэлтийг эхлүүлэхээр төлөвлөж байна.

Бидний хувьд 3S-г урт хугацаанд тогтвортой байлгахын тулд цаашдын стратегийн төлөвлөгөөндөө 3S-н хэрэгжүүлэлтийг оруулж өгсөн байна. Мөн хэрэгжүүлэхээсээ өмнө ажилчиддаа сургалт хийж байгаа.

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

Сургалт маш их үр өгөөжтэй, үр дүнтэй болсон.

Aircon Service компанийн захирлын сургалтаас магтаалын хуудас болон бүх ажилчид байгууллагынхаа төлөвлөгөө боловсруулалтанд оролцдог нь зөв санагдсан.

Ямада Сэйсакүшо компанийн 3S хэрэгжүүлэлт нь манай байгууллагад ойрхон санагдсан тул өөрсдийн загвар аж ахуй компаниар тодруулсан. Тус компани хэрэгжүүлж байнга маш энгийн зөв хэрэгжүүлж байсан.

Японоос ирээд Өглөөний хурлыг тус компанийн загвараар явуулсан нь үр дүнтэй байгаа тул байнга хэрэгжүүлж байна.

6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга(Компани эсвэл өөрийн бие дээр)

Ажлын байрны орчингийн аюулгүй байдлыг төмөр хаалтаар бус санамж самбарууд болон

ажилчдадаа сайн ойлгуулж хэвшүүлэхээр ажиллаж байна. 3S хэрэгжүүлэхээр төлөвлөгөөгөө боловсруулж байна.

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Сургалтад ойлгож авснаа хэрэгжүүлэхээс өмнө өөрийн байгууллагын маш судлаж хэрэгжүүлэх хэрэгтэй.



5S хэрэгжүүлсэн жишээ
Агуулахын тавиурын дугаарлалт

2019 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

Нэр: **Л.Гэрэлмаа**
 Албан тушаал: **Борлуулалтын менежер**
 Үндсэн сургалт төгссөн он: **2019**



| | |
|-------------------------|---|
| Компанийн нэр: | Лайфтроник ХХК |
| Байгуулагдсан он: | 2014 |
| Үйл ажиллагааны чиглэл: | <ul style="list-style-type: none"> • Лабораторийн тоног төхөөрөмж, хэрэгсэл, урвалж оношлуур импортлон ханган нийлүүлэх • Тоног төхөөрөмжийн суурилуулалт • Мэргэжлийн сургалт • Техник үйлчилгээ, баталгаат засвар |
| Ажилчдын тоо: | 22 |

Компанийн товч танилцуулга

1997 онд Эрүүл мэндийн салбарт хувийн хэвшлийн анхны шинжилгээний лаборатори Гялс ХХК байгуулагдсан.

2014 оны 2-р сард Гялс ХХК-ийн Хангалт Борлуулалтын албанд итгэл хүлээлгэн онцгой эрхтэй дистрибьютер компаниудыг шилжүүлж, бие даасан компани болох шийдвэрийг ТУЗ-аас гаргав. Бүрэн бие даасан компани болсон тул Лайфтроник ХХК гэж нэрлэсэн.

Бид Эрүүл Мэндийн Яамнаас Эмнэлгийн тоног төхөөрөмж, урвалж оношлуур, хэрэгсэл ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж байна.

Алсын хараа

Лабораторийн хөгжлийг Монголд

Эрхэм зорилго

Шилдэг технологийг нэвтрүүлж, Чанарыг эрхэмлэсэн бизнесийг бүтээнэ.

Үнэт зүйл

Итгэл даах чадвар

Итгэл даасан чанар

Итгэлтэй хамтын ажиллагаа
Итгэлээр дүүрэн санаачлагч
Зөв дадал зуршил

Бидний уриа

Итгэл найдварыг “Эрүүл аз жаргалтай амьдрал” баталгаажуулна.



Ажиллах таатай орчин, урвалж, оношлуур хадгалах тусгай нөхцөлийн шаардлага хангасан агуулах бүхий 300 м2 талбай байранд үйл ажиллагаагаа явуулж байна.

Программын удирдлагатай автомат токарийн суурь машин ТМС-20

Үйлдвэрлэгч: NAKAMURA-TOME (Япон)



Монгол улсад албан ёсны дистрибьютерийн эрхтэйгээр дараах компаниудыг бид төлөөлж байна.

| | |
|----------|--|
| Франц | bioMerieux |
| Япон | Hitachi, Furuno, Fujirebio, Kokubo |
| Америк | Cepheid, Immucore, Thermofisher Scientific |
| Герман | Brand GBMH, Memmert, Hain Lifescience |
| Хятад | Mindray, Dirui, Abon, Acon |
| Солонгос | Seegene, Bioneer, |





1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

13. Сүүлийн жилүүдэд компани томрохын хирээр хүний нөөцийн бодлогод анхаарах, хэрхэн шийддэг, ажил үүргийн хуваарь, оффисоос гадуур ажиллах ажилчдын бүртгэлийг сайжруулах, урамшууллын системийг тодорхой болгох, КРІ хэрэгжүүлэх
14. Менежментийн талаарх ойлголт, практикт хэрхэн хэрэгждэг?
15. Компанидаа япон маягийн менежментийг хэрэгжүүлэх, судлах, эмх цэгц, ажлын бүтээмжийг дээшлүүлэх
16. Борлуулалтыг идэвхжүүлэх, зардлыг бууруулах үр дүнтэй аргууд, хэрэглэгч, ажилчдын сэтгэл ханамжийг хэрхэн дээшлүүлэх зэрэг тулгамдсан асуудал болж байгаа.

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

Удирдлага 2014 онд уг сургалтанд хамрагдаж, үйлчилгээ борлуулалт хийж буй компанийг үйлчилгээ тусдаа, худалдаа тусдаа хоёр компани болохоор хүсэлт гаргаж худалдааны чиглэлээр одоогийн манай компани үүсгэн байгуулагдсан.

Менежментийн хувьд

- Компанийн одоогийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг хамт олноороо хэлэлцэн, зорилго чиглэлдээ нийцсэн алсын хараа, эрхэм зорилготой болсон.
- Япон менежмент бага багаар хэрэгжиж байгаа.
- Стратегийн төлөвлөгөө 5 жилээр
- Хүний нөөцийг бодлого ажилчидаа хөгжүүлж, жил бүр гадаад, дотоодын сургалт, семинарт тогтмол хамруулдаг, тэгш боломж олгодог.
- Үргүй зардлыг хэрхэн бууруулах тал дээр байнга анхаардаг
- Компани ямар түвшинд байгаагаа тодорхойлж, цаашдын үйл ажиллагаанд анхаарч ажиллаж байна.

- Хүний нөөцийн стратеги, багийнхантай харилцах арга, уулзалт хийхэд анхаарах, хэрхэн урамшуулах, бодлогыг хэрэгжүүлсэн.
- Санхүүгийн хичээлээр мөнгөний үнэ цэнийг үнэлэх, борлуулалтын авлагад менежмент хийж ангилах, агуулахын барааны үлдэгдэлд анхаарах, шинэ программ нэвтрүүлж төрөл бүрийн анализ хийх боломжийг нэвтрүүлсэн.
- Паретогийн зарчмаар харилцагч, бүтээгдэхүүн, борлуулалтыг ангилж ажиллах болсон.

5S нэвтрүүлэх бэлтгэл ажлыг алхам алхамаар хийж эхэлсэн.

- Оффис дотор гутлаа солих
- Цонхны хаалт (тоосны хамгаалалт)
- Оффисын гэрэлтүүлэг, эмх цэгц, компьютерийн утаснууд цэгцлэлт
- Цонхны хөшиг
- Ажилчдын ширээний эмх цэгц
- Оффис дотор чийгшил үүсгэх Загасны аквариум
- Канон ашиглах заавар Монгол хэл дээр
- Агуулахын барааны хаягжилт
- Хүйтэн хэлхээ, Гааль-Агуулах, Агуулах-Хэрэглэгч
- Шинэ ажилтануудын дадлага (гааль, түгээлт, агуулах)
- Хурдан шивэлтийн дасгал хийх, (арван хуруу)
- Ангилал үүсгэж фолдерт хадгаладаг, хэлтэс нэгжүүдээр
- Мэдээлэл дамжуулах дотоод сүлжээ (Share нь 4 хатуу дисктэй)
- Агуулах, хөргүүрийн өрөө
- Дэлгүүргүй болсон
- Сургалтын хэлтэс үүсгэсэн
- ERP систем (Enterprise Resource Planning)
- Ажилтан бүр шинэ санаа хөтөлбөр

Урвалж, оношлуурын тээвэрлэлт


-20⁰ С хэмд хадгалах зориулалттай урвалжийг тээвэрлэнэ.

2-8⁰ С хэм, 15-30⁰ С хэмд хадгалах урвалж, оношлуур, багаж, тоног төхөөрөмж зэргийг тээвэрлэнэ.



Оффисын ширээний дор байрлах цахилгааний утас

Өмнө нь



Дараа нь



Агуулахын зохион байгуулалт



Агуулахыг цэгцэлж замд яваа бараа, борлуулалт хийх бэлэн бараа зэргийг ангилж, байршлын хаягжилтыг соронзон наалтаар шийдсэн.

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

Дадлага сургалтаар маш их зүйл сурсан, гол нь хүний тархинд биш, сэтгэл зүрхэнд ойлгуулах хэрэгтэй гэдгийг нүдээрээ харж мэдэрлээ.

Борлуулалтыг идэвхжүүлэх, зардлыг бууруулах үр дүнтэй аргууд хоорондын хамаарал


- Борлуулалтыг идэвхжүүлэх аргууд /үзэсгэлэн, нэг цэгийн худалдаа, POP, VMD-харахад хялбар, сонгоход хялбар, худалдан авахад хялбар, Антен шоп, зах зээлийн судалгаа, мэдээллийн бааз бүрдүүлэх/



VMD-харахад хялбар, сонгоход хялбар, худалдан авахад хялбар



POP сурталчилгаа: сэтгэлд хүрсэн үгс *Аавийнхаа баяртай байгаа царийг харахыг хүсч байна.*



- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх замаар борлуулалтыг нэмэгдүүлэх /арр, бүтээгдэхүүний бий болсон түүхийг ойлгуулах, SNS/
- Борлуулалтын дараах үйлчилгээг сайжруулах
- Борлуулалтын хувь хэмжээнээс хамаарсан урамшуулал /хувьцаа, урамшуулал/
- CIS=EIS үйлчлүүлэгч, ажилтны сэтгэл ханамж тэнцүү байх тогтолцоо

| Үйлчлүүлэгч | Ажилтан | Компани |
|--|--|---|
| Үнэ, үйлчилгээ, сэтгэл ханамж, урамшуулал бонус Юу хүсч байгаа, ямар сэтгэлийн хөдөлгөөнтэй байгааг мэдэрч харьцах Үйлчлүүлсэн давтамжаас хамаараад албан тушаал Борлуулалтын дараах үйлчилгээ | Ажилтан тогтвортой ажиллах урам зориг /хандлага/ Таатай орчин Хөдөлмөрийн нөхцөл, цалин урамшуулал Сонгон шалгаруулалт Ятган сэнхрүүлэх, борлуулах | ХҮН-ийг чухалчлах <ul style="list-style-type: none"> • Тогтмол үнэлгээ хийх, цалин нэмэх • Ганцаарчилсан уулзалт тогтмол • Ажлын байрны шилжилт хөдөлгөөн • Сургалт явуулах • Нийгмийн халамжийн тогтолцоо |
| <ul style="list-style-type: none"> ● Эмх цэгц, зарчимтай, шантрашгүй, цаг барьдаг чанарууд ● Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ цэнийн талаарх цогц ойлголт ● Үйлдвэргүй үйлдвэрлэгч тогтолцоо, менежмент | | |
| <p>Үйлдвэрлэлийн процесс, удирдлагын арга барил</p> <ul style="list-style-type: none"> ● ALL WIN зарчим /Үйлдвэрлэл, боловсруулалт, борлуулалт/ ● JUST IN TIME ● Канбан хуудас ● МҮДА-г арилгах ● Кайзен ба бүтээмжийн хамаарал, 5S-ийн ач холбогдол ● Үйлдвэргүй үйлдвэрлэгч тогтолцоо, менежмент ● “Шинэ ажилтны ангилсан сургалт, хандлага” ● “Ажилтан хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа” ● Хүний нөөцийн бүрдүүлэлт хэрхэн хийх ● Тоёота, Панасоник компаниас үйлдвэрлэлийн менежмент хэвшил болсон байгааг Кайзен, 5S, ХАБ зэргээс харав. ● Магтаалын хуудас, өглөөний шуурхай | | |
| <p>Хүний нөөцийн менежмент</p> <ul style="list-style-type: none"> ● Ажилчдын ур, чадварыг нэмэгдүүлэх тасралтгүй сургах тогтолцоо | | |

- Хүний нөөцийн үнэлгээний систем
 - a) Зорилго тодорхойлох хуудас-ажилчдын ур чадварыг сайжруулах зорилгоор тоон, чанарын үнэлгээгээр зорилгод суурилсан аргуудаар үнэлэх
 - b) Хүний нөөцийн үнэлгээний хуудас-өдөр тутам, сар бүр, улирал тутам ажлын төлөвлөгөөг ажилтан тус бүрээр гаргах, биелэлтийг дүгнэх, цаг ашиглалт идэвх санаачлагыг дүгнэх
- Оролт гаралтын судалгаа, анализ хийх, цаашдын төлөвлөгөөг гаргах
- Ажилтан бүрийн оролцоотой менежментийн тогтолцоо, төлөвлөгөөг боловсруулах
- Урамшууллын систем
- Хувь хүн бус, хамтын хүч, насан туршид ажиллах итгэлцэл

Үйлчилгээний стандарт

- Чин сэтгэл хүндлэл, хайрлах ухаан
- 5S кайзэн, хөтөлбөр хэрэгжүүлэхийн ач холбогдол
- “ХҮН”-ийг чухалчлах
- Ажилчдын ур, чадварыг нэмэгдүүлэх тасралтгүй сургах тогтолцоо
- Музейгээр дамжуулах бизнесийн философийг олон нийтэд таниулах, суралцах талбар болгосон байдал.



5S

Компаний тасралтгүй хөгжих зорилгийг урт хугацаанд хэрэгжүүлэх арга хэрэглэгдэхүүн юм.

1. Хэрэгтэй хэрэггүй зүйлийг ангилна.
2. Хэрэгтэй үед шууд хэрэглэхээр цэгцлэнэ
3. Үргэлж цэвэрхэн байлгах
4. Дээрх 3S-ийг хэвшил болгох
5. Баримтлах, зуршил болгох

Зургийг www.google.com хайлтаар татаж авав.



Кайзен 5S-ийн зарим жишээ

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Япон хүмүүсийн тэсвэр тэвчээр, тасралтгүй суралцдаг чанар, хичээнгүй, үнэнч, аливаад чин сэтгэлээсээ хандах хандлага, цаг баримтлах зэргийг нүдээрээ харж, компани нийгмийн хариуцлагаа ухамсарлаж, хүнээ дээдэлдэг менежментийг харлаа. Мянга сонсохоор нэг үз гэдгийн адилаар Бизнес сургалтаар заасан бүхнийг практикт хэрэгжиж байгааг харахад нүдэндээ итгэхгүй ч үе байсан. Тийм л гайхалтай бодитоор хэрэгжсэн байсан.

Сургалт зохион байгуулалт маш сайн, дэг журамтай, төрөл бүрийн салбарын үйл ажиллагаа явуулдаг компани, дэлгүүр, үйлдвэр, сургуулиар дамжуулж маш олон зүйлийг таниулсан нь үр дүнтэй, сурсан мэдснээ бататгаж үр дүнгийн семинар, тайлан гаргаж хэрэгжүүлэх ажлын жагсаалтыг гаргаж байсан нь чанарыг илтгэнэ. Дадлага сургалтанд хамрагдах боломжийг олгосон ЖАЙКА ОУ-ын байгууллага, Рело Панасоник Интернэйшнл ХХК, Монгол Япон төв, Компанийн удирдлагадаа талархал илэрхийлье.

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

Сургалтын багш, орчуулагч, туршлага судалсан компаниуд, удирдлагуудын лекц зэрэг өндөр сэтгэгдэл төрүүлсэн сурах, хэрэгжүүлэх олон ажил байгааг олж харсан. Компанийн удирдлага “ажилчид амьдралынхаа чухал мөч 18-65 насыг ажлын байрандаа өнгөрөөдөг чухал үеэ үргүй ажил хийж дэмий өнгөрөөвөл тэр хүмүүсийн амьдралыг үл хүндэтгэсэн болно” гэсэн хандлага, өөрчлөгдөх ёстой нь ажлын талбар бус менежмент, компанийн хөгжил бол хувь хүний хөгжил юм зэрэг үзлийг тэмдэглэх нь зүйтэй.

CIS=EIS тогтолцоог онцлон сонгож хэрэгжүүлэх

1. Тогтолцоог хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах
2. Хэрэглэгчийн болон ажилтны сэтгэл ханамжийн судалгааг авах
3. Судалгааны үр дүнд шинжилгээ, дүгнэлт хийх
4. Цаашид авах арга хэмжээг тодорхойлох

5. Ажилтан, хэрэглэгч дээр урамшууллын бодлого журам боловсруулах

Диваажингийн үг ба тамын үг

Үгний утга өөр өөр, хүлээж авах нь өөр өөр, тиймээс үгийг сонголт хүртэл маш чухал.
 “Мэдээжийн хэрэг” гэхийг “**Баярлалаа**” гэвэл талархал болно.
 “Тэгээд яасан гэж” гэхийг “**Баяр хүргэе**” гэвэл магтаал болно.
 “Ерөөсөө чадахгүй нь” гэхийг “**Одоо дөнгөж эхэлж байна шүү дээ**” гэвэл эрмэлзэл болно.
 “Тийм болох юмсан” гэхийг “**Заавал тийм болно**” гэвэл шийдвэр болно.
 “Одоо яршиг” гэхийг “**Дахиад жаахан хүлээе**” гэвэл тэвчээр болно.
 “Ядарчихлаа” гэхийг “**Сайн хичээсэн шүү**” гэвэл чармайлт болно.

Өглөөний шуурхай

Зорилго: Хувь хүний хөгжил, олны өмнө ярих чадвар, хэлэх гэсэн санаагаа товч тодорхой ярьдаг, цаг хугацаанд багтаж ойлгуулдаг болох, мөн компанийн ажилчдын дотоод уур амьсгалыг сайжруулж, нэг хамт олон болоход чиглэгдэнэ. Зорилгоо өөрчлөхгүйгээр арга барилаа өөрчлөхөд аливаа ажилд илүү үр дүн авчирдаг.

Хамрах хүрээ: Бүх ажилчид /Өдөрт 2 ажилтан ярих/

Хэзээ: Ажлын өдөр бүр байнга

Үргэлжлэх хугацаа: Өглөө бүр 8:20-8:30 минутын хооронд



Ямада Сэйсакүшо ХК-ийн өглөөний шуурхай

Магтаалын карт

Чин сэтгэл хүндлэл,

Могтайнай буюу Хайран юм

Сайжруулалт Кайзэн, 5S нэвтрүүлэх бэлтгэх хангах, нэвтрүүлж эхлэх

6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга(Компани эсвэл өөрийн бие дээр)

4. Шинэ ажилтны дасан зохицох хөтөлбөр цогц сургалт, гарын авлага
5. Сайжруулалт Кайзэн, 5S нэвтрүүлэх бэлтгэх хангах, нэвтрүүлж эхлэх
6. Ажилтан бүр сард нэг шинэ санаа, кайзэн сайжруулалт
7. Өглөөний шуурхай хэрэгжсэн.
8. Ажилтан, хэрэглэгчийн урамшууллын тогтолцоо

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Цаг баримтлах, бусдадаа төвөг удах
- Японд очсон л бол соёл, уламжлал, япон хүний тэвчээртэй тууштай, үнэнч хандлага, хичээнгүй байдал, компанийн менежментийг олж хараарай.
- Сургалтын хичээл бүрт тэмдэглэл хөтлөх, ингэснээр үр дүнгийн тайлан, семинар, МЯТ, Жайкад тайлан, компанийн тайлан зэрэгт маш их хэрэг болдог. Өөрийн тэмдэглэл хэзээд нүдэнд харагдаж толгойд бодогддог шүү дээ.
- Сургалтаар авсан мэдлэгээ бусадтай хуваалцах, Сургалтад ойлгож авснаа богино хугацаанд хэрэгжүүлэхийг хичээх хэрэгтэй. Хугацаа алдах тусам мартагдах шинжтэй байна.
- Заавал бүхнийг хэрэгжүүлэх биш, монголчлох, өөрийн компанийн нөхцөл байдал, онцлогт тохируулан өөрчилж хэрэгжүүлэх хэрэгтэй.

2019 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

Нэр:


Ч.Халтмаа

Албан тушаал:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
нарийн бичгийн дарга

Үндсэн сургалт төгссөн он:

2018



| | |
|-------------------------|-----------------------------|
| Компанийн нэр: | Скайтел ХХК |
| Байгуулагдсан он: | 1999 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Харилцаа холбооны үйлчилгээ |
| Ажилчдын тоо: | 500 |

Компанийн товч танилцуулга



ЭРХЭМ ЗОРИЛГО / MISSION STATEMENT

ирээдүйг өнгөлнө ...



ХЭТИЙН ЗОРИЛГО / VISION

ДИЖИТАЛ ДЭВШИЛД МАНЛАЙЛАГЧ



ҮНЭТ ЗҮЙЛС / VALUES

ЭРЭМГИЙ

- Ялагч сэтгэл зүйтэй, эрэмгий байна
- Шиндэг шийдлийг бахархалтайгаар хүргэнэ

ХУРДТАЙ

- Эрдэм чадвар хосолж ундарна
- Хурдтай, чадварлаг үйл ажиллагаа

ХАРИУЦЛАГАТАЙ

- Үйлс бүхэн маань ҮНЭН байна
- Итгэлцэл хүндлэлээр өс суртал тагширнэ

ХАМТДАА

- Гар нийлэхэд ирээдүй нийлнэ
- Үйлсээ бүтээж үндэстнээ гэрэлтүүлнэ



SKYtel
Mongolian First Broadband Network Company

ШИНЭ БЭЛГЭДЭЛ БҮЮУ ЛОГОНЫ ТАЙЛАЛ

Манай шинэ бэлгэдэл гурван өнгөнөөс бүтнэ. SKAYtel компаний нэр өөрөө Тэнгэрийн Холбоо гэсэн утгатай. Тиймээс бид Тэнгэрийн өнгөөд орших угтга санаа агуулсан гүн хөв өнгийг сонгосон. Нарны торлон туна, эрч хүчээр тэнгэр вад тэмүүлэх хурд хүнийг өдрө тутам хамгийн энгийн зүйлээр төлөөлүүлэх санааг хадгалсан. Үүнийг цагаан өнгөөр ариун гэгээнийг бэлгэдлээ. Аз жаргалын энгийн шийдэл зүрх сэтгэлийн хөлөг онгоц.

ТЭНГЭР

Тэнгэр бол цагцалшгүй, агуу, орон зай, хязгааргүй, мөнх, ирээдүйг илтгэдэг

ҮҮЛ

Үүл нь хур бороо, хөнгөн, ариун, мөрөөдөл, шим, баялаг гэсэн утгатай

НАР

Нар бол шинэ, ирээдүй, амьдрал, гэрэл гэгээ, энерги, эрч хүчний илэрхийлэл.



“СКАЙТЕЛ” ХХК

“Тэнгэрийн Холбоо” нэртэй СКАЙтел компани 1999 онд үйл ажиллагаагаа явуулж эхэлснээр, үүрэн холбооны салбарт жинхэнэ шударга өрсөлдөөнийг бий болгож чадсан юм. Өнөөдөр СКАЙТЕЛ компани чанарын удирдлагын ISO9001:2008 стандартыг хэрэгжүүлэгч, Монголын 100%-ийн хөрөнгө оруулалттай Үндэсний групп компанийн түвшинд хүртлээ өргөжин, Монгол орон даяар 41 үндсэн салбар, 26 гэрээт салбар, 5300 гаруй гэрээт борлуулагчдаараа дамжуулан, хэрэглэгчдэдээ үйлчилгээний шинэ хэв маягаар, тав тухтай орчин нөхцөлд үйлчилж, хэрэглэгчдийнхээ сэтгэл ханамжийг өндөр байлгахын төлөө компанийхаа үнэт зүйлс, хэтийн зорилго, эрхэм зорилгоо чандлан ажиллаж байна.

Хэрэглэгчдэдээ энгийн, найдвартай, төлбөрийн уян хатан нөхцөлтэй бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх үүднээс “Үнэ тарифаа хүссэнээрээ удирдах” боломжтой Урьдчилсан төлбөрт үйлчилгээ, “Дугаартайгаа хүссэн багцаа сонгон ашиглах, хэрэглээний аливаа хязгаарлалтгүй” дараа төлбөрт үйлчилгээ, орчин цагийн хүн бүрийн зайлшгүй хэрэгцээ “Дата” үйлчилгээг олон таатай хувилбартайгаар санал болгодог. Дэлхийн 240 орчим орны 760 гаруй операторын сүлжээнд өөрийн дугаараасаа холбогдох боломжтой олон улсын роумингийн цогц үйлчилгээ, олон улсын ярианы World call 002 гарц, утасгүй интернэтийн үйлчилгээ, мөн технологийн дэвшлээр дэлхийд жишиг тогтоогч Samsung, Huawei зэрэг брэндийн гар утсыг албан ёсны эрхтэйгээр худалдах зэрэг үйлчилгээг үзүүлж байна. СКАЙтел компани Хамгийн өндөр хурдны, өргөн зурвасын хөдөлгөөнт интернэтийн 3G, 4G LTE сүлжээг Монгол орны 21 аймаг, 350 орчим сум сууринд байгуулж чадсан, Монголын №1 Дата оператор ба үнэнч ууган хэрэглэгчид болон шинэ хэрэглэгчдийнхээ Ирээдүйг улам Өнгөлөхийн төлөө брэндийн буюу мөн чанарын шинэчлэл хийсэн. Амьдралын үнэ цэнэтэй хором мөч бүхнийг дотны хүмүүстэйгээ цаг алдалгүй хуваалцах, найдвартай, амьд харилцааг бий болгох нь СКАЙ брэндийн чин эрмэлзэл юм.

“СКАЙМЕДИА КОРПОРАЦИ” ХХК

Монгол улсын мэдээлэл технологийн салбарт Скай Си энд Си нэртэйгээр 2000 онд байгуулагдаж, үйл ажиллагаа, цар хүрээгээ өргөжүүлсээр “Скаймедиа Корпораци” ХХК болон хөгжсөн түүхтэй. Олон улсын ярианы чиглэлээр үйл ажиллагаагаа эхэлж, өдгөө шинэ үеийн IPTV, хөдөлгөөнт интернэтийн “Telemax” үйлчилгээ, мөн суурин утас, өндөр хурдны интернэтийн “Дөрвөлсөн үйлчилгээ”-г цогц шийдлээр нь айл өрх болон байгууллагын хэрэглэгчдэд хүргэж байна. Тогтвортойгоор үйл ажиллагаа явуулсан 12 жилийн хугацаанд бид үндэсний хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж, өөрийн шилэн кабелийн сүлжээ, IPTV, Wimax утасгүй технологи, шинэ үеийн VoIP технологийг хамтад нь хөгжүүлснээр давтагдашгүй, цогц шийдлийг хэрэглэгчдэдээ санал болгож чадсан.

Өрхийн хэрэглээнд зориулсан цогц шийдэл:

- Ай Пи ТВ /IPTV/
- Шилэн кабелийн интернэт
- IP76 суурин утас

Байгууллагын хэрэглэгчдэд зориулсан цогц шийдэл

- Гурвалсан үйлчилгээ /Ай Пи ТВ, Интернет, Суурин утас/
- Шилэн кабелийн интернет
- IP76 суурин утас
- Дата центр, албан ёсны эрхтэй программ хангамжууд, лизенцийн үйлчилгээ
- Cloud call center service

“СКАЙНЭТВОРКС” ХХК

Манай компани дэлхийн стандарт шаардлагыг бүрэн хангасан шилэн кабелийг ашиглаж, үндэсний хэмжээний нэгдсэн тоон сүлжээг байгуулах зорилготойгоор 2005 онд анх байгуулагдсанаас хойш УБ хотод 1700 км, хөдөө орон нутагт 5000 км, нийт 6700 км үргэлжилсэн өндөр хурдны шилэн кабелийн суурь сүлжээг амжилттай бүтээн байгуулсан. УБ хотын нийт барилга байгууламжийн 80 гаруй хувь, хөдөө орон нутагт 13 аймгийн төв, 65 сум суурин газруудыг өөрийн шилэн кабелийн сүлжээнд холбоод байна. Манай хамт олны шаргуу хөдөлмөр, нөр их хүчин чармайлтаар бий болсон үндсэн сүлжээ (IP/SDH/GPON) нь хэрэглэгчдэд үүрэн холбооны 3G үйлчилгээ, орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан IPTV, Интернет, суурин утасны цогц үйлчилгээг хүлээн авах таатай боломжийг бий болгож чадлаа. Мөн манай сүлжээгээр дамжуулан төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд интернетэд зориулсан өндөр хурдны тоон урсгал, салбар хоорондын өндөр нууцлал бүхий VPN холболт байгуулан ашиглаж байна.

Скайнэтворкс ХХК-ий үйлчилгээнүүд:

- Өндөр хурдны 1Mbps-100Mbps-ийн урсгал түрээслэх
- Байгууллагын салбар хоорондын онлайн холболт
- FE/E1 урсгал
- Хот хоорондын түрээсийн суваг/урсгал

1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

17. Менежментийн талаар онолын цогц мэдлэгтэй болох
18. Компанидаа япон маягийн менежментийг бүрэн хэрэгжүүлэх
19. Компанийн засаглалыг сайжруулах, сайн туршлагаас суралцах

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

1. Компанийн стратеги, санхүү, маркетинг, борлуулалт, хэрэглэгчийн үйлчилгээ, хүний нөөц байгууллагын соёлын чиглэлээр шинэ зүйл сурч мэдсэн. Компанийн дунд шатны удирдах ажилтнуудыг менежментийн болон удирдан манлайлах ур чадварыг сайжруулах сургалт, шинэ ажилтнуудыг чиглүүлэх сургалтанд хамруулсан.
2. Ялангуяа стратеги төлөвлөлтийн свот анализ хэсэгт сурсан шинэлэг зүйлүүдээ компанийн

бизнес төлөвлөгөө, өөрийн хариуцсан чиглэлээр үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулахад ашигласнаар төлөвлөгөөний зорилт, хэмжүүр үзүүлэлт, хүлээгдэх үр дүнгийн хувьд сайжирч төлөвлөгөөг илүүг бодитой төлөвлөх болсон.

3. Компанидаа маркетинг, борлуулалт, хэрэглэгчийн үйлчилгээний процессын үр ашгийг үнэлэх зорилгоор маркетингийн төлөвлөгөөт ажлуудын үр дүн, процессийг шалгаж байна.
4. ТУЗ-ийн хяналт, компанийн засаглалын чиглэлээр ажлаа сайжруулах зорилгоор ТУЗ-өөс ГУ-ийн багт өгсөн үүрэг даалгавар биелэлтийг шалган, хангуулах чиглэлээр ажиллаж байна.

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

Япон компаниудын туршлага судлан, Япон маягийн менежментээс маш их зүйл суралцаж, компанийн холбогдох захирлуудад сурсан мэдсэнээ харамгүй хуваалцлаа. Үүнд дараах зүйлүүдийг онцолж байна.

1. **Оосакагийн Технологийн Их Сургуулийн** багшийн заасан хичээлд дурдсан 5S KAIZEN МУДА аргачлалын дагуу Компанид 3S хэрэгжүүлэх зорилгоор ажлын байрны цэвэрлэгээ, бичиг цаасны болон бусад хог хаягдлыг ангилан, ялган, хаях “One hand” компани ажлыг 2019 оны 10 сард өрнүүлсэн. Энэ ажлын хүрээнд зөвхөн хог хаягдалын ангилан, хаяснаар хэрэглэгдэхгүй бараа материалыг худалдан авахгүй байх, цаг тухайд нь ялган хаяж хэвших, зэрэг нь компанийн үргүй зардлыг бууруулж, илүү үйлдэлийг хасч МУДА-г хэрэгжүүлэх эхний алхам боллоо.

- SEIRI-Ангилж ялгах. Үүнд Ямада сейсакушо ХХК-ийн туршлагын дагуу шууд буюу өдөр тутам хэрэглэр зүйл, ойрын 6 сард хэрэглэх зүйл гэж агуулахын болон оффисын эд зүйлийг ангилан ялгалаа.
- SEITON- Эмхэлж цэгцлэх
- SEISOU- Цэвэрлэх ажлын хүрээнд хог хаягдлыг тогтмол ангилан ялгаж цэвэрлэж хаядаг боллоо.
- МУДА – Үргүй зардлыг бууруулах

Оосакагийн Технологийн Их Сургуулийн 2012 оны тусгай лекц уншсан Тобита Коожиро багшийн “Өөрчлөгдөх ёстой нь ажлын талбар бус менежмент юм” гэсэн үг маш чухал үг байна.



ONEHAND хөтөлбөрийн хүрээнд байрлуулсан АНГИЛАН ЯЛГАХ хогийн саванд дараах зааврын дагуу хогоо ангилан ялган хийж хэвшээрэй.

ЦЭНХЭР САВ буюу ЦААСАН хог хаягдал

- Осонгүй
- Үдэсгүй
- Элдэв бохирдолгүй
- Шохойтой хэвэл, Сэтгүүл, Боршур, гялгар цаас, хэрэглэсэн салфетка зэргийг хийхгүй байх

ШАР САВ буюу ХУВАНЦАР, ШИЛ, ГЯЛГАР УУТ

- Хуванцар болон шилэн савны доторх шингэн зүйл, бохирдолыг асгаж хийх
- Гялгар уутыг доторх бохирдолыг энгийн хог хаягдар руу хийсний дараа шар сав руу хийх
- Чихрийн цаас, кофены уут, хатуу уут шар сав руу хийхгүй энгийн хог хаягдал руу хийх

УЛААН САВ буюу энгийн хог хаягдал

- Бусад бүх хог хаягдалыг хийх
- Аль хогийн саванд хийх талаар эргэлсэн тохиолдолд энгийн хог хаягдалын сав руу буюу улаан саванд хийх

Таны ангилан ялгасан хог дахин боловсруулах төврүү илгээгдсэнээр байгууллагын хог хаягдалыг бууруулахаас гадна эх дэлхийдээ оруулж байгаа үнэтэй хувь нэмэр болох болно.

2. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг эрхэмлэн, дээд зэрэгт хүргэж ажилладаг “**AP company**” ХХК-ийн туршлага манай компанийн үйлчилгээний соёлыг дээшлүүлэх, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг сайжруулахад үнэтэй зүйл болж байна. Ялангуяа хэрэглэгчийн сэтгэл ханамж гэдэг бол ажилчдын сэтгэл ханамжтай эн тэнцүү ухагдахуун гэдгийг Компанийн удирдлагадаа ойлгуулан, байгууллагын соёлын судалгаа, ажилчидын сэтгэл ханамжийн судалгааг компани өөрсдөө биш анх удаа мэргэжлийн судалгааны байгууллагаар хийлгэж байна.

CIS=EIS (Customer Impressive Satisfaction=Employee Impressive Satisfaction)

Судалгааны үр дүнд шинжилгээ дүгнэлт хийж, компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүний нөөцийн албанаас ажилчдын сэтгэл ханамжийг сайжруулах ажлууд хийгдэнэ.

3. Манай компани Скаймедиа үйлчилгээний хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авах хөтөлбөр боловсруулан, судалгааны асуулгыг илүү дэлгэрүүлж, зорилтот хэрэглэгчийн тоо байршлыг тодорхойлон, хүлээгдэж буй үр дүнгээ нарийвчлан гарган, судалгааг илүү чанартай хийхийг зорьлоо. Судалгааны үр дүнд компаниас үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээний аль хэсэг нь хэрэглэгчид таалагдахгүй, сэтгэл ханамжийн үзүүлэлт бага гарч буй талаар дэлгэрэнгүй шинжилгээ хийснээр цаашид хийгдэх ажлуудыг тодорхойлон, ирэх оны бизнес төлөвлөгөөнд тусган батлуулж, хэрэгжүүлэхээр боллоо.
4. “Aircon Service” ХХК-ийн борлуулалтын дараах үйлчилгээнээс манай компанийн инженер техникийн ажилтнууд шууд хэрэгжүүлж болохуйц дараах туршлагыг судаллаа. Скайтел ба Скаймедиа үйлчилгээний хэрэглэгчийн гомдлыг бууруулахад үйлчилгээ дэмжлэгийн инженерүүдийг 1-2 дугаар түвшинд ажиллуулж, сүлжээ үйлчилгээний чанарын стандартыг дээшлүүлэх боломжтой боллоо.
5. “Ямада сейсакушо” ХХК-ийн сайн туршлагад үндэслэн Сүлжээ ашиглалтын албаны хийдэг өглөөний шуурхай хурлын үеэр сонгогдсон ажилтан 2 минутын яриа нэмэлтээр хийж байх нь багийн ажиллагааг сайжруулах нэг арга гэж үзлээ.

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

1. Сургалтын нэгдсэн хөтөлбөрийг батлуулан, сургалтууд зохион байгуулах. Аливаа компани ажилтнаа тасралтгүй сургах мэдлэг ур чадварыг нэмэгдүүлж байх хэрэгтэй ба үүний тулд компанийн 2020 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд саналаа тусган, батлуулан хэрэгжүүлэх нь чухал юм. Сургалтын төлөвлөгөөнд зөвхөн мэргэжлийн сургалт төдийгүй, 5S кайзен, мудагийн тухай ойлголтууд, бүтээмж болон багийн ажиллагаа, удирдах ажилтнуудад Япон компаниудаас сурсан Япон маягийн менежментийг хуваарийн дагуу танилцуулж ойлгуулах нь зүйтэй гэж үзэж байна.
2. Бүтээмжээ сайжруулах, дижитал дэвшилд манлайлах зорилгын хүрээнд үйл ажиллагааны үр

ашгийг нэмэгдүүлэх, шийдвэр гаргах хурлыг сайжруулсан, дотоод процессыг хялбаршуулсан, гар ажиллагааг автоматжуулсан, хүн цаг хэмнэсэн программыг эрчимтэй нэвтрүүлэх хэрэгтэй байна.

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

Сургалтын чанар маш сайн, агуулгын хувьд мэдээ мэдээллээр баялаг, маш их үр өгөөжтэй болсон. Хичээлийг заахдаа онол, практик хослуулсан нь миний хувьд их шинэлэг байлаа. Сургалтын үед чухал гэж үзсэн зүйлсийн зургийг гар утасны камераар авч өөртөө хадгалах боломжийг зарим Япон багш нар маань олгож байсанд маш их талархаж байна, энэ нь сургалтаар олж авсан мэдлэг туршлагаа бусадтай хуваалцахад илүү түргэн шуурхай, бодит материал болох сайн талтай.

6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)


1. “Панасоник” ХХК-ийн үүсгэж байгуулагч **Мацүшита Коносүкэ** гэж алдартай хүний менежментийн философи, дэлхийн түвшинд ажилладаг “Тоёота” ХХК гэх мэт олон жилийн туршид тогтвортой үйл ажиллагаа явуулж бизнесээ өргөжүүлсэний гол нууц нь менежментийн философи, алсын хараа, урт хугацааны төлөвлөгөөг маш сайн боловсруулж, тодорхойлон хэрэгжүүлсний үр дүн бөгөөд энэ нь тухайн компанийн засаглал сайн байх тулгуур үндэс гэж үзсэн тул компанийн засаглал менежментийг сайжруулахад шинэ шинэ санааг авч хэрэгжүүлэхийг хүсч байна.
2. Хувь хүний тухайд өөрийн ажлын байр, ажил үүргийн хувьд мудаг арилгаж, илүү процесс, үйлдлийг хасах, хүн хүч төсвийг зөв төлөвлөх хуваарьлах хэрэгтэй гэж дүгнэлээ.

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

1. Сургалтаар олж авсан мэдлэгийг аль болох олон хүнд хүртээж, сургалтыг идэвхтэй үе үе зохион байгуулж, мэдлэг мэдээллээ сэргээж байх хэрэгтэй болов уу, энэ нь уг сургалт компанийн хэрэгжүүлж буй ажлуудад хэр үр дүнгээ өгч буйг дүгнэх боломж юм.
2. Өөрийн компанийн нөхцөл байдалдаа тохируулан бага багаар аажмаар өөрчлөлт хийхийг зөвлөж байна. Учир нь Япон болон Монгол хүний сэтгэлгээ, компанийн соёл өөр өөр тул бүгдийг нэр дор хэрэгжүүлэх цаг хугацаа, хүн хүчний хувьд боломжгүй гэж үзэж байна.

2019 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

Нэр: **А. Уянга**
 Албан тушаал: **Дэд захирал**
 Үндсэн сургалт төгссөн он: **2019**



| | |
|-------------------------|---|
| Компанийн нэр: | Инвекор проперти менежмент ХХК |
| Байгуулагдсан он: | 2017 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Үл хөдлөх хөрөнгийн менежментийн үйлчилгээ, зөвлөгөө, судалгаа, зуучлалын үйлчилгээ |
| Ажилчдын тоо: | 30 |

Компанийн товч танилцуулга

2017 оны 11 сард Япон Монголын хамтарсан SIBJ Holdings компанийн хөрөнгө оруулалтаар байгуулагдсан.

Үл хөдлөх хөрөнгийн менежментийн цогц үйлчилгээг Япон стандартын дагуу хэрэгжүүлж ажиллаж байна.

Нийтдээ 30 ажилтантай, оффисын 3 барилга, тансаг зэрэглэлийн 1 орон сууцны менежментийн үйлчилгээг удирдаж ажиллаж байна.

УДИРДАЖ БУЙ ТӨСЛҮҮД



ТӨСӨЛ БҮР ДООРХИ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛЖ АЖИЛЛАДАГ



ХҮН ТӨВТ ТӨЛӨВЛӨЛТ



ТӨСӨЛ БҮРДЭЭ БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ БАЙХ ЗАРЧМЫГ БАРИМТАЛДАГ




1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

1. Менежментийн талаар онолын цогц мэдлэгтэй болох
2. Компанидаа япон маягийн менежментийг бүрэн хэрэгжүүлэх

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

Компанийн бүх ажилчдыг хамруулсан 3 удаагийн системтэй сургалт зохион байгуулсан. Сургалттай хамт компанийн 2020 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг багийн хүрээнд эхлүүлсэн.

1. Япон өв соёлыг таних нь, Япон менежментийн нууц
2. Хэрэглэгчийн сэтгэл ханамж = Ажилчдын сэтгэл ханамж /ажилчдын дунд талархалын хуудас дамжуулах ажил зохион байгуулсан/
3. 5S, Кайзен, Мүдаг хэрхэн арилгаж бүтээмжийг нэмэх тухай сургалт.





5S хөдөлгөөний идэвхжүүлэлт

5S-н баг, хамрах хүрээг тодорхой болгосон. Шилдэг кайзэнгийн талаар нийт ажилчдад танилцуулдаг. Энэ нь бусдад санаа өгөх, сэдэлжүүлэх зэрэг ач холбогдолтой болсон. 5S хэрэгжүүлсэн жишээ.



Инженер техникийн алба, Харилцагч үйлчилгээний алба, Захиргаа хүний нөөцийн алба тус бүр дээр 5S хэрэгжүүлэх 2 сарын аян заралсан. 2019 оны шинэ жилийн баяр дээр шилдэг алба болон шилдэг ажилтанг шагнаж урамшуулж бусдад идэвхи өгнө.

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

Японы хөгжлийн гол нууц нь өв соёлоо дээдлэгч байдал, эмх цэгцийг бүх шатанд бүрдүүлэх (5S + Кайзен + Мүдаг арилгах), хүнийг хүндлэх, хүний үнэ цэнийг мэдрүүлж хүнээр ажил хийлгэх ухаан, шилдэг удирдагч нараас манлайлал жинхэнэ агуу манлайлал гарч байсан тухай ойлгосон. Өнөөдрийн амьрал түүхээс бүтсэн байдаг бүх хүний чин сэтгэл, хүч хөдөлмөрийн хүчинд өнөөдрийн хөгжилд хүрсэн улс байна.

Хүний нөөцийг хөгжүүлэх

Бүх зүйлсийн үндэс суурь нь хүн. Мэдлэг, техник, хөрөнгө, эд юмсыг зөвөөр ашиглах нь хүн.

Хүн бизнесийг хийдэг. Бүтээгдэхүүнийг хүн хийдэг. Хүн зардаг. Зөв хандлагатай хүн болгон сургаж чадахгүй бол чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж чадахгүй. Менежмент ч сайн явахгүй. Тийм учраас эхлээд хүнээ сургах, зөв хүн болгох хэрэгтэй юм байна. Хүний зөвхөн сайн, давуу талыг олж харж, түүнийг нь л ашиглах хэрэгтэй гэж ойлгосон.

5S хөдөлгөөнийг илүү хэвшүүлэх, идэвхжүүлэх

Менежментийн зорилгодоо хүрэх зам бол 5S. 5S бол зүгээр нэг эмх цэгц, цэвэрлэгээ, цэвэр цэмцгэр байдал биш юм. Хүнээ зөв хүн болгоход чинь туслах арга, тэр зорилгодоо хүрэх зам маань юм байна гэдгийг ойлгосон. 5S-г хэрэгжүүлэх нэг арга нь өрсөлдүүлэх өөрөөр хэлбэл багуудад хуваагаад, хооронд нь өрсөлдүүлэх. Тэгээд өрсөлдөөнийг ил тод, ойлгомжтой байдлаар дүгнэх хэрэгтэй.

Ажилчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх

Ажилчин сэтгэл хангалуун байж байж хэрэглэгч сэтгэл хангалуун байна. Ажилтан бүрийн оновчтой саналыг удирдлагын түвшинд авч хэрэгжүүлэх тусам компани улам хөгжин, өсөн дэвжинэ. Ажилчид өөрсдөө бие дааж хийх нь чухал. Харин хийх нөхцлийг нь бүрдүүлж өгөх хэрэгтэй. Ажиллах орчин эрүүл, аюулгүй байх ёстой. Нөхцлийг нь бий болгож, бүрдүүлж өгчихөөд дараа нь авах хэрэгтэй гэсэн үг.

Мүда-г арилгах

Нэг мүда нь өөр нэг мүдаг бий болгож байдаг. Тоёота бол хамгийн муу мүдаг “Юмыг хэтрүүлж үйлдвэрлэх” гэж үздэг. “Их хэмжээгээр үйлдвэрлээд хадгалчихад болно”, “Агуулахдаа их бараатай байхад болно” гэсэн бодол нь эргээд юмыг сайжруулъя гэсэн санааг үндсээр нь үгүй болгодог. Цаг нь тулсан юман дээр их зүтгэл, санаа гарч ирдэг.

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулан, сургалтууд зохион байгуулж, бодит байдалыг багийн гишүүн бүрт ойлгуулж, хэрэгжүүлж эхэлсэн.

Ажилтан бүртэй уулзаж сургалтын хэрэгцээ шаардлагыг судлаж үзсэний дагуу тухайн хүнд тохирсон сургалт хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, байнга, тасралтгүй сургах хэрэгтэйг ойлгож хэрэгжүүлж эхлээд байна. Сургалтын төлөвлөгөөндөө, зөвхөн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхээс гадна 5S, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, багаар ажиллах, хувь хүний соёлын талаар сургалт хийхээр оруулсан.

5S-г бүрэн хэрэгжүүлэхээр зохион байгуулалтууд хийж байна.

Нийт ажилчдаа алба нэгж тус бүрээр нь хувааж /ИТА 5 хүн, Харилцагч үйлчилгээний алба 12 хүн, Борлуулалт маркетингийн алба 6 хүн, захиргаа санхүү хүний нөөцийн албыг тус тус нь хуваарилаж 4 баг болгон хуваасан. Хариуцах хэсэг, хэрэгжүүлэх цаг, хяналт тавих зэргийг тодорхой болгож өгсөн. Өдөр бүр өглөө, орой 5 минут, долоо хоногийн Баасан гаригт 20 минут хийнэ. Хороо байгуулсан ба 7 хоног бүр хэрэгжилтийг шалгаж, үнэлгээ өгч байгаа. Шалгах хүснэгтийг сайжруулсан ба уг хүснэгтийн дагуу шалгана. Мөн 5S-н самбартай болсон. Хэрэггүй зүйлсийн тавиуртай болсон. Багууд хэрэггүй гэсэн зүйлсээ уг тавиур дээр тавих ба бусад багт хэрэггүй бол хаяна.

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

Сургалт маш их үр өгөөжтэй, үр дүнтэй болсон. Хичээлийг заахдаа онол, практик хослуулсан нь их ойлгомжтой болгосон. Энэ нь бас бусдад заахад туршлага болно.

Тоёота компанийн, анх гар нэхмэлийн машиныг сайжруулан автомат болгож, мөн Панасоник компанийн ердийн чийдэнгийн патроныг сайжруулж анхны үйлдвэрлэлээ эхэлж байсан нь аливаа юм хамгийн энгийн зүйлээс эхэлдэг юм гэдгийг ойлгуулсан. Аливаа ажлыг байнга, тасралтгүй сайжруулж байх хэрэгтэй. Сайжруулсныгаа дахиад сайжруулах хэрэгтэй гэсэн үг. Тэгж байж амжилтанд хүрдэг юм гэдгийг эндээс ойлгож байна.

6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга(Компани эсвэл өөрийн бие дээр)

Хүний нөөцийг хөгжүүлэх гарын авлага боловсруулах, шинээр ажилд орсон хүнийг анхнаас нь сургах дасан зохицох хөтөлбөр боловсруулахаар төлөвлөж байна. Ажилтан бүртэй ганцаарчилсан нөхцөл тохирох уулзалтыг зохион байгуулж, удирдлага ажилтан гэсэн хөндий заагийг халж, илүү дотно хамтын зорилготой болж хөгжих тал дээр анхаарч ажиллах. Мөн удирдлагын багаас энэхүү зардал хуваах аялалд явуулж хамтын ойлголттой болохыг хүсч байна.

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Сургалтад ойлгож авснаа богино хугацаанд хэрэгжүүлэхийг хичээх хэрэгтэй. Хугацаа алдах тусам мартагддаг. Шууд хамтран ажиллах багаа бүрдүүлж, төлөвлөгөөний дагуу ажиллах. Төлөвлөгөөнийхөө дагуу хэрэгжилтэнд хяналт тавих.

Өөрийн компанийн нөхцөл байдалдаа тохируулан өөрчилж хэрэглэ. Бүх юм шууд таарахгүй.

2019 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

Нэр: Д.Уянга
 Албан тушаал: Гүйцэтгэх захирал
 Үндсэн сургалт төгссөн он: 2019



| | |
|---|--|
| Компанийн нэр: | Бөмбөгөр Пропертис ХХК |
| Байгуулагдсан он: | 2018 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Үл хөдлөх хөрөнгийн менежмент Гадаад худалдаа |
| Ажилчдын тоо: | 20 |
| Компанийн товч танилцуулга | |
| <p>Алсын хараа: Шинийг эрэлхийлж, шилдгийг бүтээнэ.</p> <p>Уриа үг: Амжилтыг сэтгэл ханамжтайгаар хамтдаа бүтээнэ.</p> <p>Бидний эрхэм зорилго: Эерэг сэтгэлгээгээр хөгжих боломжийг хүн бүрт олгож, шинийг санаачлагч, чадварлаг, тууштай хамт олноор жигүүрлэн, бизнесийн таатай нөхцлөөр хэрэглэгч үйлчлүүлэгчдээ дэмжиж, хамтдаа тасралтгүй хөгжих замаар үнэ цэнийг бүтээнэ.</p> <p>Үнэт зүйлс:</p> <p>Багийн сэтгэлгээ:</p> <p>Зорилго нэгтэйгээр мэдлэг мэдээллээ хуваалцан, итгэлцэл, хүндэтгэлтэй эерэг дулаан орчныг бий болгож харилцан суралцаж хариуцлагатайгаар нэгэн зүгт алхдаг.</p> <p>Тогтвортой хөгжлийн зарчим:</p> <p>Нийгмийн хариуцлагаа ухамсарлан, тасралтгүй урагшлах зарчмаар хүний хөгжлийг дэмжин ажилладаг</p> <p>Чин сэтгэл:</p> <p>Компанийн ажилтнууд нэгэн гэр бүл мэт өөриймсөг байж харилцан хүндэтгэлтэйгээр бүх нөөц</p> | |

бололцоогоо дайчлан ажилладаг

Манлайлал:

Зөв тууштай шинийг санаачлагч байж, бусдыгаа манлайлалд уриалдаг

Үнэнч шудрага:

Үнэнч шудрага байдлыг мөрдлөг болгон, хуулиа дээдэлсэн ёс зүйтэй хамт олон байна

2018 оны 10-р сард үүсгэн байгуулагдсан ба үйл ажиллагаа анх эхлэхдээ зөвхөн үл хөдлөх хөрөнгө менежмент буюу түрээсийн үйл ажиллагаа эрхэлдэг байсан бол 2019 оны 3-р сараас Гадаад худалдаа эрхэлж, дэлхийд танигдсан брэнд дэлгүүрийн Монгол дахь албан ёсны төлөөлөгч болсон билээ.



1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

1. Компанийн стратеги төлөвлөлтийг хийх арга техникт суралцах
2. Хүний нөөцийн хөгжлийн бодлогыг боловсруулах үр дүнтэй аргуудад суралцах, хэрэгжүүлэх

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ?

Компанид гарсан өөрчлөлт

- Компанийн 2019 оны стратеги төлөвлөлт, богино болон дунд хугацааны төлөвлөгөөг суралцсаны дагуу гаргасан
- Санхүүгийн тооцооллын хүснэгт сайжруулж, шинэчлэл хийгдсэн
- ROE,ROI улирал бүр тооцдог болсон
- Зээлийн хүүгийн тооцооллыг хийх аргачлал бий болгосон
- Цаашид хийгдэх санхүүтэй холбоотой төлөвлөлтүүд гарсан
- Хүний нөөцийн бодлогын бичиг баримтууд шинэчлэгдсэн
- Сонгон шалгаруулалтын үйл явц сайжирсан /Ярилцлагад оролцогч бүрт зориулсан асуултууд бэлтгэдэг болсон, сонгон шалгаруулалтын дасгал ажлууд шинээр /
- Сургалт, хувь хүний хөгжлийн төлөвлөгөөнүүд гарсан
- [20190213 Ярилцлагын асуултууд.xlsx](#)

- [20190215 Дасгал, ажлууд.xlsx](#)
- [20190424 Байгууллагын сургалтын төлөвлөгөө.xlsx...](#)

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

Нийгмийн хариуцлага

- Нийгмийн хариуцлагын ач холбогдол
- Нийгмийн хариуцлагаа биелүүлэх санаанууд

Хүний нөөцийг хөгжүүлэх

- Ажилтан бүр Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйлсээ ойлгохын ач холбогдол
- All win зарчим / Хэрэглэгч үйлчлүүлэгч
- Та бол “Эрхэм нэг хүн” / Ажилтан бүр бизнесийн чухал бүрэлдэхүүн
- Ажилтны сэтгэл ханамж=Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж
- Шинэ ажилтны дасан зохицох хөтөлбөрийн ач холбогдол
- Хүний нөөцийн бодлого хөгжүүлэлтийн шалгарсан арга техникүүд
- Ажилтнуудаа хэрхэн урамшуулах арга техникүүд

Бизнесийн процессын сайжруулалт

- 5S хэрэгжүүлэхийн ач холбогдол болон хэрэгжилтийн шилдэг жишээнүүд
- Муда буюу үргүй зардлыг хор хөнөөл, түүнийг хэрхэн бууруулах аргууд
- Ажлын процессын хуваарилалтаа сайжруулах
- Борлуулалтаа нэмэгдүүлэх арга техникүүд

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсээ тодорхойлсон

Компанийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсээ компанийн ажилтнуудтайгаа хамтарч тодорхойлж, бүгд нэгдсэн ойлголтод хүрсэн.

Сургалтын төлөвлөгөө боловсруулж, зохион байгуулж эхэлсэн

Жишээ нь: Өдөр бүр Чойрэй буюу шуурхай хурал зохион байгуулж, тус хурал дээр ажилтан бүр өөрийн дуу хоолой, санал, санаачлагаа бусадтайгаа хуваалцаж байна.



5S-ийг хэрэгжүүлэх алхмууд

Жишээ нь: Хавтаснууд өнгөний кодтой болж, тус тусын өнгийн дагуу материалуудаа хадгалж эхэлсэн.

Оффисын өрөөний эмх цэгц



Хүний нөөцийн бодлогын сайжруулалтууд

Суралцсаны дагуу ажилтнуудыг идэвхжүүлэх, ажилтны сэтгэл ханамжийг дээшлүүлэх арга хэмжээнүүд зохион байгуулж байна.

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

Сургалт маш их үр өгөөжтэй, үр дүнтэй болсон. Сургалтад хамрагдах явцад лекц сонсчихоод дараа нь түүний хэрэгжилтийг үйлдвэр эсвэл компанитай нь явж танилцсанаар санааг хэрхэн ажил болгогдгийг нүдээрээ харсан нь сургалтын үр дүнг нэмэгдүүлсэн. Үүгээрээ бусдад сургахад дөхөм болсон.

6. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга(Компани эсвэл өөрийн бие дээр)

Байгууллагын соёлыг төгөлдөржүүлэх

Менежмент сайжруулах төлөвлөгөө боловсруулах

Хүний нөөцийн баримт бичиг, гарын авлагууд боловсруулах

7. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

- Цаг баримтлах
- Суралцах зорилгоо сайтар тодорхойлох
- Суралцах явцад байгууллагаа өөрчлөхийн тулд хувь хүн “Би” хэрхэн өөрчлөгдөхөө тодорхойлох

2016 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

Нэр: Д.Бат-Эрдэнэ
 Албан тушаал: Инженер
 Үндсэн сургалт төгссөн он: 2019



| | |
|---|---|
| Компанийн нэр: | Мон-Шибасаки ХХК |
| Байгуулагдсан он: | 2005 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Автомашин жижиг эд ангийн үйлдвэрлэл |
| Ажилчдын тоо: | 38 |
| Компанийн товч танилцуулга | |
| <p>2005 онд Япон улсын Шибасаки сэйсакүшё компанийн хөрөнгө оруулалтаар байгуулагдсан.</p> <p>Суудлын болон ачааны автомашины тормос, жолооны хүрд, суудал, хөдөлгүүр мөн хурдны хайрцагт угсрагддаг жижиг эд ангийг бөөнөөр үйлдвэрлэдэг.</p> <p>Нийтдээ 40 ажилтантай ба үйлдвэрлэл 24 цагаар тасралтгүй явагддаг.</p> <p>55-н төрлийн бүтээгдэхүүнийг өндөр нарийвчлалтайгаар зорж боловсруулан Япон улс руу экспортолдог.</p> <p>2012 оноос MNS ISO 9001:2010 чанарын удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн ба 2018 онд MNS ISO 9001:2015 болгон сайжруулсан.</p> <p>Тоног төхөөрөмжийн хувьд Япон улсад үйлдвэрлэсэн программын удирдлагатай автомат болон гар ажиллагаатай бага оврын гэсэн нийт 34 суурь машинтай. Программын удирдлагатай автомат суурь машин 17 ширхэг байдаг.</p> | |



Программын удирдлагатай автомат
токарийн суурь машин MURATEC

Үйлдвэрлэгч: MURATEC (Япон)



Программын удирдлагатай автомат
токарийн суурь машин TC-100

Үйлдвэрлэгч: TAKISAWA (Япон)

Гар ажиллагаатай суурь машинууд:



1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

1. Өөрийн мэдлэгээ дээшлүүлэх
2. Менежментийн талаар онолын мэдлэгтэй болох
3. Компанидаа Япон маягийн менежментийг хэрэгжүүлэх

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

1. Ажилчиддаа тайлан тавьж сурсан зүйлээ танилцуулсан



**Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн
ТӨВ**

БИЗНЕСИЙН СУРГАЛТ

(Менежерийн анги)

**Мон-Шибасаки ХХК
2019.02.01**

2. QC буюу чанарын дугуйланг хэрэгжүүлж, баг тус бүрээр нь үнэлж дүгнэдэг аргаа сайжруулсан.

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

Тоёота автомашины үйлдвэрээс




Just in time
(Яг цагтаа)

- Шаардлагатай зүйлийг шаардлагатай хугацаанд шаардлагатай тоо хэмжээгээр үйлдвэрлэх

Ухаалаг
автомат-
жуулалт


- Дамжлага тус бүр дээр чанартай бүтээгдэхүүнийг гүйцэд үйлдвэрлэх
- Доголдолтой бүтээгдэхүүнийг дараагийн дамжлагаруу явуулахгүй

Осака Технологийн Их сургуулиас



Өөрчлөгдөх ёстой нь ажлын талбар биш менежмент юм.

ALL WIN - Систем



-Ажилтны сэтгэл ханамж=Хэрэглэгчийн сэтгэл

Эдгээр зүйлсийг сурч мэдэж авлаа.


4. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

Сургалт маш их үр өгөөжтэй, үр дүнтэй болсон. Хичээлийг заахдаа онол, практик хослуулсан нь их ойлгомжтой болгосон. Энэ нь бас бусдад заахад туршлага болно.

Тоёота компаний сайжруулан автомажуулалт, мөн Панасоник компани зэргийг үзэхэд аливаа юм хамгийн энгийн зүйлээс эхэлдэг юм гэдгийг ойлголоо. Аливаа ажлыг байнга, тасралтгүй сайжруулж байх хэрэгтэй. Сайжруулсныгаа дахиад сайжруулах хэрэгтэй юм байна.

5. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)

- Шинэ ажилчдаас ур чадварын шалгалт авах
- 「MOTTAINAI -хайран юм」 -ийг хэргэжүүлэх



- Бүх ажилчдаас сэтгэл ханамжийн судалгаа авах хөтөлбөр боловсруулахаар төлөвлөж байна.

6. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Сургалтад ойлгож мэдэж авснаа богино хугацаанд цаг алдалгүй хэрэгжүүлэх. Аливаа юмыг дуурайхаасаа илүү аж ахуй нэгждээ болон ажилчиддаа тааруулж өөрчилж хэрэгжүүлээрэй. Бүх юм шууд таарахгүй.

Тоёота компаний үйлдвэр

how quality cars are assembled.

Production Process

Stamping
Cut steel sheets are inserted in a press machine to make vehicle parts such as the hood and door. The "drawing process" utilizes advanced technology to shape the steel sheets in three dimensions.

Welding
The car body is made by joining many press parts. Various welding methods are used depending on the material and the shape of the part.

Painting
A primer coat is applied to prevent rust and then several coats of paint are applied to give the body a beautiful color. Centrifugal force and electricity are used to paint every area of the body.

Assembly
A variety of parts are assembled in the body to complete the car. We aim for an assembly line which can change its length freely according to the production volume based on market demand.

[Process Flow]

- 1 Electrical wires and computer-related parts are installed
- 2 Engine and parts that transmit power from the engine to the tires are installed
- 3 Parts such as the windshield, seats, and steering wheel are installed

Main production models * Some models can not be seen in the plant tour

| | | |
|-----------------|-------|---------|
| Motomachi Plant | Crown | MIRAI |
| Takasaki Plant | RAV4 | HARRIER |
| Tsutsumi Plant | Prius | Camry |

Машин үйлдвэрлэлийн дамжлага




Сургалтаа амжилттай төгссөн мөч

2019 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

Нэр: О.Сэндэгмаа

Албан тушаал: Захирал

Үндсэн сургалт төгссөн он: 2019



| | |
|------------------------|---------------|
| Компанийн нэр | ТИТЭМ-УВС ХХК |
| Байгуулагдсан он | 2015 |
| Үйл ажиллагааны чиглэл | Худалдаа |
| Ажилчдын тоо | 15 |

Компанийн товч танилцуулга



Титэм-Увс ХХК нь Увс аймгийн Улаангом хотод худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Компанийн үүсгэн байгуулагч О.Сэндэгмаа 2001 оноос гоо сайхны худалдаагаар түрээсийн байранд бизнесийн гараагаа эхэлж байсан билээ. Бизнес өргөжихийн хэрээр үйл ажиллагаагаа тэлэн 2013 оны 11 сард “Титэм” худалдааны төвөө нээсэн. 2015.04.06-нд “Титэм-Увс” ХХК-аа үүсгэн байгуулсан. Тус компани нь Хятад болон Орос улсаас бичиг хэрэг, бэлэг дурсгал, гоёл чимэглэлийн барааг импортоор оруулж ирдэг худалдааны байгууллагаа юм. Титэм-Увс компанийн Титэм Худалдааны Төв дэлгүүр нь гоо

сайхан, бичиг хэрэг, бэлэг дурсгал гоёл чимэглэлийн гэсэн 4 тасагтай, 1 салбар дэлгүүртэй. 2018 оны “Аймгийн Тэргүүний Худалдаа үйлчилгээний байгууллага”-аар шалгарч байсан.

Монгол-Японы төвийн Бизнесийн үндсэн сургалтанд суух болсон шалтгаан

1. Менежментийн талаар онолын цогц мэдлэгтэй болох
2. Компанидаа япон маягийн менежментийг хэрэгжүүлэх

Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ?**Компанид гарсан өөрчлөлт**

- Манай байгууллагын ажил урьд ямар ч төлөвлөлтгүй урсгалаараа явдаг байлаа. Сургалтанд сууснаар байгууллагын стратеги төлөвлөлтөө хийдэг болсон. Байгууллагын зорилго зорилтоо боловсруулж, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан явцад нь хяналт тавьж үр дүнг тооцдог болсон. Үүний үр дүнд бүх ажил төлөвлөлтийн дагуу явагдаж ажлын бүтээмж нэмэгдэж байгаа.
- Борлуулалтыг дэмждэг маркетингийн арга барилуудаас ялангуяа идэвхжүүлэлт ашигладаг боллоо. Үүний үр дүнд үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэж борлуулалт өссөн.
- Хүний нөөцийн тал дээр зааварчилгаа өгөх замаар МВО үнэлгээний аргыг хэрэглэж ажилтантайгаа хамтран зорилгоо дэвшүүлсэн. Явцын ярилцлага хийж үзсэн үр дүнтэй байгаа. Ажлын үнэлгээг цалин хөлстэй нь холбож урамшуулал олгох журам боловсруулснаар ажилтнуудын тогтвор суурьшил нэмэгдэх хандлагатай байна.
- Урьд нь санхүүгийн тайлангаа уншиж мэддэггүй байсан бол сургалтын дараа тайлангийн бүтэц, ялгаа, уялдаа холбоог мэддэг болсон. Санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж чаддаг болсон. Үүний дотор ашигт ажиллагааг хэрхэн шинжлэх, юун дээр анхаарахаа мэдэж авсан.

Шинжилгээний үр дүнг цаашдын ажлын төлөвлөлтөд тусгадаг болсноор эерэг үр дүнгүүд гарч байгаа. Жишээ нь: Урьд нь нарийн тоо тооцоололгүйгээр баримжаагаар захиалга хийдэг байсан бол одоо борлуулалтын тайланг үндэслэн компанид илүү ашиг авчрах хурдан эргэлттэй бараанууд дээр төвлөрч бараагаа татах болсон. Ашиггүй удаан борлуулалттай бараа татахаа зогсоосон. Үүний үр дүнд агуулахын барааны хэт үлдэгдэл багасч байнгын борлуулалт сайтай бараагаа цаг хугацаанд нь татдаг болсон.



Хамт олноороо ажлаа зөвлөн ярилцаж байгаа нь



Нүүр будалтын зөвлөгөө өгөх эвэнт



Ажилтантай явцын ярилцлага хийж ажлаа төлөвлөж байгаа нь



Арьс тодорхойлох оношилгоо хийж идэвхжүүлэлт хийж буй үйл явц

Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйлс

1. Байгууллагын философийн талаар

- Японд бидний зочилсон компаниуд өөр өөрийн өвөрмөц онцлог, өвөрмөц философитой байсан. Компаниуд дээр нийтлэг ажиглагдсан зүйл бол тэдгээр компаниудын үзэл баримтлал нь хүний төлөө, нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулах явдал байлаа. Компани нь үйл ажиллагаагаараа дамжуулан нийгмийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэх, ажилтан нь өөрийн хөдөлмөрөөрөө дамжуулан нийгэмд хувь нэмэр оруулж байгаагаа ухамсарласан байдаг нь маш бахархуштай санагдаж байлаа.
- Компани үүсэн байгуулагдсан түүх, бүтээгдэхүүн үйлчилгээ бий болсон түүх, үүсгэн байгуулагчийн философийг түүний үе хойч хадгалан, нийт ажилтнуудад танилцуулах нь компаниараа бахархах, мөн чанарыг ойлгоход тустай гэдгийг мэдэж авлаа. /Панасоникийн музей, Мацүшита Кооносүкэгийн музей, Тоёотагийн үйлдвэр, AP компани, Aircon Service г.м /

2. Дэлгүүр болон үйлчилгээний байгууллагын менежментийн онцлог

Дэлгүүрийн уриа болон менежментийн философи нь хүмүүсийн төлөө гэсэн сэтгэл нэвт шингэсэн байх юм. Жишээ нь: Такашима их дэлгүүр

Дэлгүүрийн уриа:

- Найдвартай бараа бүтээгдэхүүнийг хямд үнээр борлуулж өөртөө болон бусдад харилцан ашигтай ажиллах
- Бүтээгдэхүүний чанар, мэдээллийг үйлчлүүлэгч худалдан авагчдад тодорхой тайлбарлан нэг ч хуурамч үйлдэл, нуун дарагдуулалтгүй ажиллах
- Баян ядуугаас үл хамааран бүх үйлчлүүлэгчдэд эрх тэгш хандан үйлчлэх

Менежментийн философи:

“Хүнд итгэж, хүнийг хайрлаж, үргэлж хүмүүсийн төлөө хичээнгүйлэн ажиллана” гэсэн чин сэтгэлээр ажилдаа хандаж, нийгэмд хувь нэмрээ оруулна.

Үйл ажиллагаандаа баримтлах чиглэл:

- Сэтгэлд хоногших зочлох үйлчилгээг үзүүлэх
- Шинэ амьдралын хэв маяг, соёлыг бий болгох,
- Эх дэлхий, байгаль орчноо хайрлан хамгаалахын төлөө шантрахгүй зүтгэх
- Нийгмийн итгэлийг хүлээсэн үйл ажиллагааг зохион байгуулах

Дэлгүүрийн үйлчилгээ нь :

- Найрсаг зочломтгой байх
- Үйлчлүүлэгчийн хүлээлтэд нийцэх .
- Хүсэн хүлээснээс нь илүү үзүүлж чадах бодлого баримталдаг байна.

3S, Кайзен

Урьд нь 5S-ийг ажлын байрны эмх цэгц, цэвэр цэмцгэр байдал гэж ойлгодог байлаа. Гэтэл энэ нь маш өргөн хүрээтэй менежментийн хэрэгсэл болохыг Осакагийн Технологийн Их сургууль дээр Минагава профессорын лекцээс ойлгосон. 3S-ийг

- ✓ Эд зүйлс
- ✓ Үйлдэл хөдөлгөөн
- ✓ Байршил орон зай
- ✓ Мэдээлэл
- ✓ Сэтгэлгээ
- ✓ Цагийн менежмент дээр ч хэрэгжүүлж болно.

3S хийсний үр дүнд үйлдвэрлэл, үйлчилгээ, оффист ажлын бүтээмжийг нэмэгдүүлж болно. Ажил их үед ажил хийгээд л байгаа хэрнэ үнэ цэнэ болж чадаж байгаа ажил маш бага байдаг. Ажлын 10-20% нь үнэ цэнэтэй ажлууд байдаг. Бусад нь үргүй зардал буюу муда. Үргүй зардлыг аль болох Кайзен хийж сайжруулж, нэмүү өртгийг улам нэмэгдүүлэх ажлыг хийх ёстой. Үүний үр дүнд ажлын бүтээмж дээшилнэ. /Ямада компани, КТС үйлдвэр /

3. Хүний нөөцийг хөгжүүлэх талаар

Японд хүнийг чухалчилсан “Хүн төвтэй менежмент” хэрэгжүүлдэг болох нь бүх л компани дээр харагдаж байлаа. Эдгээрээс 2 компани дээр хэрэгжиж буй арга барилаас товчхон дурьдвал:

АР КОМПАНИ

- Компанийн эрхэм зорилгыг мэдрүүлэх, ажилтан ажлаараа дамжуулан нийгэмд ямар хувь нэмэр оруулж буйг мэдрүүлэх
- **Ажилчдын сэтгэл ханамж =Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж**

- Ажиллах таатай орчин бүрдүүл, “АЖИЛЛАХАД УРАМТАЙ КОМПАНИ” байх

AIRCON SERVICE

- Компаны мөрдөх дүрэм бий болгох
- Компанийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлахад бүх ажилчдын оролцоог дэмжих
- Ажилтан бүр төлөвлөгөөний дагуу PDCA циклээр өөрийн зорилгод хяналт тавьж сар бүр биелэлтээ тайлагнадаг.
- **Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж бидний баяр баясгалан философи.**
- Өглөөний шуурхай дээр мэдээлэл солилцдог.
- Магтаалын картыг хэрэгжүүлдэг.

Цаашид хэрэгжүүлэхийг хүсэж буй үйл ажиллагааны агуулга (Компани эсвэл өөрийн бие дээр)

- ✓ Такашима их дэлгүүр дээр танилцсан борлуулалтын арга барилуудыг хэрэгжүүлэхийг хүсэж байна. Үүний тулд одоо ашиглаж байгаа санхүүгийн программын ашиглалтыг сайжруулах борлуулалтад шинжилгээ хийх, хэрэглэгчдийн дата баазтай болох шаардлагатай байна
- ✓ Нийт ажилтнуудад 3S-ийн сургалтыг хийж, ажилдаа хэрэгжүүлэх талаар зөвлөмж өгөх, сайжруулалтын санал цуглуулах
- ✓ Өглөөний шуурхайг тогтмол хийж хэвших
- ✓ Магтаалын картыг хэрэгжүүлэх зэрэг олон ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Бизнесийн сургалтаар сурсан зүйлээ Япон оронд очиж нүдээр үзэх боломжийг олгосон ЖАЙКА болон Монгол-Японы төвийнхөнд маш их баярлалаа. Сургалтын агуулга болон орчуулга маш сайн байсан. Очсон газар бүртээ ихийг сурч мэдэж явлаа. Мөн Япон хүмүүсийн улс орныхоо хөгжлийн төлөө ямар агуу сэтгэлтэй болохыг мэдэрч, хэрхэн бие биенээ хүндэтгэн харьцдаг, бүх улс даяараа яаж ийм цэвэр цэмцгэр аж төрж чаддагийг гайхан биширч явлаа.

Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулан зөвлөгөө, анхааруулах зүйлс

- Цаг сайн баримтлах.
- Сурсан зүйлээ багаараа ярилцах нь маш гүнзгий тогтоогддог юм байна лээ.
- Цаг алдалгүй өөрийн компани дээр хэрэгжүүлж болох зүйлсийг төлөвлөгөө гарган хэрэгжүүлж эхлэх.

Зураг хавсаргав



Ямада 3S-н сургалтын үеэр



Осакийн их сургууль Минагава багшийн 3S-ийн сургалт



KTC 3S сургалт



Панасоникийн музей



Жайка Кансай оффис



Тоёота Мотомачи үйлдвэр



Токио цамхаг

2019 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

Нэр: **Б. Хулан**
 Албан тушаал: **Дэд захирал**
 Үндсэн сургалт төгссөн он: **2017**



| | |
|--|---------------------------|
| Компанийн нэр: | Монфүүдланд ХХК |
| Байгуулагдсан он: | 2014 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Хүнсний үйлдвэрлэл |
| Ажилчдын тоо: | 50 |
| Компанийн товч танилцуулга | |
| <p>Монфүүдланд ХХК нь 2014 оноос эхлэн хүний эрүүл мэндийг дэмжсэн, эх орондоо анхдагч хүнсний шинэ төрлийн Мовьёос нэрийн өглөөний хоол, Цэнэглэгч нэрийн овьёосны шахмал, Элдэвтэй гурил нэрийн ороомгийн гурил, Овьёосны зутан, Хөөрхөн нэрийн овьёосны бантан зэрэг бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэсээр байна.</p> <p>Монфүүдландчууд Монголчуудын улаан буудайн гурил, цагаан сахар, цавуулагийн хэрэглээг багасгахийг зорьж хэрэглэгчиддээ зориулан овьёос, бүхэл үр, самар, жимс, жимсгэнэ ааруул зэрэг байгалийн гаралтай түүхий эдээр хүнсний нэмэлт, хадгалагч бодисгүйгээр үйлдвэрлэж эхэлсэнээрээ онцлог.</p> <p>2018 онд Япон Монгол Төвийн ЗААН –ийн хөтөлбөрт хамрагдсан.</p> <p>2019 оноос ISO 9001:2015 чанарын удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэн ажиллаж байна.</p> | |
| 1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан | |
| <ol style="list-style-type: none"> 1. Үйлдвэрийн өргөтгөл, бүтээгдэхүүн хөгжүүлэлттэй холбоотойгоор менежментийн талаар суралцах 2. Компанидаа япон маягийн менежментийг нэвтрүүлэх | |

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

- ✓ Компанийн дотоод журам, хөдөлмөрийн дотоо журмыг сайжруулан шинэчилсэн
- ✓ Бизнесийн орчны шинжилгээнүүдийн тогтмол хийдэг болсон.
- ✓ “5 ЯАГААД” ыг хэрэгжүүлснээр аливаа санал гомдол, үл тохирлыг бүртгэн шалтгааныг олж залруулах арга хэмжээ авч хэрэгжүүлснээр үйл ажиллагаа сайжирсан улмаар ISO 9001:2015 чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд дөхөм болсон.
- ✓ Борлуулалтын ERP програм нэвтрүүлснээр харилцагчид, хэрэглэгчдийн дата байршлуудтай, борлуулагч жолооч нарын ажлыг хянах, зөв зохион байгуулах олон давуу талууд бий болсноор борлуулал маркетингийн албаны ажил хөнгөвчилсэн.
- ✓ Хүний нөөцийн ажлын байрны сургалт зөвлөгөө авснаар манай компанид томоохон өөрчлөлт болсон, ажлаас гаралтын тоо буурч, удирлагын баг, албадууд хоорондын харилцаа холбоо сайжирч ажлын бүтээмж нэмэгдсэн.
- ✓ 5S хөдөлгөөн хэрэгжүүлэхээр эхэлсэн.

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

1. Хүний нөөцийг хөгжүүлэх

Хамгийн удирдахад хэцүү, мөн үнэ цэнэтэй нөөц бол хүний нөөц байдаг.

Японы **АР** компани, Aircon service ХК, **Ямада сайсакушо** ХК, **Гогёфүкү** ХХК –ийн “Хүн” -ийг чухалчилдаг хүний нөөцийн удирдлагаас суралцсан. Үүнд:

- ✓ Сонгон шалгаруулалтад чухал шаардагдах зүйл
- ✓ Хэрэглэгчийн сэтгэл ханамж = Ажилтны сэтгэл ханамж
- ✓ Сургалт хөгжүүлэлт, Эрхэм зорилго хуваалцах сургалт
- ✓ Тогтмол үнэлгээ хийх, цалингийн систем, албан тушаал нэмэгдүүлэх
- ✓ Тогтмол ганцаарчилсан уулзалтыг хийх
- ✓ Тогтмол өглөөний шуурхайг хийх, магтах үйл ажиллагаа
- ✓ Хувь хүний хөгжлийн төлөвлөгөөг олон жилээр гаргуулах
- ✓ Компанийн нийгмийн халамжийн тогтолцоотой байх

2. 3S, 4S, 5S мөн чанар, ялгаа

Ямада сайсакушо ХК, КТС ХХК болон Тоёотогийн үйлдвэрийн -ийн амжилттай хэрэгжүүлдэг 3S хөдөлгөөнийг бодитоор харж мэдсэн.

3S бол = ҮЙЛ АЖИЛЛАГАА= ангилж ялгах, эмхэлж цэгцлэх, цэвэрлэх,

4S бол БАЙДАЛ= хэвшил, дадал зуршил, аюулгүй байдал

5S бол ИРЭЭДҮЙН ЗОРИЛГО = 3S хэрэгжүүлсэн байхад үлдсэн 2 S аяндаа бүрдэдгийг мэдэж авсанаар 5S хэрэгжүүлэн дадал болгох боломж байгааг харсан.

3. Мүда-г арилгах

Ажлын процессын хувиарлалтыг сайжруулан, 7 мудаг (үргүй зүйл, алдагдал) илрүүлж арилгах. Нэг мүда нь өөр нэг мудаг бий болгож байдаг (Минигава Кентаро). Ажлын процесс, дамжлага бүрт үргүй зардал байдаг.

Жишээ нь Тоёота бол хамгийн муу мудаг “Юмыг хэтрүүлж үйлдвэрлэх” гэж үздэг. Тиймээс агуулахын удирлага ч шаардлагатай байна.

4. Кайзэн хийх аргачлал

- Цомхотгох
- Нэгтгэх
- Дахин өөрчлөх
- Хялбарчлах

5. Борлуулалтыг сайжруулах

Сакура Интернэйшнл- ийн Бизнесийн яриа, Мэдээллийн санг хэрхэн бүрдүүлэх вэ, POP сурталчилгаа-үгс нь энгийн товчхон боловч хэрэглэгчийн сэтгэл татахуйц байхаар мэдээлэл өгөн ялгарах, шинэ бүтээгдэхүүн турших санал авах булан, үзэсгэлэн яармагт хэрхэн оролцох зэрэг борлуулалтын идэвхижүүлэлтийн талаар олон санал сонсож мэдэж авсан.


Гогёфүкү ХХК-ийн Юуг борлуулах, Хэрхэн борлуулах, Ямар хэрэгцээг хангавал борлуулагдах вэ гэсэн онцгой санаануудаас компанидаа өөрийн онцлогтоо тохиромжтойгоор хэрэгжүүлэхээр урам авсан.

6. Япон маягийн менежмент, бизнес философи

Миний харснаар Япон маягийн менежментийг товчхон үгээр тодорхойлвол **Цагийн юмыг цагт нь хийх, тууштай байдал**, аливаа бүхний зохион байгуулалт өөрийн гэсэн төрх нь **энгийн зохистой** байх (чамин хээнцэр бус), илүү үйлдэл **үргүй зарлагагүй, цэвэр байдал, эмх цэгцтэй, ая тух, тавтай байлгах соёл** нь юм байна гэж ойлгон Япон улсаар бахархсан.

2019 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

Нэр: Ц.Дагийсүрэн
 Албан тушаал: Чанарын менежер
 Үндсэн сургалт төгссөн он: 2019



| | |
|-------------------------|---|
| Компанийн нэр: | Монбейкери ХХК |
| Байгуулагдсан он: | 1998 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Талх, Нарийн боов,Бялуу,Хөнгөн зуушны үйлдвэрлэл,Кофе шопын үйлчилгээ |
| Ажилчдын тоо: | 190 |

Компанийн товч танилцуулга

Монбейкери ХХК нь 1998 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.Бид шинэхэн халуун талх, нарийн боов, бялууг хэрэглэгчидэд хүргэх таатай замыг бий болгохоор зорьж монголдоо анхдагч болж **INSTORE BAKERY** буюу дэлгүүр доторх цехийг Номин, Имарт зэрэг супермаркетуудын сүлжээ дотор тус тус нээж, Монбейкери брендийг амжилттай бий болгон үйл ажиллагаагаа явуулж байна.

Бид **Caffe bene, Caffe Ti Amo, Tous Les** зэрэг Дэлхийн алдартай бейкери, кофе шопыг нэвтрүүлэн үйлчлүүлэгч, харилцагчдынхаа ханамжийг дээшлүүлэн бейкери болон кофены Монголдоо шинэ түвшинд хүргэхэд томоохон нэмэр оруулсан билээ.

- ▶ Үндсэн үйлдвэрлэлийн цех-4
- ▶ Instore bakery-4
- ▶ Нэрийн Кофе шоп-5
- ▶ Нэрийн салбар лангуу-13



Jours

сэтгэл
соёлыг
хувь

- ▶ Нийт 190 гаруй ажилтан
- ▶ 200 гаруй харилцагчтай

1. Монгол-Японы төвийн Бизнесийн Үндсэн сургалтад суух болсон шалтгаан

1. Менежерийн ур чадвараа нэмэгдүүлэх
2. Компани нэг ойлголтой, нэг хэлээр ярьдаг болох

2. Бизнесийн үндсэн сургалтад сурсан зүйлээ компанидаа яаж хэрэгжүүлж байна вэ? Компанид гарсан өөрчлөлт

1. Удирдлагын менежмент, зохион байгуулалт сайжирсан.
2. Компанийн стратеги төлөвлөгөөг оновчтой төлөвлөх, багийн ажиллагаанд дэвшилт гарсан.

3. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл



Энэхүү цикл тасралтгүй харилцан хамааралтайгаар эргэж байж компани амжилтайгаар урт хугацаанд үйл ажиллагаагаа авч явах юм. Эдгээр 6 зүйлийг хангах болон сайжруулахад **5S, Муда, Тоёота үйлдвэрлэлийн менежмент** зэрэг олон жишиг менежментийн арга техникүүдийг ашиглан байнгын сайжруулалт /**Казейн**/ хийж байх нь чухал юм.

4. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

- Бизнесийн үндсэн сургалтын хичээлүүдээс олж авсан менежментийн арга аргачлалыг хэрхэн өөрийн компани дээр тохируулан амжилттай хэрэгжүүлэх.
- Сайн жишиг үйлдвэрлэл, үйлчилгээний практик туршлагатай танилцах

- Япон компаний үйл ажиллагааны менежмент, зохион байгуулалтаас өөрийн компанид тохирох сайн санааг олж авах
- Япон компаний соёл, урт хугацаанд бизнесийг нь авч явж буй арга барилаас суралцах зэрэг зорилго, хүлээлттэй явсан. Эдгээр тулгамдаж буй асуудлууд дээрээ гарц гаргалгаа олж авч чадсан 100% сэтгэл ханамж өндөртэй дадлага сургалт болсон.

5. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

9/3 AP company ХК

СУРЧ, МЭДСЭН ЗҮЙЛ

1. Байгууллагын ажиллах зарчим, зорилго, соёлын суурийг маш сайн тавьж үүдээ тулгуурласан хүрхүйн ажиллуудыг төлөвлөж түүнийгээ үнэцгээр хийх.
2. Ажилтаны хандлага, ажлын байрны уур амьсгалд байнга анхаарч урам зоригтой ажиллах нөхцлийг бүрдүүлж тасралтгүй сайжруулалт хийх ёстой.
3. Ажилтан хийж буй ажилгараа бахархах сэтгэгдэл төрөх үйл ажиллагааг зохион байгуулах.
4. Ажилтан нарынхаа ажлыг байрғы сольж ажлын уялдаа холбоог сайжруулан ажил бүрийн үнэ цэнийг ойлгуулах.

ХЭРЭГЖҮҮЛЖ БОЛОХУЙЦ, ТААЛАГДСАН САЙН ЖИШЭЭ

1. Олон нийтийн болон хамт олын сүлжээ ашиглан ажилтаны ажлыг үнэлэн урамшуулах.
2. Үйлчилгээний ажилтан нарын сургалтын систем

11

9/4 Aircon Service ХК

СУРЧ, МЭДСЭН ЗҮЙЛ

1. Компаний мөрдөх журам, соёл их чухал.
2. Ажилтанда байнга урам зориг өгч дэмжиж байх.
3. Хэт их тооны аргаас хооволдсон компани удаан орших тогтворгүй.
4. Компаний стратеги төлөвлөгөөнд ажилтан бүр оролцдог, мэдлэг нээлттэй тарааж өдөг.
5. Компани хүний төлөө, юуны төлөө ажиллаж байна гэж бодож хэрэгтэй.
6. Борлуулалтын дараах үйлчилгээ чухал гэдгийг ивэрүүлсэн.

ХЭРЭГЖҮҮЛЖ БОЛОХУЙЦ, ТААЛАГДСАН САЙН ЖИШЭЭ

1. Магтаалын карт өрнүүлэх
2. Борлуулалтын дараах үйлчилгээ, хэрэгтэйгээ халамжлах

13

9/4 Aircon Service ХК

• 1966 онд байгуулагдсан

• Ажилтны тоо 61

- Бүх ажилтнуудын оролцоотой компани / төлөвлөгөө боловсруулалт, хяналт /
- Өглөөний хурал болон магтаалын хуудас
- Ажилтнуудад зориулсан хувьцааны тогтолцоо
- Ажилтны хөгжил / Бие дааж бизнес эрхлэх тогтолцоо/



12

9/5 Тоёотагийн үйлдвэр

1. Тоёотагийн 2-т орох том үйлдвэр. Өлөрт 166-200 ширхэг машин угсарна.
2. 4 дамжлагын үйлдвэртэй. Шахалтын үйлдвэр, Гагнуурын үйлдвэр, Будгийн үйлдвэр, Угсралтын үйлдвэр Шалгах хэсэг.
3. Тоёота үйлдвэрийн үндсэн тулгуур багана болсон үйлдвэрлэлийн арга бол 1. Just in time Шаардлагатай зүйлийг шаардлагатай үед шаардлагатай тоогоор үйлдвэрлэх.
2. Jidoka-Автоматжуулах Нэг дамжлагаас нөгөөд шилжихд адлаатай бүтээгдэхүүн явуулахгүй байх.
4. Менежментэй сайжруулах 4 үндсэн арга.
 1. Казейн
 2. Нүүдэнд харагдах байдлаар асуудлыг шийлэх
 3. 5Why
 4. Муда (Үргүй зардлыг багасгах)
5. Шинэ ажилчиддаа хурд шалгах тоглоом тоглуулж шалгадаг, дадлагажуулдаг.



17

9/6 Зарчим, ёс журамд тулгуурласан Кайзэн хөдөлгөөнийг өрнүүлэх аргачлал /SS Кайзэний талаарх семинар/

Оосака технологийн их сургууль, Инженер технологийн сургууль, Байгаль орчны инженерийн гэхимийн профессор Минагава

- Хөдөлмөрийн бүтээмжтэй байдлыг чухалчилсан SS Кайзэн үйл ажиллагаа
- SS-ийг хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлээгүй үеийн ажлын бүтээмжийн ялгааг ойлгуулж өгсөн багын ажил болон практик дасгалууд



18

9/6 Зарчим, ёс журамд тулгуурласан Кайзэн хөдөлгөөнийг өрнүүлэх аргачлал /SS Кайзэний талаарх семинар/

СУРЧ, МЭДСЭН ЗҮЙЛ

1. Казейн гэрээг үр өгөөжтэй хийх аргууд
2. Ажлын байрны эмх цэгц SS
3. Казейн хийх арга техник, сэтгэлгээ сууцаг
4. Хэд хэдэн үүрэг даалгаваруудыг гэрээг үр дүнтэй гүйцэтгэх
5. Удирлага ажилтан нарын үр чадвар, ажлын орчин нөхцөлд тааруулан зохиистой шаардлага тавих.
6. Бүтээмжийг нэмэгдүүлэх казейн байнга хийхийг эрмэлзэх

ХЭРЭГЖҮҮЛЖ БОЛОХУЙЦ, ТААЛАГДСАН САЙН ЖИШЭЭ

1. Казейныг сайн ойлгуулахын тулд дадлага ажил хийлгэх.
2. Өөрсдөө нь казейны санаа гаргуулан туршуулан үзүүлэх
3. Хэд хэдэн үүргийг зэрэг гүйцэтгэх тоглоом.

19

9/9 Сургалтын эхний хагасын бататгал

1. 9 сарын 8 өдрийг хүртэлх сургалтаар өөрсдийн багын сэдвийн хүрээнд юу сурав.Тулгамдаж буй асуудлууд дээрээ ямар сайн шийдэл олж харав.
2. Үр дүнгийн тайлан бэлтгэхэд анхаарах зааварчилгаа.

Асуудал 1. Компани бүр ямар үйлчилгээ үзүүлж байгаагаас хамаарч тогтсон стандарт байхгүйгээс хэрэглэгчийн сэтгэл ханамжийг хангаж чадахгүй байна.
 Асуудал 2. Хүний ноошийн оролт гаралт ихтэй байдгаас үйлчилгээний стандарт хэвшихгүй байна.
 Асуудал 3. Үйл ажиллагааны процессыг оновчтой зохион байгуулаагүйгээс ажилтны бүтээж муу байна.
 Асуудал 4. Ажлын байрны процесс бүр дээр гарын авлага, сургалт хөгжүүлдэл, хяналт шалгалт тогтворгүй./PDCA/



25

9/10 Ямада Сэйсакушо ХК

СУРЧ, МЭДСЭН ЗҮЙЛ

- Аж үйлдвэрийн тоног тохоромжтой холбоотой бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөдөлмөр хөнгөвчлөх тоног тохоромжийн зураг төсөл гаргадаг компанийн 3S-г бүрэн хэрэгжүүлсэн компани гээд 19 ажилтантай жижиг компани ч гэсэн энэхүү компанитай танилцаж туршлага судлах гэж жилд 191 орчим аж ахуй нэгж ирдэг, Одоогоор 4200 компани энэ үйлдвэртэй танилцсан байна.
- Өглөө бүр 8минуутын булан тохойн нэвэрлэгээ хийнэ. Өглөөний шуурхайгаа компанийхаа үзэл баримтлалаа чангаар уншиж эхлээд Аюулгүй ажиллах тангарагаа өргөж дуусгадаг.
- ISO аваад 12жил болж байгаа хэдий ч өдөрт 1 өгүүлбэр уншиж тухайн шаардлагыг бүгд ойлгож байгаа эсэхийг хэлэлцж хэрхэн хэрэгжүүлэх талаар ярилцдаг.

ХЭРЭГ ЖҮҮЛГЖ БОЛОХУЙЦ, ТААЛАГДСАН САЙН ЖИШЭЭ

1. 8мин Өглөөний булан тохойн нэвэрлэгээ
2. Өглөөний шуурхай болон Аюулгүй ажиллагааны дүрэм бүгд чанга хэлэх.
3. Бараа захиалах болсон гэх тэмдэглэгээ
4. Захиалга өгсөн гэх тэмдэглэгээ
5. Бараа, бүтээгдэхүүний хагт шонгон дээр бүх мэдээлэл орсон.
6. Тоо их дуримтлагдах нэгүүдээ тогтоож багд хуваагдаж нэвэрлэнэ.
7. Заавар Санамжуудыг байрлуулах

29

9/10 Ямада Сэйсакушо ХК




31

9/10 Ямада Сэйсакушо ХК

• 1959 онд байгуулагдсан

- Байгууллагын шинэчлэлийн үед амжилттай нэвтрүүлж, байгууллага догжих үндэс болсон өглөөний шуурхай, 3S хөдөлгөөний хэрэгжлийн байдалтай танилцаж, тус хөдөлгөөний туршлагын үеэс хэвийн байдалд орох хүртэлх бэрхшээл, арга зам, түүний үр дүнгийн талаар лекц
- “Мордох зүйлээ шийдэж, шийдсэн зүйлээ мөрдөгчөө” – Байгууллагын соёл



28

9/12 Үр дүнгийн тайлан танилцуулах, Төгсөлт

1. Цаг баримтлах, Богино хугацаанд товч тодорхой тайлан илтгэл тавих
2. Багийн менежмент



41

9/12 Үр дүнгийн тайлан бэлтгэл

- 4 чиглэлээр баг болон тулгамдаж буй асуудал, түүний шийдлийн талаар санал солилцов.

- Үйлчилгээний стандарт, түүнийг нэвтрүүлэх, хэвшүүлэх




39

2019 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

Нэр: **Н. Дамдиндорж**

Албан тушаал: **Багш**



| | |
|---|---|
| Компанийн нэр: | МУИС Бизнесийн сургууль |
| Байгуулагдсан он: | 1947 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Боловсрол /Сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа/ |
| Ажилчдын тоо: | 164 |
| Компанийн товч танилцуулга | |
| <p>1947 онд анх МУИС-ийн Нийгмийн ухааны хүрээлэнд Улс төр, эдийн засгийн анги нээгдсэн бөгөөд улмаар 2013 онд Бизнесийн сургууль болж бүтцийн өөрчлөлтөнд орсон байна.</p> | |
|  | <p>МУИС-БС нь маркетинг, худалдаа, менежмент, санхүү банк, даатгал, нягтлан бодох бүртгэл, аялал жуулчлалын менежмент, зочлох үйлчилгээ гэсэн бакалаврын өдөр, орой, эчнээ ангийн 8 хөтөлбөр болон магистр, докторын түвшинд сургалт эрдэм шинжилгээний үйл ажиллагаа явуулдаг бөгөөд нийтдээ 164 багш ажилтан, 4000 орчим оюутан ажиллаж, суралцаж байна.</p> <p>Бизнесийн сургууль нь University of LODZ-тай хамтарсан бакалаврын хөтөлбөр, International University of Japan-тай хамтарсан магистрийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаагаас гадна, Англи улсын NCC education-тэй хамтарсан NCC program хамтран хэрэгжүүлж байна.</p> <p>Манай сургууль нь судалгаанд суурилсан сургууль болохын хувьд Innovation and Green Business, Business process analysis and Modeling, Strategic management and Investment, Industrial policy and Planning, Market research гэсэн судалгааны үндсэн багуудад багш нарыг хувааж хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.</p> |

1. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

Борлуулалтыг удирдах, хянах аргачлал

Борлуулалт = Ирсэн зочин * худалдан авалтын хувь * 1 хэрэглэгчийн үнэ

Борлуулалт болон маркетингийн ямар арга хэрэгсэл сонгож хэрэгжүүлэх, хэрхэн борлуулалтыг өсгөж, идэвхжүүлж болох талаар удирдлагад мэдээлэх боломжтой.

Борлуулалт = 1 борлуулагчийн орлого * борлуулагчийн тоо

Ажилтнуудын ажлын үр дүнг үнэлэх, ажилтанд олгох урамшуулал, хөнгөлөлтийг тооцооход шаардлагатай мэдээллээр хангах боломжтой.

Борлуулалт = m^2 тутмын орлого * талбайн хэмжээ

Талбайн зохион байгуулалт мөн цаашлаад давхарын зохион байгуулалтаар орлогыг удирдаж болох мэдээллээр хангах боломжтой загвар юм.

Япон улсын философийн онцлог

Япон улс бусад улстай харьцуулахад хөгжил буурай байх үедээ хөгжингүй орны аливаа зүйлийг өөрийн онцлогт тохируулан нутагшуулах буюу япончлох үйл ажиллагааг маш хурдтай хийж гүйцэтгэсэн байдаг. Үүний хамгийн тод жишээ нь 1868 онд нээлтэй улс болох үед эдийн засаг, шинжлэх ухааны /зэр зэвсэг/ хөгжлийн хувьд бусад улсаас хоцорсон байсан боловч ердөө 60-70 жилийн дотор дэлхийн хөгжингүй улсуудтай байлдах хэмжээний хөгжилд хүрснийг дурьдаж болно. Үүнээс гадна чамин тансагийн оронд энгийн зохимжтой, дэвшилтэд технологи нь уламжлалдаа суурилсан байдаг зэрэг маш олон онцлогууд байна.

3S болон 5S

Хамгийн гол зүйл нь 3S хэрэгжүүлж эхлэх буюу “мөрдөх зүйлээ шийдэж, шийдсэн зүйлээ мөрдөх” бөгөөд нэгэнт эхэлсэн ажлыг цаашид хадгалах нь 5S юм. Үүний тулд захирал, удирдах албан туушаалтнууд идэвх гарган оролцох нь чухал байдаг. Магадгүй зарим тохиолдолд шийдсэн зүйл нь үнэ цэнэгүйдэх эсвэл өөр шаардлага гарч ирэх боломжтой тул тасралтгүй кайзэнийг эрэлхийлж байх хэрэгтэй.

ALL WIN бизнес модел

Бизнес эрхлэгчид энэхүү моделийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж чадвал урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах бөгөөд энэ бизнесд оролцогч талууд бүгд сэтгэл ханамжтай байх юм. Өөрөөр хэлбэл бизнес эрхлэгч та зөвхөн өөрийн ашгийг нэмэгдүүлэх биш, харилцагч нарынхаа ашгийг нэмэгдүүлэхэд санаа тавих гэсэн үзэл санаа юм. Ингэхийн тулд зардлыг бууруулах шаардлагатай бөгөөд түүхий эдийн бэлтгэл үйл ажиллагаа-үйлдвэрлэл-борлуулалтыг компани дангаараа хариуцах юм.

Мүда, түүний төрөл

Мүда гэдэг нь үргүй үйлдэл зардлыг хэлэх бөгөөд нэг үргүй зардал үйлдэл нь өөр нэг үргүй зардал үйлдлийг бий болгож байдаг. Мүда нь дараах хэлбэрээр оршин байдаг. Үүнд:

- Хэтрүүлж үйлдвэрлэсэн

- Гарт байгаа
- Тээвэрлэлтийн
- Боловсруулалтын
- Хөдөлгөөний
- Үлдэгдлийн
- Чанаргүй зүйл үйлдвэрлэх

Үлдэгдлийн мудаг ашиглагдах хугацаагаар нь Амьд-Амарч буй-Үхмэл гэж ангилж болох бөгөөд байгууллагын тухайн хөрөнгийн эргэцээс хамааран хугацаа янз бүр байж болно.

2. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Сургалтнаас сурсан зүйлсээ Бизнесийн сургуулийн багш нарт мэдээлэл хийж, тэдэнтэй санал бодлоо солилцсон бөгөөд сургуулийн үйл ажиллагаа, зөвлөгөө өгч байгаа аж ахуйн нэгж байгууллагад хэрэгжүүлж болох зүйлсийн талаар ярилцаж, боломжтой зүйлсийг хэрэгжүүлэхээр хичээж ажиллана.

3. Сургалтын талаарх сэтгэгдэл, компани хэрэгжүүлж болохуйц жишээ

Сургалт маш сайн зохион байгуулалттай, зохистой дарааллаар явагдсан бөгөөд сургалтанд хамрагдсан бидний хувьд үр дүнтэй сургалт болсон.

Үргүй үйлдэл зардлыг тодорхойлж, ангилах, түүнд тохирох аргыг хэрэгжүүлж, байгууллагад ашиглагдаж байгаа нөөцийг үр ашигтай зарцуулахад чиглэсэн бодлого горимыг боловсруулах нь сургалтаар олсон мэдлэгт тулгуурлах юм.

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга(Компани эсвэл өөрийн бие дээр)

Бизнесийн сургуулийн агуулах дахь үлдэгдлийн мудаг тодорхойлж, хэрэв байгаа бол түүнийг тохирох ангилалаар ангилж /амьд-амарч буй-үхмэл/, зохистой аргаар шийдвэрлэх.

Зөвлөгөө өгч байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд байж болох мудаг тодорхойлж, удирдлагад зөвлөгөө өгч ажиллана гэж бодож байгаа.

5. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Сургалтын агуулга, хөтөлбөртэй урьдчилан сайн танилцаад өөрийн компани болон хувь хүний тал дээр хэрэгжүүлж болох зүйлсийн талаар лавлах зүйлсийн жагсаалт гаргаж сургалтад оролцвол илүү үр дүнтэй байж болох юм.

2019 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

Нэр: **О.Баярмаа**Албан тушаал: **Бизнесийн сургалтын тасгийн мэргэжилтэн**

| | |
|--|--|
| Компанийн нэр: | Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв |
| Байгуулагдсан он: | 2002 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Боловсрол, соёлын үйл ажиллагаа |
| Ажилчдын тоо: | 30 |
| Компанийн товч танилцуулга | |
| <p>Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь Монголын зах зээлийн эдийн засагт хувь нэмэр оруулахуйц хүний нөөцийг хөгжүүлэх Монгол, Япон хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА), Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам болон МУИС-н хамтарсан төсөл хэлбэрээр 2002 оноос үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Одоо бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, япон хэлний боловсрол, хамтын ажиллагаа гэсэн үндсэн үйл ажиллагаа явуулж байна. 2012 оноос япон хэлний боловсрол болоод хоёр орны хамтын ажиллагааны хувьд Япон сантай хамтран ажиллаж байна. Мөн өнөөг хүртэл бий болгосон харилцаа холбоогоо үр дүнтэйгээр ашиглан Япон, Монголын бизнесийн гүүр болон ажиллахыг зорьж байна.</p> | |
| 1. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл | |
| <p>Энэхүү дадлага сургалтад бизнесийн үндсэн сургалтаар суралцсан агуулгыг япон компаниуд хэрхэн хэрэгжүүлж байгаа бодит байдалтай танилцах, япон маягийн менежментийн үндэс болох 5S-ийг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрч болохыг таниулах зорилгоор зохион байгуулж ирсэн. Энэ оны сургалтад хамрагдсанаар дараах зүйлийг түлхүү олж харж, сурч авлаа.</p> <ul style="list-style-type: none"> • Япон маягийн хүн төвтэй менежментийн талаарх ойлголт • Хүний нөөцийн удирдлагын арга барил • 5S хөдөлгөөн, сайжруулалт • Ажлын дэс дараалал, бүтээмжийг дээшлүүлэх арга барил | |
| 2. Сургалтын үр дүн, сэтгэгдэл | |
| <p>Монгол-Японы төвийн бизнесийн үндсэн сургалтын төгсөгч 21 компанийн захирал, менежер болон МУИС, Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн үйлдвэрийн яамны төлөөллийн хамт Япон улсад 14 хоногийн турш дадлага сургалтад хамрагдаад ирлээ. Тус дадлагын хүрээнд Япон улсын нийслэл хот Токиод компанийн менежменттэй танилцах, бизнесийн хамтын ажиллагааны семинарт</p> | |

хамрагдаж, Осака, Кёото хотуудад байрлах үйлдвэр, албан газраар зочлон үйл ажиллагаатай танилцах боломж олдсон юм.



3. Сургалтаар суралцсан, байгууллагадаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

Япон улсад суралцаж төгссөнийхөө хувьд тус улсын нөхцөл байдал, соёл уламжлалыг өөрийн хэмжээнд мэддэг ч энэ удаа өөр өнцөгөөс харахыг хичээлээ. Өнөөг хүртэл оюутан хүний сонирхогчийн өнцгөөс харж байсан бол дадлага сургалтад хамрагдах явцдаа албан байгууллагын менежмент хэрхэн явагддаг, түүнийг хэрхэн төлөвлөж удирддаг, хүнтэй буюу ажилтантайгаа хэрхэн харилцдаг, бага зүйлээс ихийг эхлүүлдэг талаар илүү тод томруун, ойроос харж танилцан, суралцах боломж олдсон юм. Нийт 2 долоо хоногийн хугацаанд олон үйлдвэр, албан байгууллагатай танилцах төлөвлөгөөтэй байсан тул явахын өмнө 2 зүйлийг голлон харж танилцана гэж төлөвлөсөн. Үүнд:

- Япон улс нь хүнээ дээдэлдэг нийгэм. Компани, албан байгууллагууд хүндээ хандсан ямар үйл ажиллагаа явуулдаг талаар илүү түлхүү ажиглалт хийнэ
- Япон улс үйлчилгээгээрээ дэлхийд тэргүүлдэгтэй хэн ч маргахгүй байх. Үүний нууц нь юу вэ? Ямар арга барилаар ажиллаж байна вэ?

Сургалтад явахын өмнө төлөвлөж байсан зүйлсээ бүгдийг нүдээр үзэж бататгаж чадлаа. Өмнө нь зөвхөн гадна талаас нь хардаг байсан бол биднийг хүлээн авч компаниа танилцуулж, сургалт явуулсан компанийн удирдлагуудын өөрийнх нь амнаас сонирхсон асуултандаа хариулт авч чадсан юм. Тиймээс дараах 2 зүйлийг байгууллагадаа хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

1. Шинэ ажилтны сургалт, дасан зохицуулах хөтөлбөртэй болох
2. Монгол-Японы төвийн үйлчилгээний стандарт бий болгох

4. Цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга (Компани, эсвэл өөрийн бие дээр)

Хамгийн гол зүйл нь сурч мэдсэн, мэдэрсэн зүйлээ ажилдаа нэвтрүүлэх нь чухал. Цаашид байгууллагадаа болон өөрийн бие дээр хэрэгжүүлэх зүйлс тус тусдаа бус ижил зүйл байх болно. Өөрөөсөө эхэлж байж тухайн зүйл нь ажил дээр мөн үр дүнгээ өгнө гэж бодож байна. Иймээс өөрийн бие дээрээ дараах зүйлсийг хэвшүүлэхээр зорих болно.

1. Ажлыг эрэмбэ дарааллаар хийх
Олон ажлыг зэрэг хийх нь алдаа доголдол их гарах аюултай. Гаргасан алдаагаа дахин дахин засах нь үр бүтээлгүй бөгөөд урам зоригийг мохоох хор хөнөөлтэй зүйл гэж Осакагийн Технологийн Их Сургуулийн багшийн сургалтын явцад дурдагдаж байв.

2. Эмх цэгцийг бүрдүүлэх

Ажлын байрны эмх цэгцийн тухай сүүлийн жилүүдэд манай улсад ч яригдаж эхлэх болсон. Энгийн, хэний ч хийж чадах зүйл боловч тийм тусмаа эхлэх болон хэвшүүлэхэд хугацаа их шаардагддаг ч хэвшил болсноор ажлын бүтээмж болон урам зориг дээшилдэг давуу талтай.

3. Эерэг хандлагатай байх

Ажлын байрны уур амьсгал нь ажлын бүтээмжтэй шууд хамаардаг. Бие биедээ урам зориг өгч, чадахгүй зүйлд нь туслан, харилцан туслалцан хамтран ажиллах нь Япон орны хөгжлийн бас нэгэн хэсэг болсон болов уу гэж сургалтын явцад харагдаж байлаа.

5. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Юуны өмнө цагийг хатуу баримталж сурсан байх нь бусаддаа болон зохион байгуулж буй хүмүүст төвөг бага учруулна. Мөн, сургалтад явахын өмнө ямар газруудаар очиж танилцах болон тухайн байгууллагын танилцуулгыг урьдчилан өгдөг тул сургалтын материалтайгаа сайтар танилцаж, асуух асуулт, үзэж харах зүйлээ төлөвлөсөн байвал үр дүнтэй.

Бидний сургалтын явцад хэд хэдэн газарт дурдагдаж байсан 一期一会 (ichi go ichi e) гэх Японы зүйр үг бий. Монголоор “Энэ агшин ахин давтагдахгүй тул аливаа зүйлд сэтгэл зүрхнээсээ хандъя” гэсэн утгатай. Бид ажлаар, аяллаар хэзээ ч Япон болон бусад улс оронд очих нөхцөл бүрдсэн нөхцөлд амьдарч байгаа ч тухайн агшин ахин давтагдахгүй учраас ач холбогдол өгч хандах нь юу юунаас илүү чухал санагдаж байна.

Үйлдвэрийн эмх цэгцийн жишээ оруулав



2019 оны Монгол-Японы төвийн Япон дахь дадлага сургалтын тайлан

Нэр: С.Амарбаясгалан

Албан тушаал: Япон хэлний сургалтын тасгийн мэргэжилтэн, багш



| | |
|--------------------------------|---|
| Компанийн нэр: | Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв |
| Байгуулагдсан он: | 2002 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Боловсрол, соёлын үйл ажиллагаа |
| Ажилчдын тоо: | 30 |

Компанийн товч танилцуулга

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь Монголын зах зээлийн эдийн засагт хувь нэмэр оруулахуйц хүний нөөцийг хөгжүүлэх Монгол, Япон хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА), Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам болон МУИС-н хамтарсан төсөл хэлбэрээр 2002 оноос үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Одоо бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, япон хэлний боловсрол, хамтын ажиллагаа гэсэн үндсэн үйл ажиллагаа явуулж байна. 2012 оноос япон хэлний боловсрол болоод хоёр орны хамтын ажиллагааны хувьд Япон сантай хамтран ажиллаж байна. Мөн өнөөг хүртэл бий болгосон харилцаа холбоогоо үр дүнтэйгээр ашиглан Япон, Монголын бизнесийн гүүр болон ажиллахыг зорьж байна.

1. Япон дахь дадлага сургалтаар сурсан зүйл

Тус сургалтаар Япон маягийн менежментийн талаар ойлголттой болж, практик дээр япон компаниуд хэрхэн компаниа удирдан зохион байгуулдаг, цаашлаад байгууллагын амжилтын нууц нь юун дээр тогтдог зэргийг ойлгуулж чадсан үр дүнтэй сургалт болж чадлаа. Үзэж танилцсан зүйл олон ч тэр дундаас дараах 2 зүйлийг онцлон дурдмаар байна.

“АЖИЛТАН”-аа эрхэмлэх буюу CIS=EIS зарчим /Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж = Ажилтны сэтгэл ханамж/

Монголд үйлчлүүлэгэний байгууллагууд “Үйлчлүүлэгч=Хаан” гэсэн зарчмаар үйл ажиллагаа явуулах нь олон. Үйлчлүүлэгчдээ сэтгэл хангалуун байлгах, тэдгээрт чанартай бүтээгдэхүүн,

үйлчилгээг хүргэхийг зорьдог. Тэгвэл японд ч мөн үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхийг зорих үйлчилгээний байгууллагууд олон бөгөөд тэдний нэг болох AP Company ХК дээр бид зочилсон билээ. Тус компаний менежментийн онцлог нь “үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж нь ажилтнуудын сэтгэл ханамжтай шууд холбоотой” гэсэн зарчмыг баримтладаг оршино. Өөрөөр хэлбэл ажилтнууд ажилдаа хэр сэтгэл ханамжтай байна төдий хэрээр үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх боломжтой гэж үздэг байна. Иймд үйлчлүүлэгч хаан гээд ажилтнаа мартаж болохгүй бөгөөд ажилтнууддаа энэ байгууллагыг цогцлооход чухал үүрэг гүйцэтгэж буй эрхэм нэгэн гэдгийг ойлгуулж, бүх шатны ажилтнууд нэгэн зорилгын дор нэгдэж ажиллах боломжийг бүрдүүлэх үүднээс ажилтны сургалт, хөгжлийг чухалд авч үздэг байна. Ингэснээр үйлчлүүлэгчид ч сэтгэл ханамжтай байж, ажилтнууд ч урам зоригоор дүүрэн ажиллах боломжтой гэдгийг ойлгуулсан.

Мөн AP Company ХК болон Aircon Service ХК-ийн “ХҮН” буюу ажилтнаа эрхэмлэн үзэж, тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд санаачлан хийж буй ажлуудаас үзэхэд зөвхөн материаллаг тусламж, дэмжлэгийг ажилтнууддаа олгох нь чухал бус, ажилтнуудыг мотивацжуулахад тэднийг санал, санаачлагыг дэмжиж, тогтмол зөв шударга үнэлгээг явуулж, тэрхүү үнэлгээнд тохирсон урамшууллыг олгож, сурч боловсон, өсөн дэвших боломж олгох нь чухал гэдгийг ойлгосон.

5S КАЙЗЭН үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх нь

Монгол-Японы төв нь 5S Кайзэн үйл ажиллагааг 4 дэх жилдээ хэрэгжүүлж байна. 5S Кайзэн үйл ажиллагаагаар дамжуулан үргүй зардлыг бууруулж, үр ашигтай ажиллахыг зорьж байна. Иймд 5S Кайзэн үйл ажиллагааны өлгий болсон Японы байгууллагадаар зочлохдоо өөрийн байгууллагад хэрэгжүүлж болохуйц санаа олохыг эрэлхийлж явсан билээ. Ийнхүү зорьж явсны үр дүнд дараах зүйлсийг ойлгож авсан.

1. Оосакагийн технологийн их сургуулийн Минагава багшийн хичээлээс: Сайжруулалтыг биелүүлэх эрмэлзлэлээр хийж байж амжилттай хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл ажилтнууддаа хүчээр 5S болон сайжруулалтыг хий гэж тулгах биш, яагаад тэрхүү ажлыг хийх ёстой, тус ажлыг хийснээр байгууллага төдийгүй тухайн хүнд хэр тустай гэдгийг ойлгуулсны үндсэн дээр хэрэгжүүлэх нь чухал. Иймд 5S Кайзэнг хэрэгжүүлэхээс урьтаж байгууллагын “байх ёстой дүр төрх” буюу зорилгоо тодорхой болгож, ажилтан бүр тэрхүү зорилгодоо хүрэх тэмүүлэлтэй байх хэрэгтэй гэдгийг ойлгосон.
2. Ямада Сэйсакүшо ХК болон Kyoto Tool ХК-ууд дээр зочлон: 5S-ийг хэвшүүлэн ажиллахын тулд юуны өмнө эхний 3S буюу Сэйри, Сэйтон, Сэйсо-г ягштал мөрдөх нь чухал. 3S-ийг дадал болгож чадвал ажиллах орчин аяндаа эмх цэгцтэй болж, хамгийн гол нь аюулгүй ажиллах орчин бүрддэг байна.
3. Мөн 5S үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд удирдлагуудын оролцоо чухал гэдгийг Ямада Сэйсакүшо дээр очоод ойлгосон билээ.

Дээрхээс гадна борлуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх болон маркетингийн үр дүнтэй аргууд, үйлчилгээний стандарт, бараа бүтээгдэхүүнийг бренд болгох нь зэрэг олон зүйлийг сурч мэдэн, практик дээр үзэж танилсан билээ.

2. Сургалтын үр дүн, сэтгэгдэл

Тус сургалтад хамрагдсанаар өдийг хүртэл таниж мэддэг байсан япон орны талаарх сэтгэл минь илүү өргөжин тэлж, япон маягийн менежмент, удирдлагын талаар ойлголттой болж чадсан.

Миний бие тус төвд япон хэлний сургалт зохион байгуулах, багшлах, япон хэлний боловсролыг дэмжих зэрэг ажлуудыг хариуцан ажилладаг тул бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх тус сургалтад хамрагдахдаа итгэл муутай байв. Учир нь бизнес, менежментийн талаарх мэргэжлийн түвшний мэдлэггүй байснаас тэр юм. Харин тус сургалтаар япон байгууллагууд дээр зочлон, тэдгээрийн удирдлагуудаас байгууллагын менежментийн онцлог, хүний нөөц хөгжүүлэлт, үйлчилгээний стандарт зэргийн талаар лекц сонсож, практик дээр эдгээрийг явуулснаар байгууллага хэрхэн хөгжиж буйг төвөггүй олж харж чадсан билээ.

Мөн сургалтад хамт оролцсон Монгол байгууллагуудын төлөөлөгчдөөр дамжуулан Монголын компаниудын хөгжил, тэдгээрийн хүчин чармайлтыг харж чадсандаа баяртай байна.

Энэхүү сургалтыг зохион байгуулсан Жайка, Рело Панасоник Интернэйшнл, ПРЕКС-ийн хамт олон болон сургалтад хамрагдах боломжийг олгосон Монгол-Япон төвийн удирдлагууддаа талархал илэрхийлье.

3. Байгууллага дээрээ хэрэгжүүлж болохуйц жишээ, цаашид хэрэгжүүлэхийг хүсч буй үйл ажиллагааны агуулга

Тус сургалтад хамрагдахдаа 5S Кайзэн үйл ажиллагаанд хандах ажилтнуудын хандлагыг сайжруулж, оролцоог хангахын тулд япон байгууллагууд хэрхэн ажиллаж байгааг газар дээр нь танилцан, тасралтгүй, үр дүнтэй 5S Кайзэн үйл ажиллагааны know-how юу болохыг олж мэдэхийг зорьсон билээ. Энэхүү зорилгын хүрээнд тус сургалтаар сурсан зүйлээ ашиглан байгууллага дээрээ үр дүнтэй 5S Кайзэн үйл ажиллагааг амжилттай явуулахын тулд 2020 онд “5S Кайзэн үйл ажиллагааны баг”-т орж, дараах зүйлсийг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

1. 5S Кайзэн үйл ажиллагааны “байх ёстой дүр төрх /зорилго/”-ыг тодорхой болгож, Монгол-Япон төвийг илэрхийлсэн 5S Кайзэн үйл ажиллагааны зорилготой болох. Тус зорилгыг нийт ажилтны оролцоогоор тодорхойлж, ажилтан бүр өөрийн санаачлагаар үйл ажиллагаанд оролцохуйц ажлуудыг төлөвлөн зохион байгуулах.
2. Ажилтнуудад 5S Кайзэн үйл ажиллагааны талаарх ойлголтоо гүнзгийрүүлэх боломжийг олгож тогтмол сургалт зохион байгуулах. Сургалтыг дан ганц лекц хэлбэрээр бус, ажилнууд өөрийн санал санаачлагаа гаргах боломжтой workshop хэлбэрээр зохион байгуулах.
3. 5S Кайзэн үйл ажиллагааны үнэлгээг тогтмол хийх. Үнэлгээг тодорхой шалгуурын үндсэн дээр явуулах нь чухал.

Дээрхээс гадна япон компаниуд болон явсан газруудад анзаарагдсан, өөрийн байгууллага дээр шууд хэрэгжүүлэх боломжтой хэд хэдэн санааг олж харсан.



4. Дараа жилийн сургалтад хамрагдах хүмүүст зориулсан зөвлөгөө, анхааруулах зүйл

Юуны өмнө танд Япон дахь дадлага сургалтад хамрагдах болсонд баяр хүргэе.

Тус сургалт нь Монголд сурч мэдсэн япон менежментийн талаарх ойлголтоо гүнзгийрүүлж, япон байгууллагуудтай танилцах, өөрийн байгууллагын үйл ажиллагааг танилцуулах боломж тул тус боломжийг үр дүнтэй ашиглахын тулд та дараах зүйлсийг сайтар төлөвлөж, судлахийг шаардлагатай гэдгийг анхаарна уу.

- Компани дээрээ тулгамдаж буй асуудлаа оновчтой тодорхойлж, япон байгууллагуудаас сурч мэдэх зүйлээ сайтар тунгаан бодож, төлөвлөх
- Зөвхөн япон байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах бус, өөрийн байгууллагыг ч мөн япон байгууллагуудад харилцан танилцуулж, цаашлаад хамтын ажиллагаа эхлүүлэх боломжтой тул өөрийн байгууллагыг танилцуулахад шаардлагатай зүйлсийг марталгүй бэлтгэн явах.
- Очсон байгууллага бүр өөр өөрийн онцлогтой бөгөөд шинээр сурч мэдэх, санаа авах зүйл олон тул очихоор төлөвлөгдсөн байгууллагуудын талаар судалж мэдэн, асууж тодруулах зүйлээ урьдчилан бэлтгэх
- Сургалтад хамрагдах явцдаа Монгол орон, тэр дундаа өөрийн байгууллагыг төлөөлөн явж буй гэдгийг санан, аливаад хариуцлагатай хандах

Та бүхэнд амжилт хүсье.